

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ

ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО

2025 он

Д/д	Санал ирүүлсэн байгууллага, албан бичгийн дугаар	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх, тайлбар
1.	УЛСЫН ДЭЭД ШҮҮХ 2024.12.27 №1/6198	<p>Таны 2024 оны 1/1868 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн “Авлигын эсрэг багц хуулийн төсөл Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гаргасан саналыг нэгтгэн Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3 дахь заалтад заасны дагуу хавсралтаар хүргүүлэв.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж буй Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл /2024.11.18-ны өдрийн байдлаар/–ийг үзэл баримтлалын хувьд дахин нухацтай авч үзэх шаардлага байгааг дурдан материаллаг болон процессийн эрх зүйн үүднээс дараах саналыг өгөх нь зүйтэй гэж Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас үзлээ.</p> <p>1.Монгол Улс нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцоор хүлээсэн үүргийн дагуу нийтийн албан тушаалтан хууль бусаар хөрөнгөжих үйлдлийг анх 2012 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270- дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болгон хуульчилж, улмаар шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлд уг гэмт хэргийн диспозици болон санкцд өөрчлөлт оруулж, “үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хураах”</p>	<p>Саналыг тусгасан эсэх, тайлбар</p> <p>1.Саналыг тусгаагүй.</p> <p>Тайлбар:</p> <p>Ирүүлсэн саналд дурдсанаар “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” үйлдлийг зөвхөн 2002 он, 2015 оны Эрүүгийн хуульд заасан “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн хүрээнд дурджээ. 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10-т зааснаар “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг нь 100 сая төгрөгөөс дээш хэмжээгээр үндэслэлгүй</p>

	<p>заалтыг нэмж тусгасан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.</p> <p>Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 7.5 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагын нэг төрөлд хамаарах тул эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмын дагуу түүнийг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлох учиртай.</p> <p>Гэтэл Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл /цаашид анхдагч хуулийн төсөл гэх/-ийн үзэл баримтлалд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг тусад нь бие даасан хуулиар зохицуулахаар томъёолсон нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль тогтоомжтой давхардал үүсгэж байна.</p> <p>Тухайлбал, анхдагч хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг илрүүлж, хураан авахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт үйлчлэхээр тусгасан атлаа хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, үүрэг, мөрдөн ажиллагаа явуулах тусгай журмыг хуульчилснаас гадна Иргэний хэргийн анхан шатны шүүх нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх асуудлыг прокурорын гаргасан нэхэмжлэлийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээр тусгажээ.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлана.” гэж заасантай энэхүү анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалт зөрчилдөж байна. Эрүүгийн</p>	<p>хөрөнгөсөн бол тус гэмт хэргийн шинжийг агуулдаг.</p> <p>Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтаас гадна Нийтийн албан тушаалтан үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой дараах хуулийн зохицуулалт байгаа юм.</p> <p>Энэ нь:</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.” Зохицуулалт юм.</p> <p>Гэвч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалт нь аль ч хуульд байхгүй. Мөн үндэслэлгүйгээр нэмэгдсэн 100 сая хүртэл төгрөгийн хөрөнгийг хураан авахад Эрүүгийн журмаар шийдвэрлүүлж хураан авах үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг 100 сая хүртэл хэмжээнийх дээр агуулаагүй тул хэрэгжүүлэх процессыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар явуулах боломжгүй юм.</p> <p>Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй, нийтийн албан тушаал хашиж байх хугацаандаа хууль ёсны хөлс, орлогоос нь давсан хөрөнгөө хууль ёсны</p>
--	--	---

	<p>хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01 дугаартай тогтоолд "...хэрэг хянан шийдвэрлэх нь зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хязгаарлагдана" гэж дүгнэснийг дурдах нь зүйтэй.</p> <p>Иймд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг энэ гэмт хэргийн онцлогт тулгуурлан шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс процессын зарим тусгай зохицуулалтыг шинээр хуульчлах шаардлагатай гэж үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт "Хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явуулах тусгай журам" бүхий дэд бүлгийг шинээр нэмэх боломжтой юм.</p> <p>2.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 29 дүгээр зүйлд нийцүүлэн ердийн гэмт хэргээс уртаар тогтоолгох асуудлыг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хувьд эд хөрөнгө бий болсон үеийг албан тушаал хашиж байсан үед багтаан тогтоох боловч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тухайн албан тушаалыг хашиж буй эсэхээс үл хамааран эд хөрөнгө ил болсон буюу албан тушаалтан эд хөрөнгийг өөрийн эсхүл, хамаарал бүхий хүний эзэмшилд авсан үеэс эхэлж тоолдог.</p> <p>Харин үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байх, эсхүл хэтэрхий урт хугацаагаар тогтоох нь хүн өөрийн шударгаар олж авсан эд хөрөнгийн эх үүсвэрийг нотолж чадахгүйд хүрэх, нотлох боломжгүй болох, ингэснээр хүний эрх зөрчигдөх эрсдэлд хүргэх аюултай болно.</p> <p>Түүнээс гадна 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрөөс дагаж мөрдсөн "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих</p>	<p>дагуу олсон болохыгоо тайлбарлаж чадахгүй байгаа хөрөнгийг хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэж, мөн төр, нийтийн ашиг сонирхол, бусдад учруулсан гэм хорыг арилгуулах зорилгоор нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг гаргуулан улсын орлого болгох буюу хураан авах, нөхөн төлүүлэхтэй холбоотой процессийн зохицуулалтыг Эрүүгийн хуулиас тусад нь процессжуулан хуульчлах нь зүйтэй гэж үзэж төсөл боловсруулсан болно.</p> <p>Эрүүгийн хуулийн 22.10-т заасан "Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон" үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тусад нь хянан шийдвэрлэх юм.</p> <p>Иймд хуулийн төсөл нь Эрүүгийн хууль тогтоомжид хамаарахгүй болно.</p> <p>2.Саналыг тусгаагүй.</p> <p>Эрүүгийн хуульд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь "Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон" байх шинжийг агуулдаг тул албан тушаалтан эд хөрөнгийг өөрийн эсхүл, хамаарал бүхий хүний эзэмшилд авсан үеэс хойш тогтоогдох хүртэл хугацаа алдах, хугацаа шаардагдах эрсдэлтэйг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг 20 жилээр тусгасан болно.</p>
--	--	---

	<p>тухай” хуулийн 6.1-д “Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно.” гэж заасныг анхаарах нь зүйтэй.</p> <p>3.Хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгийг хураах харилцаанд баримтлах эрх зүйн үндсэн эх сурвалжийн нэгээр Иргэний хуулийг нэрлэн заажээ. Гэвч хувийн эрх зүйн үндсэн эх сурвалж болох Иргэний хуулиар энэ төрлийн харилцааг зохицуулах нь эрх зүйн онол, зарчмын хувьд боломжгүй юм.</p> <p>Эд хөрөнгийг хуулийн хүрээнд олж авах, эзэмшилдээ байлгах, үр ашгийг хүртэх замаар хувийн өмчийн эрх найдвартай хамгаалагдах баталгааг Үндсэн хуулиас гадна Иргэний хууль бэхжүүлэн зохицуулдаг бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт субьектив шаардах эрхийн хүрээнд хэрэгждэг. Нийтийн эрх зүйн хүрээнд эд хөрөнгийг хураах, дайчлан авах харилцаа нь хувийн эрх зүйн зохицуулах зүйлд хамаардаггүй онцлогтой.</p> <p>Тодруулбал, иргэд, хуулийн этгээд, эсхүл төр, орон нутгийн субьектив шаардах эрх зөрчигдсөн бол тэдгээр нь өөрсдөө, эсхүл хуулийн хүрээнд эрх бүхий төлөөлөөр дамжуулан зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр иргэний хэргийн шүүхэд хандана. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, эсхүл төр байх аль ч тохиолдолд уг этгээдийн субьектив шаардах эрх зөрчигдсэн, эсхүл хөндөгдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн байхыг хувийн эрх зүйн хэм хэмжээ шаардах бөгөөд энэ ч агуулгаар энэ харилцаанд мөн чанарын хувьд прокурорын оролцоо шаардлагагүй байдаг онцлогтой. Хувийн эрх зүйн харилцаа нь оролцогч хэн байхаас үл хамааран тэгш байдлын хүрээнд өрнөх учиртай.</p> <p>Иргэд, хуулийн этгээдийн хооронд хууль бусаар хөрөнгө шилжсэн, олж авсан гэх үндэслэл байвал ийнхүү хөрөнгө шилжсэнээр хувийн эрх ашиг нь хохирсон этгээд өөрт</p>
<p>3.Саналыг тусгаагүй.</p> <p>Хуулийн төсөлд “хураан авах” гэдгийг “шүүхийн шийдвэрээр хууль бус хөрөнгийг энэ хуульд заасан үндэслэлээр тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчээс гаргуулан улсын орлого болгохыг” ойлгохоор тусгасан бөгөөд тус ойлголтод хөрөнгийг дайчлан авах болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагын агуулга, шинж байхгүй юм. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага нь тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчилд нь эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээлгэх зорилготой.</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах(гаргуулан улсын орлого болгох), нөхөн төлүүлэх нь гэмт, хэрэг зөрчилд нь оногдуулж байгаа ял, шийтгэл биш бөгөөд тодруулбал, нийтийн албан тушаал хашиж байх хугацаандаа хууль бусаар хөрөнгөжиж төр, нийтийн ашиг сонирхол, эрхэд гэм хор учруулснаас үүссэн гэм хорыг арилгуулах зорилготой.</p> <p>Төр, нийтийн зөрчигдсөн ашиг сонирхлыг сэргээх, учруулсан гэм хорыг арилгуулах зорилгоор, албан тушаалаа ашиглан олсон хууль бус хөрөнгийг албан тушаалтнаас гаргуулж, улсын орлого болгох асуудлыг</p>	

	<p>учирсан хохирлоо арилгуулахад хувийн эрх зүй үйлчлэх бөгөөд дээрх хууль бус шилжүүлгийн явцад нийтийн эрх ашиг хохирсон гэж үзэх үндэслэл тогтоогдвол энэ нь иргэний эрх зүйн хэм хэмжээгээр бус нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах харилцаа болно.</p> <p>Иргэний хуулийн дөрөвдүгээр хэсэг, гэрээний бус үүргийн төрөл болох үндэслэлгүй хөрөнгөжих, зөрчлийн улмаас үүсэх үүрэг болох гэм хор учруулснаас үүсэх үүргийн аль ч тохиолдол нь эд хөрөнгөө бусдад үндэслэлгүй шилжүүлсэн, эсхүл эд хөрөнгө, эрүүл мэнд гэх мэт хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд нь гэм хор учирсан тухайн этгээд өөрт олгогдсон субъектив шаардах эрхээ хэрэгжүүлснээр үүснэ.</p> <p>Харин хэн нэгэн этгээд эрх мэдэл, албан тушаалын байдлын урвуулан ашиглах замаар эд хөрөнгө олж авсан нь нийтийн эрх ашигт хохирол учруулсан хууль бус үйлдэл мөн бөгөөд хохирол, гэм хор учирсан тухайн эрх ашиг нь нийтийн эрх ашиг тул энэхүү харилцаанд талуудын тэгш эрх, хуваарилалтын ба солилцооны зүй ёс, гэрээний чөлөөт байдлын зарчмыг санал болгодог хувийн эрх зүйн хэм хэмжээ тохирдоггүй.</p> <p>Түүнчлэн талуудын тэгш байдлын үндсэн дээр үүсэх хувийн эрх зүйн материаллаг хэм хэмжээнээс бий болсон маргааныг хянан шийдвэрлэх механизм ч энэхүү материаллаг харилцаан дахь тэгш байдлын зарчимтай саалшгүй холбоотой. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах үндсэн хоёр зарчимд суурилан хэрэгжинэ. Үүнд:</p> <p>-нэхэмжлэлийн шаардлага, татгалзлын үндэслэлээ өөрсдөө нотлох, тэгш мэтгэлцэх талуудын зарчим,</p> <p>-хэргийн оролцогч нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлох, татгалзах, эвлэрэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан элүүлэх, үргэлжлүүлэх, дуусгавар болгох диспозитив зарчмыг эн тэргүүнд нэрлэж болно.</p> <p>Тодруулбал, хувийн буюу субъектив эрх ашиг нь зөрчилтсөн гэж үзсэн хэн ч болов иргэний шүүхэд хандаж</p>	<p>“нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах” гэж томъёолон тусгасан болно.</p> <p>Мөн Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.4, 9.4.5-д “эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх, учруулсан хохирлыг арилгуулах, эдийн бус гэм хорыг арилгуулах, хуулиар тогтоосон бусад аргаар иргэний эрхийг хамгаална” гэж, 497 дугаар зүйлийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” гэж, 90 дүгээр зүйлийн 90.1-д “Хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь тодорхой байгаа этгээдийг шударга эзэмшигч гэнэ.” гэж, 93 дугаар зүйлийн 93.1-д “93.1.Эд хөрөнгийг хууль ёсны эзэмшигчээс шаардаж болохгүй.” гэж заасан байна.</p> <p>Түүнчлэн одоо мөрдөж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заажээ.</p> <p>Иймд тус процессийг Иргэний шүүхээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй гэж үзсэн болно.</p>	<p>Холбогдогч этгээд шүүхийн шатанд нотлох баримт шинээр нэмж гаргаж өгөх, мэтгэлцэх эрхийг хязгаарлаагүй болно.</p> <p>Улмаар холбогдогч нотлох баримтаа хөрөнгө шалгах ажиллагааны явцад гарган өгөх, зааж өгөх, тайлбар гаргах зэрэг бусад эрх, боломжоор давхар хангаж өгч</p>
--	--	---	--

	<p>эрхээ сэргээлгэх боломжтой боловч шаардах эрхээ хэрэгжүүлэн мэтгэлцэхдээ тэгш боломж олгогдох ёстой. Энэ ч агуулгаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ талуудын хүсэлтэд суурилан оролцогч нэг талын давуу байдлыг илтгэх аливаа мөрдөн шалгалтаас ангид байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эн тэнцүү боломжтой байх зарчимд тулгуурлана.</p> <p>Иргэний шүүх нь талуудад тэгш хандаж, мэтгэлцэх боломжоор ханган өөрөө хөндлөнгийн байх зарчимтай тул цагдаагийн болон прокурорын байгууллагын оролцоотой хэрэгждэггүй. Эдгээр байгууллага нь хэргийн оролцогчийн хувиар өөрсдийн субьектив шаардах эрх нь зөрчигдсөн гэх агуулгаар иргэний хэрэг /хөдөлмөр, гэрээний маргаан г.м/ хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бол бусад оролцогчтой тэгш мэтгэлцэх учиртай. Нэг талын давуу эрхээр, мөрдөн шалгах зарчмаар цуглуулсан нотлох баримт иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талуудын зарчмуудын дор хуульд нийцээгүйд тооцогдож, шүүх үнэлэхгүй байх хууль зүйн үр дагавартай. Иргэний эрх зүйн зөрчлөөс үүсэх маргааны хувьд ч хэргийг хянан шийдвэрлэх дээрх зарчим хөндөгдөхгүй бөгөөд гагцхүү гэм буруугүйгээ хариуцагч өөрөө нотлох үүрэг хүлээдгээрээ гэрээнээс үүсэх маргаанаас ялгагдана.</p> <p>Иймд нийтийн эрх зүйн шинжтэй хэрэг маргааныг мөрдөн шалгах зарчимд суурилан шийдвэрлэх үзэл баримтлал бүхий тус хуулийн төслийн зохицуулах зүйлийг хувийн эрх зүй ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэм хэмжээний үйлчлэлд хамааруулсан нь тулгуур зарчмын зөрчил болохын зэрэгцээ Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, иргэний хэргийн шүүхийн мөн чанарт нийцэхгүй тул ердийн харьяаллын шүүх ийм үзэл баримтлал бүхий хуулийг хэрэгжүүлэхэд онол, практикийн хүндрэл, хүний эрхийн зөрчил үүсэхээр байгааг анхаарвал зохино.</p> <p>4.Анхдагч хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын зарим гэмт хэрэг болон 18 дугаар бүлэгт заасан мөнгө угаах гэмт</p>
	<p>тусгасан. Хөрөнгө шалгах ажиллагаанд төрд давуу эрх байхгүй бөгөөд хууль бус байх магадлалтай хөрөнгийн хууль ёсны эх үүсвэртэй болохыг тайлбарлах, нотлох, өмгөөлөгч авах, хууль зүйн туслалцаа авах, өөрөөр хэлбэл шүүхээс өмнөх шатанд хөрөнгийг хууль ёсны эх үүсвэртэй болохыг тайлбарлах боломжоор холбогдогчийг урьдчилан хангахаар тусгасан.</p>

	<p>хэргийн шинж, энэ төрлийн гэмт хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг ялгамжтай тогтоох агуулгаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн саналууд нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон ФАТФ-ын зөвлөмжид бүрэн нийцээгүй байгааг тэмдэглэж байна.</p> <p>5.Эрүүгийн хуулийн 22.16 дугаар зүйл “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг шинээр томъёолсон нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50.1.29-д заасан шүүгчийн сахилгын зөрчилтэй давхардснаас гадна нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмаар дамжуулан шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгод нийцэхгүй, сахилгын зөрчилд хамаарах хуулиар нэгэнт тогтоосон зан үйлийн хэм хэмжээг эрүүгийн гэмт хэрэг болгож буй үндэслэл, үзэл баримтлал нь тодорхойгүй байна. Ингэснээр шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулах үр дагавартай гэж үзэж байна.</p>
<p>4. Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг байхаар нэмж тусгасан.</p> <p>5.Тус заалт нь шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, аливаа этгээд шүүгчид нөлөөлөхөөр оролдох тохиолдолд шүүгч тухайн нөлөөллийг заавал мэдүүлэх хөшүүрэг болгох зорилготой.</p> <p>Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 45.8-д “Шүүгч энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэж, битүүмжлэн Ерөнхий зөвлөлд ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.” гэж, 45.10-т “Энэ хуулийн 45.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.” гэж заажээ. Тус заалт нь нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй үйлдэлд биш, харин хөтөлсөн нөлөөллийн мэдүүлгийг битүүмжлэн Ерөнхий зөвлөлд 3 хоногийн дотор хүргүүлэх үүргээ зөрчвөл сахилугын шийтгэл оноох агуулгатай гэж үзэхээр байна.</p> <p>Иймд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлийг тодорхой болгон Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.</p>	

	2	<p>ХҮНИЙ ҮНДЭСНИЙ КОМИСС</p> <p>2025.01.03</p> <p>№01/29</p>	<p>Танаас ирүүлсэн Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14.2-т “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн ч болов гэмт буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.”, 14.7-д “Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.”, 15.1-д “Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.” гэж тус тус заасан.</p> <p>Түүнчлэн УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан нь дээрх хуулийн төсөлтэй зарчмын хувьд агуулга ижил байсныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан өдрөөс хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна.</p> <p>Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон</p>	<p>Дараах үндэслэлээр Эрүүгийн хууль тогтоомжид хамааруулахгүйгээр тусдаа процесс гаргаж хуулийн төсөл боловсруулсан болно.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.” гэж заасан.</p> <p>Гэвч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалт нь аль ч хуульд байхгүй. Мөн үндэслэлгүйгээр нэмэгдсэн 100 сая хүртэл төгрөгийн хөрөнгийг хураан авахад Эрүүгийн журмаар шийдвэрлүүлж хураан авах үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг 100 сая хүртэл хэмжээнийх дээр агуулаагүй тул хэрэгжүүлэх процессыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар явуулах боломжгүй юм.</p> <p>Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй, нийтийн албан тушаал хашиж байх хугацаандаа хууль ёсны</p>
--	---	---	--	---

	<p>хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийн бүрэн гүйцэд заасан байх” гэж заажээ.</p> <p>Иймд Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг дэмжихгүй байгаа бөгөөд энэ хуулийн төсөлд зохицуулахаар тусгагдсан “хөрөнгө шалгах ажиллагаа”-ны талаарх болон бусад зохицуулалтыг Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.</p>	<p>хөлс, орлогоос нь давсан хөрөнгөө хууль ёсны дагуу олсон болохыгоо тайлбарлаж чадахгүй байгаа хөрөнгийг хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэж, мөн төр, нийтийн ашиг сонирхол, бусдад учруулсан гэм хорыг арилгуулах зорилгоор нийтийн алба нтушаалтны хууль бус хөрөнгийг гаргуулан улсын орлого болгох буюу хураан авах, нөхөн төлүүлэхтэй холбоотой процессийн зохицуулалтыг Эрүүгийн хуулиас тусад нь процессжуулан хуульчлах нь зүйтэй гэж үзэж төсөл боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөл нь Эрүүгийн хууль тогтоомжид хамаарахгүй болно.</p>
3. МОНГОЛ ЕРӨНХИЙ АУДИТОР 2024.12.17 № 2423	<p>Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаар албан бичигтэй танилцлаа.</p> <p>Тус албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг багц хууль буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар , нөхөн төлүүлэх тухай, Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай анхдагч хуулийн төсөлтэй танилцаж, зарчмын хувьд дэмжиж байгаа болно.</p>	<p>Зарчмын хувьд дэмжсэн.</p>
4. УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР 2024.12.26 №1/60	<p>Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн Авлигын эсрэг багц хуулийн төсөлтэй танилцаад саналаа хавсралтаар хүргүүлэв. Хүлээн авч танилцана уу.</p> <p><u>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд</u></p>	

	<p>1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.2/17.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг” гэсний өмнө “Бусдын” гэж нэмэх.</p> <p>Суурь гэмт хэргийг үйлдсэн этгээдийг тус зүйл хэсгээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага оногдуулах нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 4 лэх хэсэгт заасан “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчимтай нийцэхгүй байх тул гэмт хэргийн субъектийг тодорхой болгох шаардлагатай байна.</p> <p>2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 3/22.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт</p> <p>”Нийтийн албан тушаалтан өөрт итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчлөн найруулах.</p> <p>Тайлбар:-Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад нийтийн албан тушаалтнаас бусад албан тушаалтан итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийг завшсан тохиолдолд оногдуулах хорих ялын хэмжээг 2 жилээс 8 жил хүртэл байхаар хуульчилсан. Иймд нийтийн албан тушаалтанд хөрөнгө завших гэмт хэргийн нийгмийн аюжлын шинж чанар, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-д нийцүүлэн зорчих эрх хязгаарлах болон хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.</p> <p>3.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 1/7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт</p> <p>“3.Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлөх, эсхүл улсын орлого болгож Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь</p>	<p>1.Саналыг тусгасан.</p> <p>2. Хуулийн төслөөс “Нийтийн албан тушаалтан албаны хөрөнгө завших” -тай холбоотой асуудлыг Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн хүрээнд шийдвэрлэж байгааг хэвээр үлдээхээр шийдвэрлэж, төслөөс хассан.</p> <p>3.Саналыг тусгасан.</p>
--	--	--

	<p>хохирол, хор уршгаас илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.” гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар-Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь гэмт хэргийн улмаас бусдад учирсан хохирол болон хор уршгийг арилгах үүрэгтэй тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлд заасан хуулийн зохицуулалттай нийцүүлж хор уршгийн талаар нэмэх нь зүйтэй.</p>	
	<p>4.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “...гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник хэрэгсэл” гэсний дараа “эд хөрөнгө” гэж нэмэх.</p> <p>Тайлбар-Гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдах эд зүйлсийг зөвхөн техник хэрэгслээр хязгаарлах нь учир дутагдалтай байна. тухайлбал, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны хөрөнгө, оорлоготой нийлүүлэх, холих замаар мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн тохиолдол цөөнгүй гарах болсон. Энэ тохиолдолд тухайн хууль ёсны хөрөнгийг ашиглахгүйгээр мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх боломжгүй тул гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан эд зүйл гэж үзэх үндэслэлтэй юм. Иймд зарим төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж буй нөхцөл байдал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтод нийцүүлэн эд хөрөнгө гэсэн ойлголтыг нэмэлтээр хуульчлах шаардлагатай байна.</p>	<p>4.Саналыг тусгасан.</p>
	<p>5.Хуулийн төслийн 3 дугаар зүйл.2/18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...энэ хуулийн 18, 20, 22...” гэсний дараа “24” гэж нэмэх.</p>	<p>5.Саналыг тусгасан.</p>
	<p>6. Хуулийн төслийн 3 дугаар зүйл.2/18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...эсхүл энэ хуулийн 18, 20, 22....” гэсний дараа “24” гэж нэмэх.</p> <p>Тайлбар-Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага FATF-ийн 3 дугаар зөвлөмжид “улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг хамруулж, өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохино” гэж заасан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт</p>	<p>6.Саналыг тусгасан.</p>

	<p>заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, төр, нийтийн ашиг сонирхолд учруулж буй хохирол, хор уршиг зэргийг харгалзан бүхэлд нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болохоор хуульчлах нь зүйтэй байна.</p> <p>7.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. Хуулийн төслийн 3 дугаар зүйл.2/18.6 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт "...29 дүгээр зүйлд..." гэсний зүйл гэснийг хасаж, "бүлэг" гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар-Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүтцэд нийцүүлэн зүйл гэснийг бүлэг болгон өөрлөх шаардлагатай.</p> <p>8.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 4/22.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт "Энэ зүйлд заасан "их хэмжээ" гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгох" гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар-Тус бүлэгт заасан гэж өргөн хүрээтэй хуульчлах нь зарим авлигын гэмт хэргийн нийгмийн аюулын шинжид нийцэхгүй тул зүйл гэж өөрчлөх нь зүйтэй байна.</p> <p><u>Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төсөлд</u></p> <p>9.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн 4.2.2 дахь заалтын "хөрөнгийн үнэлгээг тогтоох" гэснийг "хөрөнгийн үнэлгээг тогтоолгох" гэж өөрчлөх</p> <p>Тайлбар-хөрөнгийн үнэлгээний тухай хуульд зааснаар тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий үнэлгээчин хөрөнгийн үнэлгээ хийх тул түүнд нийцүүлэх шаардлагатай.</p> <p>10.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.8, 5.9, 5.10 дахь хэсэг</p> <p>Хөрөнгө эрхлэн удирдах нэгж хариуцах</p> <p>Тайлбар-Тухайн хэсэгт заасан ажиллагааг хэн хариуцахыг тодорхой болгох.</p>	<p>7.Саналыг тусгасан.</p> <p>8.Саналыг тусгасан.</p> <p>9.Саналыг тусгасан.</p> <p>10.Саналыг тусгасан.</p>
--	---	--

	<p>11. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.17 дахь хэсэг “хариуцагч” гэснийг тодорхой болгож, хуулийн нэр томьёонд нэмж оруулж тодорхойлох.</p> <p>Тайлбар-Хуульд заасан нэр томьёогоор тодорхойлж ойлгомжтой болгох.</p> <p>11.Саналыг тусгасан.</p>	
	<p>12. Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 214.4-д.”</p> <p>Тайлбар- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 214гэсэн зүйл хэсэг байхгүй тус зөвтгөх.</p> <p>13. Хуулийн төслийн 6.4 дэх хэсэг “...мэргэжлийн хяналтын байгууллагын...” гэснийг өөрчлөх.</p> <p>Тайлбар-Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж чиг үүрэг нь бусад байгууллагуудад шилжсэн. Иймд ямар байгууллагын хяналт дор устахыг тодорхой тусгах.</p> <p>Нийтийн албан тушаалтны ихууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл</p> <p>14.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.10-4.1.14 дэх заалт</p> <p>Холбогдох бусад хуулийн нэр томьёотой нийцүүлэн өөрчлөх</p> <p>Салбар хуулиар тодорхойлсон нэр томьёог харилцан адилгүйгээр дахин томьёолох нь хуулийн давхардал, зөрчлийг үүсгэхээр байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д заасан шаардлагад нийцүүлэх.</p> <p>15. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг “Тухайн нийтийн албан тушаалтан байгаа эсэхээс үл хамааран хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг явуулна” гэснийг “Тухайн нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, нас барсан эсэхээс үл хамааран хөрөнгө хураан авах ажиллагааг явуулна.” гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар-Тухайн нийтийн албан тушаалтан байгаа эсэх гэдэг нь ойлгомжгүй, ямар утгыг идэрхийлж байгаа нь</p>	<p>12.Саналыг тусгасан.</p> <p>13.Саналыг тусгасан.</p> <p>14.Саналыг тусгасан.</p> <p>15.Саналыг тусгасан.</p>

	<p>тодорхойгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан шаардлагад нийцүүлэх.</p> <p>16. Хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйл Хоёрдугаар бүлгийн 5,6 дугаар зүйлд заасныг өөрчлөн найруулах.</p> <p>Тайлбар-Төслийн хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйлд заасан зохицуулалтууд нь “зарчим” бус харин хуулийн үйлчлэх хүрээ, хязгаар үндэслэлийг журамласан зохицуулалтууд байх тул өөрчлөн найруулах.</p> <p>17. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг 6.1.10 дахь заалт</p> <p>Тухайн заалт ойлгомжгүй байх тул өөрчлөн найруулах</p> <p>Тайлбар:-Төслийн тус заалт нь ямар утга санааг илэрхийлж байгаа нь ойлгомжгүй байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан шаардлагад нийцүүлэх.</p> <p>18. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “...нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болох...” гэснийг “хууль бус хөрөнгө, орлого олсон болохыг” гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар-Хууль бус хөрөнгө нь зөвхөн нийтийн албан тушаалтны эзэмшил, өмчлөл, ашиглалтад байгаа тохиолдолд түүнийг тогтоож, хураан авах гэж ойлгогдож байх тул өөрчлөн найруулах.</p> <p>19.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг Ямар процесс ажиллагаа явуулсны улмаас холбогдогч болохыг тодорхой болгож, холбогдох зохицуулалтыг нэмэх.</p> <p>Тайлбар: -Хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны аль үе шатнаас нийтийн албан тушаалтан холбогдогч болж, холбогдогчийн эрх үүрэг хүлээх нь ойлгомжгүй байх тул холбогдох зохицуулалтыг нэмэх шаардлагатай.</p> <p>20.Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг</p>	<p>16.Саналыг тусгасан.</p> <p>17.Саналыг тусгасан.</p> <p>18.Саналыг тусгасан.</p> <p>19.Саналыг тусгасан.</p>
--	--	---

	<p>“...бусад оролцогч...” гэсэн тодорхойлолт нэмэх. Тайлбар-Бусад оролцогч гэсэн тодорхойлолт хуулийн төсөлд байхгүй тул нэмэх.</p> <p>21.Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг Тус хэсгийг бүхэлд нь хасах Хөрөнгө шалгах ажиллагааны явцад дээд шатны прокурорын шийдвэртэй холбогдуулан дээд шатны прокурорын газарт гомдол гаргах эрхийг хуульчилснаар мөрдөн шалгах ажиллагаа удаашрах нөхцөл байдал үүснэ. Төсөлд зааснаар хууль бус хөрөнгийг шалгах нийт хугацаа 3 жилээс хэтрэхгүй байхаар буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хугацаанаас харьцангуй бага байхаар заасан нөхцөл байдалтай холбогдуулан төслөөс тус хэсгийг бүхэлд нь хасах.</p> <p>22.Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар хаалттай, хязгаарлалттай мэдээллийн томъёоллыг тусган, өөрчлөн найруулах.</p> <p>23.Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Энэ хэсэгт заасныг хасах. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баримт мэдээллийг нотлох баримтаар тооцох тул хасах нь зүйтэй.</p> <p>24.Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг Тус хэсгийг бүхэлд нь хасах.</p> <p>“Мөрдөгч, прокурор нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогоос давсан хөрөнгийг гэмт хэргийг замаар олсон эсэхийг нотлох үүрэг хүлээхгүй.” гэсэн нь хуулийн төслийн 6.2 дугаар зүйлд заасантай зөрчилдөж байх тул хасах.</p> <p>25. Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь заалтын Б-д “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан” гэснийг хасах.</p>	<p>20.Саналыг тусгасан.</p> <p>21.Саналыг тусгасан.</p> <p>22.Саналыг тусгасан.</p> <p>23.Саналыг тусгасан.</p> <p>24.Саналыг тусгасан.</p>
--	--	---

	<p>Тайлбар-Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн “6.1.Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно.” гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.</p> <p>26. Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь заалтын Д-д “Яллагдагч сураггүй алга болсон” гэснийг хасах Яллагдагч сураггүй алга болсон үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй гэсэн хуулийн зохицуулалт ЭХХШТХ-д байхгүй тул хасах нь зүйтэй.</p> <p>27. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг “...шалгах ажиллагаанд 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна” гэснийг тодорхой болгох Тайлбар-Хууль буцаан хэрэглэх нь эрүүгийн эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрсөн тогтсон ойлголт юм. Төсөлд зааснаар хуулийг буцаан хэрэглэх тохиолдолд дэлгэрэнгүй, нарийвчилсан, хугацааны талаарх үндэслэлийг тусгасан зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай.</p> <p>28. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг “Хөрөнгийн үнэлгээг тухайн үеийн инфляцитай уялдуулан тооцно” гэснийг “Хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тооцно.” гэж өөрчлөх. Тайлбар-Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай. Мөн тус заалт нь “шалгах ажиллагааны хамрах хугацаа” хэсэгт хамааралгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-т заасан шаардлагад нийцүүлж тусгах шаардлагатай.</p>
<p>25. Саналыг тусгаагүй. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулиар авлига, албан тушаалын гэмт хэрэг, Авлигын эсрэг хууль зөрчсөн үйлдлийг хамруулаагүй гэж үзэж тусгаагүй болно.</p> <p>26. Саналыг тусгаагүй.</p> <p>Хөрөнгө шалгах ажиллагааны процесс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа процесс тул хасах шаардлагагүй болно.</p> <p>27. Тус хуулийн төсөл нь эрүүгийн эрх зүйд хамааралгүй тул буцаан хэрэглэх боломжтой юм.</p> <p>Тайлбар, саналыг харгалзан үзэж дэлгэрэнгүй болгох саналыг хүлээн авч дэлгэрүүлэн тусгасан.</p> <p>28. Саналыг тусгасан.</p>	

	<p>29.Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг “...прокурор” гэсний дараа “шүүхийн гэснийг хасах. Тайлбар-Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “шүүх нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийн хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хянан шийдвэрлэхдээ энэ хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан явуулна.” гэж заасантай нийцүүлэх.</p> <p>30.Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг “...цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй..” гэснийг хасах. Тайлбар-хэрхэн ойлгож хэрэглэх нь тодорхой бус байх тул хасах.</p> <p>31.Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг “...маягтыг” гэснийг “эрх зүйн хэлбэрийн загварыг” гэж өөрчлөх. Тайлбар-Шалгах ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхээс үйлдэгдэх эрх зүйн хэлбэр гэж тодорхойлох нь хуульд нийцнэ.</p> <p>32.Хуулийн төслийн 49 дугаар зүйлийн 49.4 дэх хэсэг “...Хөрөнгө шалгах алба..” эсхүл “...нэгж” гэж өөрчлөн нэг мөр болгох. Хуудийн төсөлд шалгах нэгж, алба гэж нэг ойлголтыг хэд хэдэн байдлаар томъёолсон байх тул өөрчлөлт оруулах.</p> <p>33.Хуулийн төслийн 51 дүгээр зүйл Өөрчлөн найруулах. Хөрөнгө шалгах ажиллагааны шийдвэр хэсэгт хөрөнгө тусгаарлах, нэгтгэх зэрэг зохицуулалтыг оруулсан боловч үндэслэл тодорхойгүй байх тул тодорхой болгох шаардлагатай.</p> <p>34.Хуулийн төслийн 52 дугаар зүйл Өөрчлөн найруулах. Хууль бус хөрөнгө өмчлөгч эзэмшигч, холбогдогч нь хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ хялбаршуулсан журмаар</p>	<p>29.Саналыг тусгасан.</p> <p>30.Саналыг тусгасан.</p> <p>31.Саналыг тусгасан.</p> <p>32.Саналыг тусгасан.</p> <p>33.Саналыг тусгаагүй. Үндэслэлийг тодорхой тусгасан болно.</p>
--	--	---

	<p>шалгах ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болно гэж заасан байх боловч прокурорт хүсэлт гаргах талаар тодорхой тусгаагүй байна.</p> <p>35.Хуулийн төслийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг “...дээд шатны прокурор танилцана.” гэснийг хасах. Прокурорын тухай хуульд заасан прокурорын үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим буюу хараат бус байх зарчимд нийцэхгүй тул төслөөс бүхэлд нь хасах нь зүйтэй.</p>	<p>34.Саналыг тусгасан.</p> <p>35.Шалгах ажиллагааг үндэслэлгүйгээр зогсоох эрсдэлийг тооцож тус заалтыг тусгасан болно. Саналыг харгалзан үзэж “танилцана” гэснийг “хянана” гэж өөрчлөн тусгасан.</p>
<p>5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР 2024.12.25 № 01/21180</p>	<p>Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль”, “Түр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль”-ийн төсөл, Авлигын эсрэг хууль болон хологдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн танилцуулга, үзэл баримтлалыг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр ирүүлснийг хүлээн авч, танилцлаа.</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал нь үндэслэл муутай, бодитой, шинжлэх ухаанч байх зарчимд нийцээгүй, бие даасан хараат бус байгууллагын бүрэн эрхэд халдсан, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөхүйц, хуулийн үр дагаврын судалгаа нь шаардлага хангаагүй, хуулийн төслүүд нь Төсвийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох бусад хуультай зөрчилдсөн, агуулгын хувьд давхацсан зэрэг учир дутагдалтай гэж үзэхээр байна.</p>	

		<p>Иймд ирүүлсэн хуулийн төслүүдийг дэмжих боломжгүй, дахин боловсруулах шаардлагатай гэж үзэж байх тул холбогдох саналыг үүгээр хүргүүлж байна.</p> <p>Нэг. “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал”-ын тухайд:</p> <p>1.1 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 1-д:</p> <p>“Монгол Улсад авлигын эсрэг чиглэсэн дараах гол хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль (2006 он); • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он); • Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013 он); • Эрүүгийн хууль (2015 он); • Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он). <p>Эдгээр хуулиуд нь авлигатай тэмцэх гол арга хэрэгсэл болох боловч бодит үр дүн гаргах тал дээр хүндрэлтэй байгааг олон улсын судалгаанууд илэрхийлдэг. Тухайлбал, Монгол Улс “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын 2023 оны Авлигын төсөөллийн индексээр манай улс 180 улсаас 2018 онд 93, 2019 онд 106, 2020 онд 111, 2021 онд 110-т эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 6 байраар ухарч 116-д, 2023 онд өмнөх оны эрэмбээс 5 байраар ухарч 121-д эрэмбэлэгдсэн муу үзүүлэлттэй байна.</p> <p>Манай улс 2006 онд шинэчлэн баталсан Авлигын эсрэг хуулиараа анх удаа авлигатай тэмцэх тусгай</p>	<p>1.1.Саналыг тусгасан. Саналыг хүлээн авч хуулийн төслийн үзэл баримтлалд Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлтийн талаар тусгав.</p>
--	--	---	---

	<p>байгууллага-Авлигатай тэмцэх газрыг байгуулж, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагааг нь явуулж эхэлсэн. Түүнээс хойш 17 жил өнгөрсөн хэдий ч манай улсын авлигын индекс жил ирэх тусам буурсаар байна..." гэжээ.</p> <p>Тайлбар: "Транспэрэнси Интернэшнл" олон улсын байгууллагаас гаргадаг авлигын индексийн үнэлгээнд ялангуяа Монгол Улсын авлигын индексийн үнэлгээ "муу үзүүлэлттэй" гаргахад дээр дурдсан хуулиудын хэрэгжилт нөлөөлж байгаа мэтээр дүгнэсэн нь үндэслэлгүй байна.</p> <p>Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI)" нь шинжилгээгээр мэргэшсэн 12 байгууллагын гаргасан 13 мэдээллийн эх сурвалжийг нэгтгэсэн нийлмэл индекс юм. Улс орнуудын үндсэн мэдээллийн хүртээмж өөр өөр байдаг учраас ашигласан эх сурвалжуудын тоо улс орон бүрд өөр өөр байдаг.</p> <p>Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI) нь</p> <ul style="list-style-type: none">• авлигын бодит тохиолдлыг хэмждэггүй.• институцийн бүтцийг үнэлж дүгнэдэггүй.• авлигын янз бүрийн төрлийг ялгаж салгадаггүй бөгөөд зөвхөн олон нийтийн секторын авлигад анхаарлаа хандуулдаг.• Хууль бус санхүүгийн эргэлт, мөнгө угаах болон хувийн секторын авлигын тухай мэдээллийг агуулдаггүй.• Авлигын талаарх хүмүүсийн ойлголтын үнэлгээ нь улс орон дахь авлигын бодит түвшинг заавал тусгадаггүй болно.• Тухайн улсын Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаа, үр нөлөөг хэмжихгүй. <p>Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI) нь авлигыг зөвхөн макро түвшинд хэмждэг бөгөөд хэмжүүр нь нарийн төвөгтэй, өөрчлөгдөхөд удаан байдаг учраас авлигын эсрэг</p>	
--	---	--

	<p>тодорхой шинэчлэлийн богино хугацааны үр дүнг үнэлэхийн тулд СРГ-г ашиглах нь зохимжгүй байдаг.</p> <p>Дээр дурдсанаас үзэхэд, Авлигын төсөөллийн индексээр үзэлд баримтлалд нэрлэн заасан хуулийн "...хэрэгжилт авлигатай тэмцэхэд бодит үр дүн гаргахад хүндрэлтэй байгаа тухай...", мөн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр авлигын индекс буурч байгаа тухайн дүгнэлт хийх нь үндэслэлгүй юм.</p> <p>Иймд "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал"-ын "Практик үндэслэл, шаардлага"-ыг үнэн зөв, үндэслэлтэйгээр тодорхойлох шаардлагатай байна.</p>	
	<p>1.2.Үзэл баримтлалын "1.2. Практик үндэслэл, шаардлага" хэсгийн 2-т:</p> <p>"Хуулийн хэрэгжилт, хариуцлагын бодлого сул, тодорхой бус, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх процесс удаашралтай, үр дүнгүй, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сул байна." гээд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг "2017-2023" оноор, хохирол нөхөн төлүүлэлтийг "2013-2017" оноор, Аудитын байгууллагын мэдээллийг "2020-2024" оноор гэх мэтээр харилцан адилгүй хугацааг хамааруулан судалгаа мэдээллийг гаргажээ.</p> <p>Тайлбар: Ийнхүү адил бус цаг хугацааны мэдээллийг харьцуулан шинжлэх ухааны үндэслэлгүй, бодитой бус мэдээллийг хуулийн үзэл баримтлалд дурдан үндэслэж байгаа нь ойлгомжгүй төдийгүй хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход учир дутагдатай байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас 2007-2023 онд гэмт хэргийн улмаас учирсан 2 их наяд 804 тэрбум 194 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг царцаах, буцаах зорилгоор гадаад</p>	<p>1.2.Тоон үзүүлэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллүүдийг нэгтгэн үзэж, ирүүлсэн мэдээллийн хүрээнд 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилттэй холбогдуулан 2013 оноос хойш 2015 оны Эрүүгийн хууль мөрдөж эхлэх хугацаа хүртэл гарсан тоон мэдээлэл, 2015 оны Эрүүгийн хууль мөрдөж эхэлснээс хойшхи тоон мэдээллээр ангилж гаргасан нь шинжлэх ухааны үндэслэлгүй, мэдээлэл бодит бус гарах нөхцөл байдалд хүргэхгүй ба байгууллагуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд суурилсан бодит мэдээллүүд гарсан болно.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээллээс үзвэл 2013-2017 онуудад гэмт хэрэг үйлдэж олсон 400 сая төгрөгийн хөрөнгө, орлогыг хураан авсан байна. Энэ нь эдгээр онуудад гарсан албан тушаалын гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 0.1 хувьтай.</p>

	<p>улс орнуудтай идэвхтэй хамтран ажилласнаар 2021-2023 онд гадаад улс орнуудаас 13.9 сая ам. долларын хөрөнгийг буцаан авч, улсын орлого болгосон.</p> <p>2022 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II (Урьдчилан сэргийлэх), V (Хөрөнгө буцаах) бүлгийн хэрэгжилтийг үнэлсэн олон улсын шинжээчдийн багийн зүгээс манай улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, ялангуяа хөрөнгө буцаах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа бусад улс оронд туршлага болохуйц жишиг болж байна хэмээн дүгнэсэн.</p> <p>Иймд “Дээрх тоон мэдээллээс үзвэл гэмт хэрэг үйлдэж олсон буюу шударга бус аргаар олж авсан хөрөнгийг хураан авах бодлого өнгөрсөн жилүүдэд хэрэгжээгүй, өөрөөр хэлбэл гэмт этгээдүүд болон хууль бусаар хөрөнгөжсөн этгээдүүд өдийг хүртэл хууль бусаар олсон хөрөнгөө эзэмшиж, түүнийхээ үр шим ашгийг хүртэж байгаа гэж дүгнэхээр байна.” гэсэн нь үндэслэлгүй дүгнэлт байх тул шинжлэн ухааны үндэслэлтэй, бодитой байх зарчимд тулгуурлах шаардлагатай байна.</p> <p>1.3 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 9-д:</p> <p>“Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь авлигатай үр дүнтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүй Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэлтэй байна. Иймд авлигын гэмт хэрэгт, тодруулбал цагдаагийн байгууллага өөрсдөө илрүүлсэн, эсхүл орон нутагт гарсан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүчин чадлыг ашиглан явуулахаар хуульчлах нь зүйтэй байна.”</p> <p>“Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах харьяаллыг нэмэгдүүлж, мөрдөн шалгах байгууллагад Цагдаагийн байгууллагыг нэмж тусгана. Ингэснээр</p>	<p>битүүмжилсэн хөрөнгийн 0.4 хувьтай тэнцэж байсан.</p> <p>Харин Авлигатай тэмцэх газраас 2013-2017 онуудад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн тухайд эдгээр гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирлын хэмжээ 299,8 тэрбум төгрөг байснаас 20.3 тэрбум төгрөгийн хохирлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ. Мөн эдгээр онуудад Авлигатай тэмцэх газраас 85.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна. Гэтэл эдгээр онуудад шүүхийн шийдвэрээр 400 сая төгрөгийн буюу 0.4 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө орлого хураан авсан мэдээлэл ирүүлсэн болно.</p> <p>Саналыг харгалзан үзэж тоон мэдээллээс бодит нөхцөл байдлыг дүгнэх боломжтой гэж үзэж үзэл баримтлалд зөвхөн тоон мэдээллийг дурдан тусгалаа.</p> <p>1.3.Хуулийн төсөлд саналыг тусгаагүй.</p> <p>Шинэ хуулийн төсөл батлагдан хэрэгжиж эхэлбэл Авлигатай тэмцэх газрын ачаалал нэмэгдэх байдлыг харгалзан нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа болон авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг Цагдаагийн байгууллагын, ялангуяа орон нутаг дахь цагдаагийн хүчин чадлаар нэмэгдүүлэн явуулж авлигатай тэмцэх нь зүйтэй гэж үзсэн болно.</p> <p>Мөн саналыг харгалзан үзэж үзэл баримтлалд практик шаардлагыг өөрчлөн тусгав.</p>
--	---	---

	<p>Цагдаагийн байгууллага Авлигатай тэмцэх газрын ачааллаас хуваалцаж, авлигын эсрэг хүч нэмэгдэх юм.” гэжээ.</p> <p>Тайлбар: Авлигын эсрэг хуулиар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар Авлигатай тэмцэх газар нь ...авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах... чиг үүрэг бүхий хараат бусаар бие даан хэрэгжүүлэхээр хуульчилсан.</p> <p>Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогоо “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгээр тодорхойлж, “Авлигагүй засаглал” буюу “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх Нэгдүгээр үе шат /2020-2030/-нд “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг буурсан байна” гэх үр дүнд хүрэхээр,</p> <p>Монгол Улсын Их хурлаас 2023-2030 онд хэрэгжих “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрт Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна, Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ зэргээр авлигатай тэмцэх бодлогоо тодорхойлсон.</p> <p>Авлигатай тэмцэх газрын МШХ-ийн мөрдөгч орон нутагт байнга суурьшин Авлигын эсрэг хуульд заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байна.</p> <p>Гэтэл Ялангуяа орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүйгээс Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэлтэй байгаа</p>	
--	--	--

	<p>тухай үзэл баримтлалд дурьдсан байх ба “орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэл...”-ийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй, таамагласан байдлаар тусгажээ.</p> <p>Нөгөө талаар УИХ-аас 2025 оны төсвийг хэлэлцэх явцад Цагдаагийн ерөнхий газрын дарга "...Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор бол цагдаагийн байгууллага 6096 орон тоо дутуу байгаа. Ирэх онд 863 орон тоогоо нэмүүлэе гэсэн юм. Дутуу орон тоог задлабал хэсгийн төлөөлөгч 344, эрүүгийн төлөөлөгч 183, хэсгийн байцаагч 226, хүүхдийн байцаагч 234, хэв журмын эргүүл 1422, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч 2588 дутуу байгаа. Энэ тоо бол Засгийн газрын тогтоолд заасан 4000 хүн дутам нэг хэсгийн байцаагч, 50 мянган тутамд нэг хэлтэс байна гэдэг тогтоолоор..." гэжээ.</p> <p>Гэтэл Авлигын эсрэг хуулиар тогтоосон Авлигатай тэмцэх газрын чиг үүргийг цагдаагийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төсөлд тусгасан нь төрөөс баримтлах төрийн бодлоготой зөрчилдөхийн зэрэгцээ, нэгэнт маш олон орон тооны дутагдалтай байгаа цагдаагийн байгууллагаар гүйцэтгүүлэх нь оновчгүй зохицуулалт төдийгүй, авлигын гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах зарчим тодорхой хэмжээгээр алдагдаж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувь буурах, үр дүнгүй болох сөрөг үр дагавартай гэж үзэж байна.</p> <p>Авлигатай үр дүнтэй тэмцэх нь зөвхөн Авлигатай тэмцэх газрын үүрэг бус улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, төрөөс авлигын эсрэг үр дүнтэйгээр тэмцэж, шударга байдлыг төрийн салбарт хэвшүүлж байгаа байдал, хүнд суртал, ил тод байдал, төрийн албан хаагчдын шударга томилгоо, авлигыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль зүйн орчин, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, бизнес, улс төрийн бүлэглэлүүдийн далд ашиг сонирхол, улс төрийн санхүүжилт, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд оногдох хэмжээний өсөлт зэрэг нийгэм, эдийн засаг, эрх зүйн олон хүчин зүйлээс хамааралтай.</p>	
--	---	--

	<p>Үзэл баримтлалд “Авлигатай тэмцэх газар нь улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь сөргөөр нөлөөлж байна.” гэж дүгнэж байгаа нь үндэслэлгүй юм.</p> <p>Иймд таамаглах төдийгээр “Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь авлигатай үр дүнтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлж байна.” гэж ноцтой дүгнэлт хийж, Авлигын эсрэг хуульд заасан чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхээр үзэл баримтлалаа тодорхойлж, зохицуулалтыг холбогдох хуульд тусгахаар төсөл боловсруулсан нь үндэслэлгүй, зохимжгүй байна.</p> <p>1.4 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 9-д:</p> <p>“Дээр дурдсан байдлаас дүгнэвэл авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй байдал... нь цаашид авлигын гэмт хэргийг улам даамжруулах, хяналтаас гаргах өндөр эрсдэлтэй байна.” гэжээ.</p> <p>“13. Авлигын гэмт хэргийн улмаас үүсэн бий болдог дагавар гэмт хэрэг буюу мөнгө угаах, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн шинж хийдэлгүй, тодорхой болно.</p> <p>Авлигын гэмт хэрэг нь нотлогдоогүй хэдий ч нийтийн албан тушаалтан болон түүний “төлөөний хүн” хууль ёсны өөрийн орлогоосоо их хэмжээгээр давсан хөрөнгө, орлогыг хууль ёсоор олсон гэдгээ тайлбарлаж, нотолж чадаагүй тохиолдолд үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзэж Эрүүгийн хариуцлага ногдуулах нь авлигын гэмт хэргийн эсрэг бас нэг томоохон бодлого болох юм.</p> <p>Тайлбар: Үзэл баримтлалд хууль батлах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байгаа, мөн эдгээр гэмт хэргийн шинжийг хуулийн төслүүдэд тусгаагүй хирнээ “авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлно., 13. Авлигын гэмт хэргийн улмаас үүсэн бий болдог дагавар гэмт хэрэг буюу мөнгө угаах, хууль бусаар</p>	<p>1.4.Саналыг тусгасан.</p>
--	---	------------------------------

	<p>хөрөнгөжих гэмт хэргийн шинж хийдэлгүй, тодорхой болно.” гэх мэтээр ямар нэг судалгаа, үндэслэлгүйгээр дээрх байдлаар дүгнэсэн нь ойлгомжгүй, агуулгын зөрөөтэй, учир дутагдалтай байна.</p> <p>1.5 Үзэл баримтлалд хамаарах бусад асуудлын тухайд: Хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, битүүмжлэх, хадгалах, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх асуудал нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, түүнийг дагаж гарсан эрх зүйн актаар бүрэн зохицуулагдсаныг үгүйсгэсэн, огт зохицуулалтгүй байгаа асуудлыг шийдвэрлэж байгаа мэтээр тодорхойлжээ.</p> <p>Эрүүгийн эрх зүйн харилцаанд “хамжигч”, “зуучлагч”-аас гадна “төлөөний хүн” гэх нэр томъёог оруулж ирж байгааг тайлбарлаагүй, энэ нь энэ төрлийн гэмт хэргийн субъект болгож авлига, албан тушаалын гэмт хэргээр шийтгэх нь мөн ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.</p> <p>Хоёр: Хуулийн төслийн танилцуулгын тухайд:</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн талаар танилцуулгад “Хуулийн төслийг боловсруулах явцад Авлигын эсрэг хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр, зарим шаардлагатай судалгааг судлаач болон судалгааны зарим байгууллагаар хийлгэлээ.” гэжээ.</p> <p>Тайлбар: Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс маш богино хугацаанд хийсэн “Авлигын эсрэг хуулийн зарим зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,...-ийн зарим зүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-ний судалгааны тайлангуудтай танилцан х саналыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Өөрөөр хэлбэл, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нь зохих шаардлага хангахгүй, учир дутагдалтай байх тул судалгааны чанар, тайлангийн</p>
	<p>1.5.Саналыг тусгаагүй.</p> <p>Хууль бус буюу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно” гэж тусгаснаас гадна, 7.5 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг зөвхөн тодорхойлох байдлаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг заавал хураах, нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд</p>

	<p>боловруулалтыг сайжруулан, АТҮХ, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зохион байгуулалттай уялдуулан, бүхэлд нь буюу иж бүрэн байдлаар, үнэлгээний аргачлал, судалгааны арга зүйн зохих шаардлагыг ханган гүйцэтгэх саналаа хүргүүлснийг энд дурдах нь зүйтэй.</p> <p><u>Гурав: Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:</u></p> <p>3.1 Төслийн: 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх “9.1 Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар</p> <p>Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.</p> <p>9.3 Авлигын талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллагад гаргах бөгөөд авлигын талаарх нотлох баримтыг хамт хүргүүлж болно.” гэжээ.</p> <p><u>Санал:</u></p> <p>Ø Энэ нь Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий дагнасан байгууллагын эрх зүйн байдлыг дордуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд харьяаллын бус гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэж зохиомол ачаалал үүсгэх, хүн хүч, төсөв зардал нэмэгдэхээс гадна байгууллага хооронд үл ойлголцол үүсэх, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг шилжиж цаг хугацаа ихээр алдах, үзэмжээрээ хандах, хариуцлагын үр нөлөө буурч гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдэд ял завших, хариуцлагаас мултрах үр дагаврыг бий болгох зохицуулалт болсон гэж үзэхээр байна.</p> <p>Ø Дээр дурьдсан 2 хэсгийн агуулга нь хоорондоо зөрчилтэй буюу 9.1-д АТГ, 9.3-т цахимаар Авлигатай</p>	<p>“үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.”-оор тус тус хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй.</p> <p>“Төлөөний хүн”-д гэмт хэргийн хамтран оролцогчоор хариуцлага хүлээлгэхээс гадна, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан болно.</p> <p>3.1.Саналыг тусгасан.</p>
--	--	--

	<p>тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллагад гэж заажээ.</p> <p>Ø Өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар гэж заасан байна. Амаар гэдэгт “утсаар ярих”, “биечлэн ирэх” үйлдэл, “цахимаар” гэдэгт цахим шуудан ашиглах эсхүл албан ёсны цахим сүлжээнд бичих үйлдэл хамаарна.</p> <p>Иймд “9.1 Иргэн, хуулийн этгээд авлигын талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр Авлигатай тэмцэх газарт өгч болно.” гэж өөрчлөх;</p> <p>3.2 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх</p> <p>“9.4 Авлигын талаар мэдээлэл өгсөн этгээд (цаашид “авлигын мэдээлэгч” гэх)-ийг нууцлах бөгөөд авлигын мэдээлэгчийн хувийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр задруулах, бусдад дамжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.” гэжээ.</p> <p>Санал: Авлигын мэдээлэгч гэж хэнийг хэлэх вэ, Авлигатай тэмцэх газарт хандан өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж байгаа бүх хүнийг хамруулахаар заасан байна.</p> <p>Ø “...этгээдийг нууцлах” гэснийг дэлгэрүүлэх. Тухайлбал, нэр, утасны дугаар, ажлын газар, гэрийн хаяг зэрэг түүний ямар мэдээллийг нууцлах талаар дэлгэрэнгүй тусгах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, тухайн этгээдийн мэдээлэл төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийн алинд нь хамаарах, хэрхэн нууцлах, нууцлал ямар байх ёстойг тодорхой болгох, Авлигын талаар мэдээлэл өгсөн этгээдийг өөрөө хүссэн тохиолдолд нууцлах байдлаар тусгах. Өөрөөр хэлбэл, “нэрээ нууцалж шүгэл үлээж болох” эрхийг баталгаажуулах нь зүйтэй.</p>	<p>3.2.Саналыг тусгасан.</p>
--	--	------------------------------

	<p>Ø Мэдээлэл өгч байгаа бүх хүнийг бус “Нийтийн ашиг сонирхлын хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн хууль бус үйлдлийг илчилж, энэ тухай өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх, тайлан гаргах, тайлбар өгөх зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөө авлигын талаарх мэдээлэгч” гэх агуулгыг тусгах, “зайлшгүй шаардлагатай мэдээллийг тодруулах” зорилгоор гэрчээр мэдүүлэг авч болох талаар зохицуулах нь зүйтэй.</p> <p>Ø Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулж шүгэл үлээж болох зохицуулалтыг тусгах.</p>	
	<p>3.3 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх</p> <p>9.5 Авлигын мэдээлэгчийг шаардлагатай тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад авна.</p> <p>Санал: “Авлигын мэдээлэгчийг шаардлагатай тохиолдол” гэсний дор дэлгэрэнгүй тайлбар оруулах шаардлагатай. Тухайлбал, “шаардлагатай тохиолдол” гэдэгт зөвхөн мэдээлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, хамаатан садны амь бие, эрүүл мэндэд эрсдэл учрахыг ойлгох уу? Эсхүл үүнд мэдээлэгч, түүний гэр бүлийн гишүүн, хамаатан садны эрхэлж байгаа ажлын байранд үүссэн гадуурхалт, хөдөлмөрийн таагүй нөхцөл хамаарах уу өөрөөр хэлбэл, хамгаалалтад авах тохиолдлуудыг тодорхой зааж өгөх нь зүйтэй.</p> <p>Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд ажлын байрны дарамт, хөдөлмөрийн нөхцөл дордох зэрэг сөрөг нөлөөллөөс гэрч хохирогчийг хамгаалах зохицуулалт байхгүй тул мэдээлэгчийн хамгаалах тухай асуудал тунхагийн шинжтэй болох эрсдэл үүснэ гэж үзэж байна.</p>	<p>3.3.Саналыг тусгаагүй.</p> <p>Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын хүрээнд хамгаалагдахаар тусгасан.</p>

	<p>3.3 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх</p> <p>9.6.” ... авсан хууль бус хөрөнгийн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн авлигын мэдээлэгчид олгоно.” гэжээ.</p> <p>Санал: Үүнд зөвхөн урамшууллын асуудал яригдаж байгаа нь хангалтгүй гэж үзэж байна. Тухайлбал, мэдээлэгчид мэдээлэл өгснөөс болж, төрөл бүрийн дарамт шахалтад орж, эдийн засаг санхүүгээр хохирсон бол түүний хохирлыг барагдуулах асуудал давхар зохицуулагдах ёстой.</p> <p>Мөн “....үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх” гэж тодорхой тоо заан оруулжээ. Энэ нь албан тушаалтнуудын зүгээс албан үүрэгтэйгээ холбоотойгоор мэдээлэлд ойр байдлаа ашиглаж, холбогдох мэдээллийг гуравдагч этгээдэд өгөх, ашиг хүртэх хэлбэр рүү хууль бус ашиг сонирхлыг нэмэгдүүлэх үр дагавартай зэрэгт анхаарах шаардлагатай.</p> <p>Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад энэхүү хэмжээний талаар ямар нэг тооцоо, судалгаа хийгдсэн талаар дурдагдаагүй байгааг анхаарах.</p> <p>“9.6 ...үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг, хэрэв түүнд мэдээлэл өгсөнтэй холбоотой хохирол учирсан бол тухайн хохирлын хэмжээг тухайн авлигын мэдээлэгчид олгоно.” гэж өөрчлөн найруулах;</p> <p>“9.7 Шүүхийн ерөнхий зөвлөл нь хууль бус хөрөнгө хураан авсан, нөхөн төлүүлсэн, эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ авсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Хөрөнгө эрхлэн удирдах албанд тухай бүр хүргүүлнэ.</p>	<p>3.3.Саналыг тусгаагүй.</p> <p>Бусдын хууль бус үйлдлийн улмаас хохирсон бол хохирлоо хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх зохицуулалттай тул хохирлыг барагдуулах талаар тусгах шаардлагагүй юм.</p>
--	---	--

	<p>9.8 Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 9.7-д заасан шүүхийн шийдвэрийг хүлээн авч, шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс авлигын мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг тооцож, хагас жил тутам Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21-дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Ажлын албанд холбогдох шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хүргүүлнэ.</p> <p>9.9 Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Удирдах зөвлөл нь Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын мэдээлэгчид олгох урамшууллын тооцоог холбогдох шүүхийн шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хянаж, авлигын мэдээлэгчид урамшууллыг олгоно.” гэжээ.</p> <p>Санал: Авлигатай тэмцэх газар шүүхийн шийдвэрийг хүлээн авч, шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс авлигын мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг тооцож олгохоор заасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд тус байгууллагын хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарахааргүй байна.</p> <p>Мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг мөрдөн шалгах ажиллагааны явцад тооцож, олгох шийдвэрийг гагцхүү шүүх гаргадаг байх нь хууль ёсны бөгөөд аливаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл болно.</p> <p>Иймд 9.7, 9.8, 9.9 дэх хэсгийг “...шүүх шийдвэрлэж, ШШГ байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангадаг байх...” зохицуулалтыг тусган өөрчлөн найруулах;</p>	<p>Авлигын мэдээлэгчийн урамшууллыг олгох зохицуулалтын тухайд авлигын мэдээлэгчээс өгсөн мэдээллийн дагуу шалгагдсан хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдэж, хууль бус хөрөнгө орлого, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хурааж улсын орлого болгосон нөхцөлд тухайн мэдээлэгчид тухайн хурааж улсын орлого болгосон хууль бус хөрөнгөнөөс урамшуулал олгохоор зохицуулсан. Үүнтэй холбоотойгоор авлигын мэдээлэгчийн урамшууллыг мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоон тодорхойлох шаардлагагүй болно. Харин шүүхийн шийдвэрийг үндэслэн, авлигын мэдээлэгчийн өгсөн мэдээлэл нь тогтоогдсон байдлыг үндэслэн авлигын талаар мэдээлэл хүлээн авсан АТГ, ЦЕГ урамшууллын тооцоог хийж</p>
--	--	--

	<p>Дөрөв. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай, анхдагч хуулийн төслийн тухайд:</p> <p>Ø Хуулийн төсөл бүхэлдээ хууль бус хөрөнгийг шалгах үндэслэлийг тогтоож, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх, хянан шийдвэрлэх журам, эрх бүхий байгууллагын тогтолцоо, олон улсын хамтын ажиллагаа болон эдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулна гэжээ.</p> <p>Энэ бүх үйл ажиллагаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журмаар зохицуулагддаг.</p> <p>Төсөл нь тухайлсан байгууллагуудын чиг үүргийг давхардуулсан, гажуудуулсан зохицуулалт гэж ойлгогдож байна. Шүүх шүүн таслах, Прокурор хуулийг хэрэгжилтийг хангуулж, шүүхэд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэгтэй байгууллагууд, мөн төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагууд тусгайлсан чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг.</p> <p>Дээрх байгууллагууд дотор тусгайлсан чиг үүрэг бүхий нэгжийг шинээр төлөвлөж бий болгох нь төрийн байгууллага хооронд чиг үүргийн давхардал, хэрэг зөрчлийн харьяаллын маргаан үүсгэсэн, төрийн байгууллагын тоог нэмэгдүүлсэн, оновчгүй, данхар бүтцийг бий болгож төсөв мөнгийг үргүй зарцуулах үр дагаврыг үүсгэхээр байна.</p> <p>Мөн гэм буруутай эсэхийг нь шалгаж шийдвэрлэхэд учруулсан хохирол, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг нэгэн адил гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж гэж тодорхойлж, нотлон тогтоох ажиллагааг хийж гүйцэтгэж байхад чиг үүргийг давхардуулан хөндлөнгөөс дахин өөр мөрдөгч тухайлсан асуудлыг мөрдөн шалгахаар байгаа нь нэг төрлийн хэрэгт 2 өөр мөрдөгч мөрдөн шалгах</p>	<p>байх нь зүйтэй гэж үзсэн тул саналыг тусгаагүй.</p> <p>Мөн авлигын мэдээлэгчийн хуийн мэдээллийг нууцлах шаардлага байгааг энд харгалзан үзсэн болно.</p> <p>Дөрөв.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж хуульчилжээ.</p> <p>Мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.”-оор хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байна.</p> <p>Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэж заасан тул Авлигын эсрэг хуулийн дээр дурдсан заалтыг хэрэгжүүлэх процессыг Зөрчил</p>
--	--	--

	<p>ажиллагааг явуулах нь ойлгомжгүйн дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт хангагдахгүй нөхцөл үүснэ.</p> <p>Төслийн зохицуулалтаас харахад хөрөнгө хураах 7-27 дугаар зүйл, хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа 28-51 дүгээр зүйлд зааснаас үзэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “эрүүгийн процесс”-ын журмаар явагдахаар, төслийн 55-57 дугаар зүйлд Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа” иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар явагдахаар заажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, хууль бус хөрөнгийг шалгах, “үндэслэлгүй хөрөнгө”-ийг буцаан авах ажиллагаа нь 2 өөр процессоор явагдахаар хуульчилсан нь ойлгомжгүй байна.</p> <p>Иймд холбогдох хуулиуд Эрүүгийн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой байна.</p> <p>Ø Төслийн зохицуулалтууд нь хоорондоо зөрчилтэй, ойлгомжгүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн холбогдох зүйл, хэсгийг хуулж тавьсан, огт ойлгомжгүй, хэмжигдэхгүй нэр томьёо хэрэглэсэн (эрх бүхий албан тушаалтан, эвлэрлийн гэрээ, төлөөний хүн, мэдэх ёстой байсан, цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгө гэх мэт) зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангахгүй байна. Тухайлбал,</p> <p>Төслийн 6.2 Нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болохыг энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн шатанд прокурор нотолно.” гэх боловч шүүхээс бусад ямар шатанд хэн нотлох үүрэг хүлээгээд байгаа нь ойлгомжгүй.</p>	<p>шалган шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэх боломжгүй юм.</p> <p>Мөн Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг 100 сая хүртэл хэмжээнийх дээр агуулаагүй тул хэрэгжүүлэх процессийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар явуулах боломжгүй юм.</p> <p>Иймд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх үндэслэл, журмыг эрүү, зөрчлийн процессоос тусдаа процессжуулан хуульчлах нь зүйтэй гэж үзэж энэхүү хуулийн төслийг боловсруулсан болно.</p> <p>Ойлгомжгүй нэр томьёо хэрэглэсэн гэснийг хүлээн авч хуулийн төслөөс эрх бүхий албан тушаалтан, эвлэрлийн гэрээ, цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгө гэх мэт нэр томьёог хассан.</p>
--	--	---

	<p>Төслийн “7.1 Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж заасан хирнээ “10.3-т Мөрдөн шалгах ажиллагааны явцад Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.” гэжээ. Гэтэл АТГ, Тагнуулын байгууллагын албан хаагч Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан албадлага хэрэглэх үндэслэлгүй юм.</p> <p>Ø Хуулийн төслийн 4 дүгээр зүйл: гэмт хэрэг, хөрөнгө, гуравдагч этгээд, хураан авах, нөхөн төлүүлэх, нийтийн албан тушаалтан, хамаарал бүхий этгээд, гэр бүлийн гишүүн гэх мэт бусад хууль тогтоомжоор тодорхойлсон нэр томъёоноос өөрөөр тодорхойлсон нь хууль хэрэглэгчдэд төөрөгдөл, ойлголтын зөрүү үүсгэсэн тодорхойлолт болсон байгааг анхаарч бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай.</p> <p>Ø Хуулийн үйлчлэх хүрээ, хууль бус хөрөнгө шалгах хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийг тогтооходоо:</p> <p>Хуулийн төслийн 3.1 дэх хэсэгт “Энэ хууль нь нийтийн албан тушаалтан холбогдсон, гэмт хэргийн улмаас бий болсон, энэ хуульд заасан хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах үндэслэл байгаа тохиолдолд үйлчилнэ” гээд 7.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ”;</p> <p>Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт “Энэ хууль нь Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураахад нэгэн адил үйлчилнэ” гээд, 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.2-т заасан ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж заасан байна.</p> <p>Уг хуулийн төсөлтэй уялдуулан Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт /“үндэслэлгүйгээр</p>	<p>Хуулийн төслийн 6.2. дээр саналыг тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 7.1 дээр холбогдох өөрчлөлтийг тусгаж саналыг тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр саналыг тусгасан.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж хуульчилжээ.</p> <p>Мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг</p>
--	---	--

	<p>хөрөнгөжих". Тайлбар: Албан тушаалтан 6 сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ/-ын дараа "Тайлбар: "Илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй" гэж тухайн хөрөнгө, орлогоо хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж нотлох баримт гаргаж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгсөн хэдий ч тухайн үйл баримт нотлох баримтаар тогтоогдохгүй байхыг ойлгоно" гэж нэмэхээр хуулийн төслийг боловсруулжээ.</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд "Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8-т заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураах үйл ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ" гэж заасан нь Авлигын эсрэг хуульд заасан авлигын зөрчлийн 2 төрлийг нь /уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан 8 төрлийн зөрчил нь авлигын зөрчилд хамаарна/-ийг мөрдөгч шалгахаар зохицуулсан байх ба энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан "мөрдөгч"-ийн эрх, үүрэг, үйл ажиллагаанд нийцэх эсэхийг тодруулах шаардлагатай.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасан авлигын зөрчлийг ХШДШХ, харин Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд заасан Авлигын гэмт хэргүүдийг Мөрдөн шалгах хэлтэс шалгаж байгаа ба Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн 7.2 дахь хэсэгт нь авлигын зөрчил, авлигын гэмт хэргийн аль алиныг мөрдөгч шалгахаар заасан нь үндэслэлгүй байна.</p> <p>Ø Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогоогүй нь нийтийн албан тушаалтны хууль бус</p>
<p>хүчингүй болгох."-оор хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байна.</p> <p>Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ." гэж заасан тул Авлигын эсрэг хуулийн дээр дурдсан заалтыг хэрэгжүүлэх процессыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэх боломжгүй юм.</p> <p>Мөн Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг 100 сая хүртэл хэмжээнийх дээр агуулаагүй тул хэрэгжүүлэх процессыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар явуулах боломжгүй юм.</p> <p>Иймд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх үндэслэл, журмыг эрүү, зөрчлийн процессоос тусдаа процессжуулан хуульчлахаар төслийг боловсруулсан. Саналыг харгалзан үзэж төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгасан.</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх асуудлыг Авлигын эсрэг хууль дах ХОМ-д дүн шинжилгээ хийх зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжгүй байгаа болно.</p>	

	<p>хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан шударга ёсны зарчим нь Эрүүгийн хуулийн 1.4.1 дүгээр зүйл “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн гэм буруугийн зарчимд нийцэхгүй байх тул өөрчлөх;</p> <p>Ø Хуулийн төслийн 6.1.9. хууль бус хөрөнгө бий болсон цаг хугацааг нийтийн албан тушаалтны албан тушаалын бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн болон албан тушаалын бүрэн эрх, чиг үүрэг дууссанаас хойшхи 10 жилийн хугацаатай заавал хамтатган авч үзэх гэснийг “6 жил хугацаатай заавал хамтатган авч үзэх” гэж өөрчлөх;</p> <p>Ø Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт хөрөнгө шалгах ажиллагааны оролцогчдын эрх хэмжээг заахдаа: Хуулийн төслийн 10.1 дэх хэсэгт “Хөрөнгө шалгах ажиллагааг эрх бүхий мөрдөгч явуулна. Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах мөрдөгч нь дараах эрхтэй” гээд “шалгах ажиллагаа явуулах эрх нээх, прокурорт санал гаргах, зөвшөөрөл авахаар зааснаас бусад тохиолдолд нотлох ажиллагааг бие даан явуулах, шинжээч томилох, прокурорын зөвшөөрлөөр эрх бүхий байгууллагад даалгавар бичиж гүйцэтгүүлэх” гэх зэргээр эрх хэмжээг заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөгчийн эрх хэмжээнээс зарчмын ялгаа бий эсэх, мөн “Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах мөрдөгч”, “Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах хэрэг” гэх зэргээр заасан ойлголтуудад “Хөрөнгө орлогын мэдүүлэг шалгах” ажил ямар хүрээнд хамаарах нь тодорхойгүй байна.</p> <p>Ø Хуулийн төслийн 9 дүгээр зүйл /Прокурорын бүрэн эрх/-ийн 9.1.2-т “Энэ хуульд заасан журмаар ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраар хяналт, дүн шинжилгээ хийлгэх” гэж заасан нь “Хөрөнгө шалгах ажиллагаа”-ны ерөнхий цар хүрээний дотор “Хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт шалгалт”</p>	<p>Саналыг тусгасан. Хуулийн төслийн 5.1--д ирүүлсэн саналыг хүлээн авч өөрчлөн найрууллаа.</p> <p>Хуулийн төслийн 6.1.9.</p> <p>Нийтийн албан тушаал хашиж байх хугацаанд бий болсон хууль бус хөрөнгийг шалгахаар болсон тул саналыг тусгах шаардлагагүй болсон.</p> <p>Хөрөнгө шалгах ажиллагааг явуулахад Зөрчил шалган шийдвэрлэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг тодорхой төрлийн ажиллагаа, процесс шаардлагатай юм. Иймд тохирох ажиллагааг тус хуулийн төсөлд тусгасан болно.</p> <p>Хөрөнгө шалгах ажиллагаа нь хөрөнгө орлогын мэдүүлэг шалгахаас тусдаа явагдана. Хөрөнгө орлогын мэдүүлэг шалгах ажиллагааны зохицуулалт нь одоогийн мөрдөж байгаа Авлигын эсрэг хуулийн хүрээнд зохицуулагдана.</p>
--	--	---

	<p>прокурорын зөвшөөрлөөр явагдах гэх мэт эргэлзээтэй ойлголт үүсгэхээр байна.</p> <p>Тодруулбал, Хуулийн төслийн 6.2-д “нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болохыг энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн шатанд прокурор нотолно” гэж заасан нь Авлигын эсрэг хуулийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5, 13.6 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.</p> <p>Ø Хуулийн төслийн 3.2-т “энэ хууль нь Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон орлогыг хураахад нэгэн адил хамаарна” гэж заасан Авлигын эсрэг хуулийн 33.2-д Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох гэж заасныг зөрчсөн буюу Авлигын эсрэг хуульд заасан шүүгчийн бүрэн эрхэд халдсан заалт гэж үзэхээр байна.</p> <p>Ø Хуулийн төслийн 2.3-т эрүү, иргэний эрх зүйн харилцааг хольж хутгасан, эрүүгийн эрх зүйн харилцаагаар шийдвэрлэгдэх асуудлыг иргэний эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжоор шийдвэрлэх гэж байгаа нь ойлгомжгүй байна</p> <p>Ø Төслийн “5.4 Нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг эрүүгийн журмаар хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураалгүйгээр шийдвэрлэсэн нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг</p>	<p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйл</p> <p>Хөрөнгө орлогын мэдүүлэг шалгах ажил тусдаа тул прокурорын зөвшөөрөл шаардлагагүй, харин хөрөнгө шалгах ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд прокурор холбогдогчоос ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраар хяналт, дүн шинжилгээ хийлгэх бүрэн эрхтэй байх зохицуулалт юм. Саналыг харгалзан үзэж зохих өөрчлөлтийг оруулсан. Мөн Авлигын эсрэг хуулийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5, 13.6 дахь хэсэгтэй зөрчилдөх зүйлгүй болно.</p> <p>Хуулийн төслийн 3.2</p> <p>Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.”-оор тус тус хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байгаа тул тус заалтыг хэрэгжүүлэх процессын зохицуулалт бүхий хуулийн төсөл болно.</p> <p>Хуулийн төсөл нь Эрүүгийн хууль тогтоомжид хамаарахгүй тусдаа процессын зохицуулалт юм. Тус хуулийн төсөлд эрүүгийн хэргийг</p>
--	--	---

	<p>явуулах үндэслэл болно. "Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д ".....гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцож үл болно" гэсэн заасан. Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдоогүй нөхцөлд хөрөнгийг хууль бусаар олсон гэж тооцож хураан авах, хадгалах, захиран зарцуулах асуудлыг төсөлд тусгасан нь хүний хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулаад зогсохгүй, нигилизм үүсэх үр дагаврыг үүсгэж болзошгүй юм.</p> <p>Ø Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэсэн тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн 22.10 зүйл 1 дэх хэсэгт " хөрөнгө, орлого нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол гэх агуулгад нийцүүлэх.</p> <p>Ø Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид дараах байдлаар тодорхойлсныг анхаарах.</p> <p><u>Тав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:</u></p> <p><u>5.1 Төслийн "1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:"</u></p> <p>21.1 Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:</p> <p>21.1.1 авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд 30 хувийг;</p> <p>21.1.2 мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 50 хувийг;</p> <p>21.1.3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24-т заасан "Хүүхдийн төлөө сан"-гийн зарим үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 20 хувийг."</p>	<p>Иргэний журмаар шийдвэрлэх зохицуулалт байхгүй болно.</p> <p>Төслийн 5.4 Саналыг тусгасан.</p> <p>Эрүүгийн хууль дахь Хууль бусаар хөрөнгөжих гэсэн тодорхойлолтыг дахин томъёолж саналыг тусгалаа.</p> <p>5.1. Саналыг тусгасан.</p>
--	---	--

	<p>21.3 Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараах 3 үзүүлэлтийн дундаж хувь хэмжээг харгалзан энэ хуулийн 21.1.2-т заасан хувь хэмжээнээс хуваарилан олгоно:</p> <p>21.3.1 улсын хэмжээнд гарсан нийт гэмт хэрэгт эзэлж байгаа тухайн байгууллагын илрүүлсэн болон таслан зогсоосон гэмт хэргийн хувь хэмжээ;</p> <p>21.3.2 тухайн байгууллагын илрүүлсэн нийт гэмт хэрэгт шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ;</p> <p>21.3 гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон шүүхийн шийдвэртэй хэргийн эзлэх хувь хэмжээ.</p> <p>Энэ санд зөвхөн авлигын гэмт хэргийн улмаас нөхөн төлүүлсэн, хураан авсан хөрөнгийг төвлөрүүлэх үү? Үгүй бол бусад төрлийн гэмт хэргийн мэдээлэгчийг ч нэгэн адил урамшуулах эсэх нь тодорхойгүй байна.</p> <p>Гэтэл Авлигын эсрэг хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1/-ийн "9.6 Авлигын мэдээлэгчээс өгсөн тухайн мэдээлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар нотлогдож, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд хураан авсан хууль бус хөрөнгийн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн авлигын мэдээлэгчид олгоно." гэжээ.</p> <p>5.2 Төслийн 21.3.2 дахь хэсгийг "Тухайн байгууллагын илрүүлсэн нийт гэмт хэрэгт хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолтой гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ" гэж өөрчлөх;</p> <p>5.3 Төслийн 21.3.3 дахь хэсгийг "гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон хүчин төгөлдөр шүүхийн</p>	
--	--	--

	<p>шийтгэх тогтоолтой хэргийн эзлэх хувь хэмжээ гэж өөрчлөх;</p> <p>5.4 Төслийн 21.4.1 дэх хэсэгт “хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ, тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шийтгэх тогтоол /Магадлал, тогтоол/-ын тоо мэдээ” гэж өөрчлөх;</p> <p>5.5 Төслийн 21.4.6-д мөрдөн шалгахад үр бүтээлтэй ажилласан ажилтанд байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр олгоно гэх заалт шаардлагатай эсэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий төрийн тусгай байгууллагын алба хаагч, төрийн тусгай байгууллагад ажилласны нэмэгдлийг цалин дээрээ авч тангараг өргөж ажилладаг. Хэт мөнгөний араас хөөцөлдөх асуудал гарч нөгөө талдаа сөрөг үр дагавар үүсгэх боломжтойг нөгөө талаар өмнөх сангуудын алдаа, оноонд тулгуурлан үйл ажиллагааг нь олон нийтэд нээлттэй байдлаар байлгаж, хяналтын тогтолцоог хөндлөнгийн төлөөллөөр хэрэгжүүлэх, удирдах зөвлөлийг хараат бус байдлаар сонгон шалгаруулж үр дүнг тооцдог байхад анхаарах нь зүйтэй.</p> <p>5.6 Төсөлд ““гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон хөрөнгийн 1-ээс доошгүй хувийг авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд зарцуулна” гэсэн агуулга бүхий заалтыг нэмэх;</p> <p>5.7 Төслийн 21.4 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3, 21.3, 21.4, 21.12, 21.14, 21.18-д заасан зохицуулалт нь Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан зохицуулалттай давхар буюу ямарч өөрчлөлтгүйгээр хуулж тавьсан. Өөрөөр хэлбэл, Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн</p>	<p>5.2.Тус заалт хасагдсан тул саналыг тусгах шаардлагагүй болсон болно.</p> <p>5.3.Тус заалт хасагдсан тул саналыг тусгах шаардлагагүй болсон болно.</p> <p>5.4.Тус заалт хасагдсан тул саналыг тусгах шаардлагагүй болсон болно.</p> <p>5.5.Тус заалт хасагдсан тул саналыг тусгах шаардлагагүй болсон болно.</p> <p>5.6.Тус заалт хасагдсан тул саналыг тусгах шаардлагагүй болсон болно.</p>
--	---	--

	<p>удирдах тухай хуулийн төслийн гуравдугаар бүлэгт заасан агуулга бүхэлдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй давхардсан байгааг сайтар нягтлах шаардлагатай.</p> <p>5.8 Төслийн 21 дүгээр зүйлийн 21.14-т "... хуулийн 25.5-д заасан хяналтын хороо хяналт тавих бөгөөд ..." гэсэн нь Засгийн газрын тусгай сангийн уг зохицуулалттай нийцээгүй. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.2.18-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана."/хуулийн зүйл, хэсэг, заалт ишилсэн хэсэгт "Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сан"-д холбогдох зүйл, хэсэг заалт байхгүй;</p> <p>5.9 Төсөлд сангийн эх үүсвэрийн талаарх зохицуулалт тусгагдаагүй зэрэг болно.</p> <p>Зургаа. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:</p> <p>6.1 Төслийн 21.5-д: Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаа гэмт хэргийн шинжтэй тохиолдолд төлбөрийн акт тогтоох, албан шаардлага үйлдэхгүйгээр аудитыг нэн даруй зогсоож энэ тухай Ерөнхий аудиторт мэдэгдэж, холбогдох материалыг шилжүүлнэ гэж заажээ. Холбогдох материалыг хааш нь шилжүүлэх вэ? Ерөнхий аудитор ямар арга хэмжээг авах, хугацаа зааж өгөх нь зүйтэй. Эсхүл нэн даруй холбогдох хууль хяналтын байгууллагад өгч шалгуулах. Эргээд хүргүүлсэн материалыг хүрээнд ямар арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн талаар эргэх холбоог үүрэг болгосон хэлбэрээр тусгаж өгөх, хэрэгжилтийг тооцож ажиллах шаардлагатай. Ингээгүйгээс албан тушаалтнууд гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгахгүйгээр дарагдуулах, бусдад давуу</p>	<p>5.7.Саналыг тусгасан.</p> <p>5.8.Саналыг тусгасан.</p> <p>5.9.Саналыг тусгасан.</p> <p>6.1.Саналыг тусгасан.</p>
--	--	---

	байдал бий болгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ял завшуулах нөхцөл үүсгэдэг.	
	<p>6.2 Төслийн 28.1-д: Ерөнхий аудиторыг 9 жилээр томилох гэснийг 6 жилийн хугацаагаар гэж өөрчлөх</p> <p><u>Долоо. Түр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн тухайд:</u></p> <p>7.1 Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд уг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулна” гэснийг Удирдах зөвлөлийн нийт бүрэлдэхүүний тоог тодорхой заах.</p> <p>7.2 Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай, анхдагч хуулийн төслийн 21-дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3, 21.4, 21.12, 21.14, 21.18-д заасан зохицуулалт нь Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан зохицуулалттай давхар буюу ямарч өөрчлөлтгүйгээр хуулж тавьсан. Өөрөөр хэлбэл, Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн гуравдугаар бүлэгт заасан агуулга бүхэлдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй давхардсан байгааг сайтар нягтлах шаардлагатай.</p> <p>Найм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлагатай. Үндэслэлийг хуулийн үзэл баримтлалд тодорхой дурдсан болно.</p> <p><u>Ес. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:</u></p>	<p>6.2.Саналыг тусгаагүй.</p> <p>7.1.Саналыг тусгасан.</p> <p>7.2.Саналыг тусгасан.</p>

	<p>9.1.Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт хэргээс олсон орлогыг хөрвүүлэх, шилжүүлэх, эзэмших, нуун дарагдуулах үйлдлийг Мөнгө угаах гэмт хэрэг гэж тодорхойлдог. Мөнгө угаах гэмт хэргийг Улс төрд нөлөө бүхий этгээд, нийтийн албан тушаалтан, гэмт бүлэглэл, хуулийн этгээдийг ашиглан (цэвэр хөрөнгө буюу хууль ёсны хөрөнгө, мөнгө орлогоотой хольсон mingling), Халхавч компаниуд /корпорациудыг/ ашиглах, ашиглан үйлдсэн, санхүү, хуулийн нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор үйлдсэн, гадаад улсад хөрөнгө, мөнгө орлогыг шилжүүлэн угаасан бол хүндрүүлэх шаардлагатай.</p> <p>Өнөөдрийн байдлаар өөрөө мөнгө угаах <i>Self laundering</i>, хүндрүүлэх шинжүүдийг ялган гэмт хэрэгт тооцоогүй, энэхүү шинжүүдийг тодорхойлоогүй байдлаас үүдэн мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хүмүүс ял завших үр дагавар үүсгэж байна. Иймд:</p> <ul style="list-style-type: none"> Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нь өөрчилсөн, шилжүүлсэн нуун далдалсан бол. /Өөрөө угаах/ албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол галт зэвсэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бус эргэлт, Хүн хулгайлах, барьцаалах, бэлгийн мөлжлөг, хүний цус эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэрэг болон эрүүгийн хуулийн 18, 22, 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг угаасан бол
<p>Найм. Саналыг тусгаагүй. Үндэслэлийг үзэл баримтлалд тодорхой дурдсан болно.</p> <p>9.1.Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн тодорхойлж, виртуал хөрөнгө ашиглаж, хуулийн этгээдийг халхавчлаар ашиглаж, үндэстэн дамнаж, албаны чиг үүрэг, бүрэн эрхийг ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэхээр төсөлд тусгасан тул саналыг аваагүй.</p> <p>Өөрөө болон бусдын үйлдэж олсон хөрөнгө, орлогыг угаах үйлдлийг ялгамжтай байдлаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Хуулийн төсөлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг өөрөө угаах үйлдлийг тусгасан тул саналыг аваагүй.</p> <p>Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг суурь гэмт хэрэгт тооцох саналыг хүлээн авч, хуулийн төсөлд тусгасан. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших (Эрүүгийн хуулийн 20.4 дүгээр зүйл), Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх (Эрүүгийн хуулийн 20.5 дугаар зүйл), мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл)-д заасан гэмт хэргүүд бүлгээрээ мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт хамаарч байгаа учраас саналыг аваагүй болно.</p>	

	<p>• энэ гэмт хэргийг үндэстэн дамнаж үйлдсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн, гэмт бүлэглэл, улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол гэсэн үйлдлүүдийг тусгах;</p> <p>9.2 Төслийн 1 дүгээр зүйлийн “3/ 22.14 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хөрөнгө завших” гэмт хэргийг “Авлигын гэмт хэрэг”-ийн бүлэгт оруулахаар тусгасан нь оновчгүй бөгөөд энэхүү гэмт хэрэг нь авлигын гэмт хэргийн шинжийг агуулахгүй байна. Иймд тус зүйлийг хасах;</p> <p>9.3 Төслийн 1 дүгээр зүйлийн “3/ 22.15 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах-Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн “Хорин гуравдугаар бүлэг”, “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-ийн бүлэгт дараах байдлаар хуульчлагдсаныг хэвээр үлдээх. Саналыг дэмжихгүй.</p>	<p>9.2.Саналыг тусгаж, төслөөс хассан.</p> <p>9.3.Саналыг тусгаагүй. Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэрэг нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг хэдий ч энэ гэмт хэргийн субъектив талын шинжид гэм буруугийн хэлбэрийг тодорхой зааж өгөөгүйн улмаас практикт хайнга хандах гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (22.1) гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна. Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлд албан тушаалын гэмт хэрэгт бүлэгт хуульчилж байсан уламжлал, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын</p>
	<p>Арав. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:</p>	

	<p>10.1 Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн анхдагч төсөлд тусгагдсан нэр томъёог энэхүү төсөлд тусгаснаар батлах бол Иргэний хуулийн 497-д дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан үндэслэлийг өөрчлөн найруулах шаардлагатай байна.</p>	<p>Эрүүгийн хуульд хайнга хандах гэмт хэргийг авлига, албан тушаалын гэмт хэргийн бүлэгт хуульчилсан туршлага, энэ төрлийн гэмт хэргийн онцлог, нийтийн албан тушаалтан ихэвчлэн үйлддэг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хуульчлах шаардлагатай болно.</p> <p>10.1 Саналыг тусгаж өөрчлөн найруулсан.</p>
<p>6. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ 2024.12.19 №1/2203</p>	<p>Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаар албан бичгийг хүлээн авч танилцлаа.</p> <p>Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөлд шүүх, шүүхийн Тамгын газраас ирүүлсэн саналыг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.</p> <p>Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төсөлд шүүх, шүүхийн Тамгын газраас ирүүлсэн саналын нэгтгэл</p> <p>1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 3–5 дахь хэсэг</p> <p>1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, хөрөнгө, орлого, зэвсэг хэрэгсэл, машин механизм, (уг эд хөрөнгийг захиран зарцуулсан бол үнийг) заавал хурааж улсын орлогод оруулахаар нэг бүрчлэн заах.</p>	<p>1.Саналыг хүлээн авч, төсөлд тусгасан.</p>

	<p>2.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 7.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан заалтууд хэрэглэхэд маш эргэлзээ дагуулан өмгөөлөгч болон гэм буруутай этгээдүүд нь энэ ойлгомжгүй заалт дээр (хуулийн хийдэл дээр) тоглолт хийж дараа дараагийн шатанд шүүхийн шийтгэх тогтоол гэм буруутай этгээдэд ашигтай байдлаар тайлбарлаж шүүхүүд өөр хоорондоо хэрэглэж байгаа завхралыг засах.</p> <p>3.2002 оны Эрүүгийн хуулийн 49 дүгээр заалтыг эргүүлэн дахин хийх. Маш ойлгомжтой хэрэглэхэд ямар ч эргэлзээ төрдөггүй байсан. гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хамгаалалтыг ... даруй хамгаалалтын арга хэмжээ авахыг хатуу заалтаар оруулж, баримтжуулах, хэрэгжих, хариуцлага чангатгах, боловсронгуй болгох.</p> <p>4.Авлига авсан албан тушаалтан нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих Эрүүгийн хуульд эд хөрөнгийг хураах, улсад хөрөнгө болгохыг нэмэгдэл ялаар заавал оруулах, зүйл, хэсэг тус бүрд нь заах.</p> <p>5.Эрүүгийн эрх зүйд авлига, албан тушаал, үндэслэлгүй хөрөнгөжих, залилах гэмт хэрэгт гэм буруутай этгээдэд оногдох хөрөнгө гэдэг ойлголтыг хасах замаар, хөрөнгөө нуун дарагдуулах байдлыг зогсоох.</p> <p>6.Хөрөнгө хураах ялтай гэмт хэргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлыг тусгайлсан зохицуулалттай, хяналт хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох.</p> <p>7.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын шилжсэн бол эд хөрөнгийг үнэлж, хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх, мэдсээр байж авсан бол хэлцлийг хүчингүйд тооцож хураан авах, хохирлыг</p>	<p>2.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-5 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар төсөлд тусгасан.</p> <p>3.2002 оны Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасан агуулгыг төсөлд тусгасан.</p> <p>4.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ байгаа учраас хөрөнгө хураах нэмэгдэл ял хуульчлах шаардлагагүй гэж үзсэн учир саналыг хүлээн аваагүй.</p> <p>5.Санал ойлгомжгүй учраас хүлээн аваагүй.</p> <p>6.Хуулийн төсөлд хамаарахгүй санал байна.</p> <p>7.Энэ агуулга хуулийн төсөлд тусгагдсан.</p>
--	--	---

	<p>нөхөн төлүүлэх.</p> <p>Тайлбар</p> <p>Эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжид хүргэсэн хуульд заасан үндэслэл бий болсон эсэхийг үл харгалзан гэм буруутай эсэхийг тогтоох, ял шийтгэл ногдуулах асуудлыг хөндөхгүйгээр гэмт хэргийн улмаас олсон орлого, хууль бус орлогыг хураан авах, нөхөн төлөх бодлогыг хэрэгжүүлэх механизм буюу эрх зүйн тодорхой зохицуулалтыг холбогдох хуульд нэн даруй хийх шаардлагатай байна.</p> <p>2.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн 12 дугаар зүйл.</p> <p>12 дугаар зүйлийн 12.1.5 тайлбар өгөхөөс татгалзах гэснийг хасах.</p> <p>Тайлбар</p> <p>Учир нь, Тайлбар өгөхөөс татгалзах нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулна. Тайлбар өгөх үүрэгтэй зөрчилдөж байна.</p> <p>3.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн нэрийг “Төрийн албан хаагчийн хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх” тухай хууль гэж өөрчлөх.</p> <p>Тайлбар:</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан</p>	<p>2.Саналыг хүлээн авч, төсөлд тусгасан.</p> <p>3.Хуулийн төслийн нэрийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-тай уялдуулсан.</p>
--	---	--

	<p>сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4."нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1--д заасан этгээдийг;</p> <p>Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:</p> <p>Эдгээр хуулийн заалтуудад хамаарах субъектээс гадна төрийн бусад албан хаагчид хууль бусаар хөрөнгөжих асуудал гарч байгаа тул бүх төрийн албан хаагчдыг хамруулах шаардлагатай гэж үзэж байна.</p>	<p>сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4."нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1--д заасан этгээдийг;</p>
<p>7</p> <p>МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБОО</p> <p>2024.12.26</p> <p>№01/1357</p>	<p>Нийтийн албан тушаалтнууд хууль бусаар хөрөнгөжихтэй тэмцэх хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулах талаар төрөөс явуулж байгаа бодлого, зорилго, үйл ажиллагааг дэмжиж байна. Эл зорилгод хүрэхийн тулд эрх зүйн оновчтой шийдэл, зөв зохицуулалт шаардлагатай.</p> <p>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төсөлд холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.</p> <p>1.Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж, Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө болох "өмчлөх эрх"-ийг хязгаарлалт буюу хөрөнгө хураан авах үндэслэл нь зөвхөн гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдсон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байна.</p>	<p>1.Саналыг тусгаагүй.</p> <p>Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулийг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж, Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй" гэж тунхагласан. Иймд хууль бус хөрөнгө орлогыг тусгайлсан хууль гаргаж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар хураан авах нь эрх зүйн үндэстэй юм.</p> <p>2.Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураах үндэслэлийг хэрэгжүүлэх, мөн нийтийн албан тушаалтан холбогдсон, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хянан хэлэлцсэн шүүхийн шийтгэх тогтоолоор тухайн нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдийн хууль бус хөрөнгийг нь хураагаагүй, эсхүл</p>

	<p>Тиймээс хөрөнгө олж авсан үйлдлийг гэмт хэрэг гэж тогтоогоогүй, тухайн үйлдэлдээ гэм буруутайд тооцогдоогүй нөхцөлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хүний хөрөнгийг хураан авах нь Үндсэн хуулийн зөрчил болно.</p> <p>2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийг шалган шийдвэрлэх хүрээнд тухайн албан тушаалтны хөрөнгө хууль бус эсэх нь шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд уг бүлэгт заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан “хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-г хэрэглэх үндэслэл, журмыг дэлгэрүүлэн зохицуулах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.</p> <p>Өөрөөр хэлбэл, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд тусгасан материаллаг зохицуулалтыг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд дэлгэрүүлэн томьёолох, процессын зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давхардалгүйгээр тусгах байдлаар шийдвэрлэх саналтай байна.</p> <p>3.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслөөр эрүүгийн эрх зүйд “төлөөний хүн” гэх шинэ нэр томьёо нэвтрүүлэхээр тусгасан байна. Нийтийн албан тушаалтныг авлигын гэмт хэрэг үйлдэхэд тусалсан, хууль бус хөрөнгө орлогыг өөрийн эзэмшилд байлгасан, нуусан зэргээр оролцсон этгээдийг Эрүүгийн хуулийн Гуравдугаар бүлэгт заасан зохицуулалт буюу гэмт хэрэгт хамтран оролцсон байдлыг шалган тогтоож, хамтран оролцогчийн хувиар хариуцлага хүлээлгэх боломжтой. Гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэрээс тусад нь</p>	<p>бүрэн илрүүлж хураагаагүй, эсхүл хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ хэрэглээгүй бөгөөд хууль бус хөрөнгө байна гэж үзэх хангалттай үндэслэл байвал процессын зохицуулалтыг хуульчлах шаардлагатай.</p> <p>3.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулиар Эрүүгийн хуулийн Гуравдугаар бүлэгт заасан зохицуулалт буюу гэмт хэрэгт хамтран оролцсон байдлаар зохицуулах боломжгүй юм.</p> <p>4.Хөрөнгө эрхлэн удирдах тухай хуулиар хөрөнгийн удирдлага буюу эзэмшил, ашиглалтын асуудлыг хөндлөнгийн байгууллага явуулдаг дэлхийн сайн жишиг бөгөөд ямар нэгэн процессын хуулийн давхцал үүсэхгүй.</p> <p>5.Авлига, албан тушаалын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ялгаатай байдлаар авч үзэх хэрэгцээ шаардлага үүссэн учраас зарим авлигын гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 20 жил байхаар төсөлд тусгасан. Саналыг хүлээн авах боломжгүй.</p>
--	--	--

	<p>“төлөөний хүн” гэх субъектийг шинээр тусгах шаардлагагүй.</p> <p>4.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, битүүмжлэх, хураан авах, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх зохицуулалт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бий. Гэтэл ТҮр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төсөл нь давхардсан зохицуулалт бий болгохоор байна. Хөрөнгө түр хураан авах, царцаах асуудал нь тухайн процесс ажиллагааны эцсийн шийдвэр гарахаас өмнө авагддаг арга хэмжээ учраас хөрөнгийн удирдлага буюу эзэмшил, ашиглалтын асуудлыг хөндлөнгийн буюу Хөрөнгө эрхлэн удирдах байгууллагад шилжүүлэн өгөх нь мөн л Үндсэн хуулийн зөрчил болно.</p> <p>5.Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамааруулж тогтоосон нь нийтлэг жишиг бөгөөд хамгийн оновчтой зохицуулалт юм. Тиймээс гэмт хэргийн төрлөөр хөөн хэлэлцэх хугацааг тоолох үндэслэлгүй байна. Учир нь хөөн хэлэлцэх хугацаа хариуцлагаас чөлөөлөгдөх үр дагаврыг үүсгэдэг учраас хариуцлага/ял/-тайгаа уялдаатай зохицуулагддаг.</p> <p>6.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо Мөнгө угаах гэмт хэргийн шинжээс ялгах шаардлагатай байна. Жнь: мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээс бусад гэмт хэрэг үйлдэж олсон гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг гэдгийг мэдсээр байж авсан, хадгалсан, борлуулсан гэх мэт.</p>	<p>6.Саналыг хүлээн авах боломжгүй.</p> <p>7.Нийтийн албан тушаалтны хөрөнгө завших үйлдлийг 22 дугаар бүлэгт бие даасан гэмт хэрэгт тооцохыг төслөөс хассан.</p> <p>8.Шүүгчид хууль бусаар нөлөөлөх үйлдлийг хуульчлах нь шүүхийн үйл ажиллагаанд чухал, шударга ёсны зарчимд нийцэх учраас саналыг аваагүй.</p> <p>9.Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг давхар мөнгө угаах гэмт хэргээр зүйлчлэхгүй байх саналыг хүлээн авах боломжгүй байна.</p> <p>10.Саналыг хүлээн авах боломжгүй. Нийтийн албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал бий болгох үйлдэл нь түгээмэл үйлдэгддэг, нийгмийн хор аюулаар их үйлдэл учраас гэмт хэрэгт тооцохгүй байх саналыг хүлээн авах боломжгүй байна.</p>
--	---	---

	<p>7.Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс “Нийтийн албан тушаалтан хөрөнгө завших” үйлдлийг тусад нь салган Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт хамааруулахаар төсөлд тусгасан байна. Хөрөнгө завших гэмт хэрэг Авлигын гэмт хэргийн ялгаа нь халдлагад өртөж байгаа объектоороо ялгагддаг. Тухайлбал, хөрөнгө завших гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд албан тушаалтан байна уу эсхүл тухайн эд хөрөнгийг итгэмжлэн хариуцаж байгаа нийтийн албан тушаалтан биш этгээд байна уу ялгаагүй тухайн хөрөнгийн эсрэг үйлдэл хийдэг. Харин авлигын гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь албаны чиг үүргийн эсрэг үйлдэл хийдэг. Тиймээс хөрөнгө завшиж байгаа албан тушаалтны үйлдлийг Авлигын гэмт хэргийн бүлэгт хамааруулах шаардлагагүй.</p> <p>8.Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлд Шүүгчид хууль бусаар нөлөөлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Гэтэл уг гэмт хэргийн хохирогч болох шүүгчийг нөлөөнд автсан талаараа мэдүүлээгүй гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж ял шийтгэхээр зохицуулсан нь логикгүй бөгөөд шүүн таслах ажиллагаанд шүүгч “нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг болсон” дэвшлийг үгүй хийх зохицуулалт болсон байна.</p> <p>9.Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг/ 18, 20, 22, 25, 26, 29/-ийг тодорхойлж өгсөн нь оновчтой зохицуулалт байна. Үүн дээр нэмээд уг суурь гэмт хэргийг үйлдсэн этгээд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгддэггүй байх зохицуулалтыг оруулж өгөх шаардлагатай байна. Учир нь тухайн суурь гэмт хэргийг үйлдэн хөрөнгө олж авч байгаа этгээдийн санаа зорилго нь тухайн хөрөнгийг ашиглах, хувиргахад чиглэдэг бөгөөд уг зорилгын төлөө хийсэн нэг үйлдэлд нь хоёр зүйл ангиар давхар шийтгэж болохгүй. Тиймээс мөнгө угаах гэмт хэргийн субъект нь суурь гэмт хэрэг үйлдсэн этгээд биш байхаар зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.</p>	<p>11.2015 оны Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйлд заасан хахууль авах гэмт хэргийн нэршлийг нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэж томъёолж, хүндрүүлэх шинж нэмсэн учраас саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн.</p>
--	---	--

		<p>10.Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн шинжээс “давуу байдал бий болгосон” гэсэн шинжийг нэн яаралтай хасах шаардлагатай байгаа юм.</p> <p>Учир нь “давуу байдал” гэдэгт юуг ч хамааруулж, эсхүл юу ч хамааруулахгүй байж болохоор байгаа учраас энэ тодорхойгүй байдлаас хамааран олон хүн хэлмэгдэж, олон хүн ял завшиж байна. Гэмт хэргийн шинжийг хэргийг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлно. Гэтэл давуу байдал гэсэн ерөнхий шинжийг цааш нь дэлгэрүүлэн тайлбарлахдаа Үндсэн хууль, бусад хууль, дүрэм, журамд заалтыг иш татан тайлбарлаж, эдгээр хууль тогтоомжууд бүгдээрээ “Эрүүгийн хууль” болчихоод байна.</p> <p>11.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд гэсэн шинэ гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгах асуудал байж болохгүй. Захиргааны шийдвэр, үйл ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шалгаж “эрүүлжүүлдэг” байдал газар авчихаад байгааг багасгахын оронд хувийн эрх зүйн харилцааны асуудлыг нэмж оруулж ирж байгаа нь байж боломгүй үйлдэл юм. Хэрэв энэ үйлдлийг гэмт хэрэг гэж хуульчлах юм бол асар том хэлмэгдүүлэлтийн хаалга нээгдэж хувийн хэвшлийн үйл ажиллагааг хааж боох арга хэрэгсэл болж хувирна.</p>	
8	<p>Санхүүгийн зохицуулах хороо</p> <p>2025.01.07</p> <p>№1/59</p>	<p>Танай Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл, түүний үзэл баримтлалд санал авахаар ирүүлсэн баримт бичигтэй танилцаад холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.</p> <p>1. Төслийн 4.1.2-4.1.5-т заасан тодорхойлолтуулын найруулга зарим тохиолдолд ойлгомжгүй, мөн “хууль бус хөрөнгө гэж хууль ... тухайн</p>	<p>1.Хуулийг төслийг албан тушаалтнуудад 2002.09.01-ний өдрөөс хойшх хугацаанд</p>

	<p>нөхцөл байдлаас үл хамааран энэ хуульд заасан журмаар хууль ёсны орлогоор олж авах үндэслэлгүй хөрөнгө, түүний иж бүрдэлд хамаарах хөрөнгө, энэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу дараа нь олж авсан, түүнчлэн тухайн хөрөнгийг ашигласнаас олсон, бий болсон хөрөнгө, орлогыг” гэж заасан нь хууль буцаан хэрэглэх асуудлыг нэр томъёонд тусгасан байгааг анхаарч өөрчлөн найруулах;</p> <p>2. Төслийн 4.1.12-т заасан “Нэгдмэл сонирхолтой этгээд”, 4.1.13-т заасан “төрөл садангийн хүн”, 4.1.14-т заасан “гэр бүлийн гишүүн” гэсэн тодорхойлолт зэрэг нь холбогдох бусад хуулиар тодорхойлсон нэр томъёотой давхардсан, зөрчилдсөн байж болзошгүй тул хууль тогтоомжийн нийцлийг хангах;</p> <p>3. Төслийн 6.1.9-д заасан “бүрэн эрх, чиг үүрэг дууссанаас хойших 10 жилийн хугацаатай хамтатган авч үзнэ” гэж заасантай холбогдуулан хууль зүйн үндэслэл, үр дагаврын талаар үзэл баримтлалд тусгах;</p> <p>4. Төслийн 6.1.10 дахь заалтын “нөхөн төлбөргүй” гэснийг хасах;</p> <p>5. Төслийн 15.2-т заасан “шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт” гэдэг нь ямар шаардлага, шалгуурыг хангасан дүгнэлт байх талаар хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тусгах;</p> <p>6. Төслийн 18 дугаар зүйлд тодорхойлсон “хөрөнгө хураан авах ажиллагаанд оролцогч, бусад оролцогч”-ийн хүрээг нэр томъёоны тодорхойлолтод тусгах;</p>	<p>буцаан хэрэглэнэ. Төслийн 29.1 дэх заалттай уялдуулсан.</p> <p>2.Саналыг тусгасан.</p> <p>3.Саналыг хүлээн авч, төсөлд тусгасан.</p> <p>4. Саналыг тусгасан.</p> <p>5.Саналыг тусгаагүй. ШШТХ-ийн 4 дүгээр зүйлийг баримтлан тусгасан.</p> <p>6.Саналыг тусгасан.</p> <p>8. Саналыг тусгаагүй. Тухайн ажиллагааг мөрдөгч явуулахаар хуульчилсан ойлгомжтой</p>
--	--	---

		<p>8. Төслийн 30.11-д “Баримт нотолгоо болох эд зүйлийг түр хугацаагаар хурааж авч болно.” гэж заасныг хэрэгжүүлэх этгээд тодорхойгүй байгаа тул нэмж тусгах;</p> <p>9. Хуулийн төсөлд заасан “мэдэж болох байсан”, “мэдээгүй байсан”, “мэдэх боломжгүй байсан” зэрэг ойлголтуудын ялгааг нарийвчилж, төсөлд тусгах, бусад хуульд заасан ижил, эсхүл ойролцоо агуулгатай зохицуулалттай нийцүүлэх.</p>	<p>зохицуулалт тул заавал субъект тусгах шаардлагагүй гэж үзлээ..</p> <p>9. Саналыг тусгаагүй. Агуулгын хүрээнд шууд ойлгогдож байгаа тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ..</p>
--	--	--	--

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ИРГЭДЭЭС ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОН ЯАМНЫ ЦАХИМ ХУУДСАНД ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ БАЙРШУУЛАН ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦАД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

2025 он

Д/д	Санал гаргасан иргэн	Ирүүлсэн санал, асуулга	Саналыг тусгасан эсэх, тайлбар
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн Олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллөөс хуулийн төслөө хурдан хийх, хэрэгжилтэд анхаарч хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог анхаарах, шинэчлэх, хуулиа сурталчлах, хууль хэрэгжилтэд гарч болзошгүй, цаашид анхаарах асуудлын талаар асуулга түлхүү байлаа.			
1.	Эрх чөлөө намын дарга Төмөрсүх	<p>Олон сайхан сайхан хуулиуд гарч байдаг гэхдээ хуулийн гүйцэтгэл байдаггүй. Өнөөдөр прокурор, шүүхийн байгууллагын түвшин ямар байгаа вэ? Яаж энэ хуулиа хэрэгжүүлэх юм бэ?</p> <p>Одоогийн прокурор, шүүхийн тогтолцоо, эрх зүйн орчныг өөрчлөхгүй бол энэ хууль чинь хэрэгжих боломж байхгүй. Хууль зөрчсөн шийдвэр гаргадаг Прокурор, шүүгчид хариуцлага хүлээлгэх зохицуулалт хангалтгүй байдаг энэ асуудал дээр яаж анхаарсан бэ?</p>	Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.
2.	Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн Баасан	Хууль их гараад байдаг. Хэрэгжүүлэх байгууллагадаа анхаарахгүй юмуу, АТГ, прокурор, шүүх дээр ачаалал, бүтцийн асуудал байна. Хуулиа хурдан хийж хэрэгжүүлэхгүй бол хөрөнгө хувирч хураах боломжгүй болдгийг анхаарах. Мөн хураахдаа хурдан түргэн процессоор шийдвэрлэх шаардлагатай байна.	Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.

		<p>Хураан авсан хөрөнгөө хэрхэн зарцуулах асуудлыг түр хойш нь тавих. Эхлээд хураах асуудлаа хурдан шийдвэрлэх хэрэгтэй байна.</p> <p>Энэ шинэ хуультай холбоотойгоор холбогдох төрийн байгууллагуудад шинэчлэл хийх юм уу хийхгүй юм уу?</p> <p>Төрийн албан хаагчийн хууль бус хөрөнгө хураах асуудал дээр тусдаа процессын зохицуулалт шаардлагатай шүү.</p>	
3.	Иргэн Отгонтөгс	<p>Хөрөнгө шалгах ажиллагааны хугацаа удаан байна, 2 жил гэдэг. Хөрөнгөө хурдан битүүмжилж, түр хураан авч, хамгаалж байх яг таг зохицуулалтыг хийж өгсөн үү. Хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэх юм бол прокурор нэн даруй хөрөнгийг царцаах энэ мэтчилэн хөрөнгийг хамгаалах тодорхой болгож өгсөн заалтууд байна уу, шалгаж байх хугацаанд тэр хөрөнгийг хоёр гурав хуваагаад зарж борлуулаад хуваагаад үрэн таран хийх учраас энэн дээр бас анхаарч өгөөчээ гэж хүсэж байна.</p> <p>Нийтийн албан тушаалтан гэдэг үгэн дотор улс төрийн албан тушаалтан орох уу, биетээр байхгүй ч гадаад улсад гараад явчихсан хүнийг гэм буруутайд тооцож шийдээд явах боломж байгаа юу гадаадад байгаа хүнийг монголд байхгүйгээс болоод бид гэм буруутай гэж тогтоож чадахгүй байгааг байна.</p> <p>Энэ хуулийг батлагдана гэдэгт бол аягүй эргэлзээтэй байна. Яагаад гэвэл Их хуралд чинь яг өөрсдөө хууль бусаар хөрөнгөжсөн улсууд чинь өөрсдөө сууж байгаа шүү дээ. Ямар нэгэн лобби хэрэгтэй юм бишүү баталж өгөх болов уу ард түмэн очоод ард нь жагсаж байж юм уу батлуулахгүй бол зүгээр очоод</p>	<p>Саналыуд хуулийн төсөлд тусгагдсан.</p> <p>Мөн хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.</p>

	<p>батлагдана гэж байхгүй байхаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл маш хангалтгүй явж байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр ямар өөрчлөлт хиймээр юм энийгээ бас бодмоор байна. Хууль бусаар хөрөнгөжсөн улсуудаа өршөөж ял завшуулж байгаа эргэж хараад зохих хариуцлагыг нь тооцвол маш сайн байнаа.</p> <p>Хуулийн төсөлд хялбаршуулсан журмаар шийдүүлэх заалт орсон байна, энэ заалтаар ял завших боломж олгох вий дээ.</p> <p>Мөн энэ чинь хөрөнгө хураах хууль юм уу хууль бус хөрөнгийг баталгаажуулж байгаа хууль юм уу гэдэг болчих гээд байна. Мөн хуулийн 49 дүгээр зүйл дээр чинь заасан байгаа юм хугацаа гээд хэргийг 2 жил мөрдөж шалганаа гээд хэрвээ 2 жилдээ амжихгүй бол 7 хоногийн өмнө хүсэлт өгөөд 1 жилээр сунгана гэж байгаа юм ерөнхийлөгч байсан хүн энийг чинь 3 жил байтугай 30 жил зууруулж чаднаа Төрийн албаны тухай хуулийнхаа 11.1-ийг яг энэ дээрээ тодорхой бичээд өгөөчээ тэгвэл ерөнхийлөгч, ерөнхий сайд байсан хүмүүс чинь орно.</p>	
4.	<p>Транспарэнси интернэйшнл ТББ-ын хараат бус зөвлөх Тэгшбаяр</p> <p>Энэ хуулийн ач холбогдол бол маш өндөр. Тийм учраас бид ач холбогдлыг нь иргэддээ таниулах, мэдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудтай, иргэдтэй, олон улсын байгууллагуудтай ялангуяа хамтарч ажиллах зайлшгүй шаардлага бол байна. Дагалдах хууль дээр бол бид хамгийн гол асуудал бол зарлагаа хянах ёстой. Зарцуулалт, зарлагыг шалгалтад хамруулахгүй бол энэ хууль маань хэрэгжихэд жаахан хүндрэл учрах эрсдэлтэй. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдгийн албан тушаалтан гэдэг үгийг авах шаардлага байна. Яагаад гэвэл энэ</p>	<p>Саналыг тусгаж, гадаад хамтын ажиллагааны заалтыг сайжруулсан. Мөн хөрөнгө шалгах ажиллагаанд хөрөнгийн зарцуулалт, амьжиргааны зардал зэрэг ойлголтуудыг нэмж тусгасан. Мөн хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хамаарал бүхий</p>

	<p>үндэслэлгүйгээр орж ирсэн хөрөнгийг хамаатныхаа нэр дээр, эхнэрийнхээ, хүүхдийнхээ нэр дээр жолоочийнхоо нэр дээр хадгалаад байгаа учраас энэ маань яг албан тушаалтны маань хөрөнгө өөрөө өссөн байхыг манай хуулийн зохицуулалт маань шаардаад байгаа учраас хууль зүйн яам өмнө нь өөрчлөлт хийхдээ өөрийн гэдэг ганц үгийг л авч хаясан ш дээ Хөрөнгийн менежментийн асуудал дээр бид гурван нөхцөл харж үзэх ёстой. Монголд байгаа, гадаадад байгаа монголын хөрөнгийн асуудлыг, монголд байгаа гадаад улс руу шилжсэн хөрөнгийн асуудлыг ярих ёстой. Гадны хөрөнгө нь манай Монгол Улсад хөрөнгө нь угаагдсан бохир мөнгө ороод ирэхэд цагдаа, прокурор, танай хууль зүйн яам өчнөөн юм болчихоод авч чадахгүй байгаа болохоор манай улс хохироод байнаа энэн дээр анхаараад өгөөчээ. Гадаад улсын байгууллагатай хамтарч ажиллах зохицуулалт орох шаардлагатай энэ хуульд.</p>	<p>этгээдэд хамаарах этгээдүүдийг тодорхойлж, нийтийн албан тушаалтнаас гадна хамаарал бүхий этгээдэд бий болсон, нийтийн албан тушаал хашиж байх хугацаанд бий болсон хөрөнгийг шалгах зохицуулалтыг тусгасан.</p> <p>Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.</p>
<p>5. Уул уурхайн зөвлөх инженер эрх зүйч судлаач Гэрэлгуа</p>	<p>Шинжээч, мэргэжилтнүүдийн төрийн албанд тавигдах болзол шалгуур хангасан эсэхийг та нар яаж мэдэж байгаа юм бэ</p> <p>Энэ хөрөнгө чинь өөрөө явж явж эс үйлдлээр тогтоогдож байгаагшд, эс үйлдлийг та нар яаж тогтоох юм вэ одоо төрд ажиллаж байгаа хүмүүс мэргэшсэн хүмүүс байна уу Ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг хамгийн түрүүнд цэгцлэх шаардлагатай байна. Энэ хуулинд нэг л инженер бүх л юмыг тодорхойлж байна шд, нүдний эмч шүдний эмч хийдэггүй биздээ, мэргэшсэн байгаа юу үгүй юу гэдгийг цэгцлэх, шинжээч нарыг маш нарийн тодорхойлох ёстой байгаа юм</p>	<p>Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.</p>

6.	Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн Баянмөнх	Орлогоос дазсан орлого ашиг, ажил үйлчилгээ авдаг асуудлыг шалгах талаар хуулиндаа оруулмаар байна сайдаа, Төрийн албан хаагчийн цалинтай хүн байж байдаг гэтэл хэдэн саяын төлбөртэй сургуульд хүүхэд нь явж байдаг жилд тэдэн удаа гадаадад амраад зугаалаад явж байдаг. Санал Олон нийтийн хяналт оролцоог хуульд оруулж өгөх саналтай байна.	Хуулийн төсөлд зарчим, агуулгын хувьд тусгагдсан. Олон нийтийн хяналт оролцоотой холбоотойгоор хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах асуудал дээр мэдээллийг ил тод болнож, олон нийт хяналт тавих боломжийг нээж өгсөн. Түүнчлэн авлигын талаар мэдээлэл өгөх иргэний эрхийг хамгаалж, авлигын мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах зохицуулалтыг тусгасан.
7.	МУИС барилгын төслийн зөвлөх инженер Бат-Очир	Хууль боловсруулсан баг хамт олонд гүн талархал илэрхийлж байна.	Дэмжсэн санал өгсөн.
8.	Үндсэн хууль судлаач Батбаяр	Нийтийн албан тушаалтан бүрэн эрхийнхээ хугацаанд дууссанаас хойш 10 жил гэж хамтатгаж авч үзжээ. Энэ яагаад 10 жил гэсэн юм бэ мөн 2002 оноос хойш хөрөнгийг хамруулна гэсэн байна энэ яагаад заавал 2002 он гэсэн бэ энэ үндсэн хууль батлагдсанаас хойш болдоггүй юм уу мөрдөгч шүүгч прокурор оролцоно гэж байна эд нар энэ төсөлд шударга ёсыг тогтоох баталгаа байна уу Энэ хуулийн төслийнхөө хэд дээр сайд өөрөө	10 жил гэсэн нь хашиж байсан албаны эрх нөлөө цаашид үргэлжилж байж болзошгүй гэж үзсэний үндсэн дээр тусгасан байсныг өөрчилж нийтийн албан тушаал хашиж байх хугацаанд бий болсон хөрөнгөтэй холбогдуулан

		гар бие оролцож бичсэн бэ хуулийн төслийн багийнхан бичсэн үү	шалгах ажиллагаа хийхээр өөрчлөн төсөлд тусгасан.
9.	Батсайхан Эрүүл ахуйн их эмч улсын байцаагч	Хэлэлцүүлэг хийж байгаад баярлалаа. Энэ санаа чинь зөв. Өмч хувьчлалаасаа та нар эхлээчээ 1992 оноос эхлээчээ бүтэн арваад жилийн зүйл хаягданаа шүүх засаглалынхаа процессийн асуудал дээр та нар онцгой процесс гаргаачээ би өөрөө бас өмгөөлөл хийдэг юмаа. Үнэхээр прокурор цагдаа шүүхийн улсууд ялзарчихсан байна. Сүүлдээ өмгөөлөгчөөр дамжуулаад мөнгө өгөлцөж авалцдаг бүр ил тод болчихсон байна. Сарын өмнө хүсэлт гаргасан тэрийг аягүй сайн шийдэж өгсөн. Энэ хууль чинь мөнгөгүй хүнд маш хатуу үйлчлээд мөнгөтэй хүнд маш их зөөлөн бууж байна. Хилийн хориг тавихгүй бол шөнө нь ниссээд явчихаж байна ш дээ. Энэ заалтыг бүр оруулж өгөх хэрэгтэй байна. Цаазын ялаа сэргээгээчээ, тэгж байж хүн айна.	Хуулийн төсөл батлагдсаны дараа анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.
10.	Иргэн Солонго	Нийтийн албан тушаалтан гэж яг хэнийг хэлэх вэ яг зүйлчлээд тусгаад оруулчихвал эргэлзээгүй болчих гээд байгаамуу бас	Хуулийн төсөлд тодорхой тусгагдсан бөгөөд энэ талаар хэлэлцүүлгийн явцад тайлбарлав.
11.	Иргэн Занданхүү	Эрх зүйч мэргэжилтэй Энэ хууль дээр илрэн гарах гадаад хэлбэрээ авч үзээрэй. Хууль сурталчлах гэдэг ажлыг манай монголын төр хийгээгүй.	Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.

		<p>Авлига үйлдсэн этгээдийг төр, нийтийн эрх ашиг, олон нийтийн эрхэд халдсан гэж үзэх тодорхой хуулийн заалт хэрэгтэй байна. Энэ тал дээр хэрхэн анхаарч ажилласан бэ?</p>	<p>Саналд дурдсан агуулга хуулийн төслийн дагалдан хуулийн төсөл болох Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан.</p>
12.	Иргэн Ганбаяр Хөрөнгө оруулалтын шинжээч	<p>Энэ хуулийн төслийн ажлын хэсэгт хөрөнгийн зах зээлийн мэдлэгтэй хөрөнгийн зах зээлийн талаар ойлгодог нэг ч хүн байхгүй юм бна. Энэ хууль дээр виртуал хөрөнгөөс гадна хувьцаа, бонд, койн, виртуал хөрөнгүүдийг оруулах ёстой, мөн хамааралтай хүн гэдэг дээр.</p>	<p>Саналыг тусгасан.</p>
13.	Иргэн Отгонцэцэг	<p>Энэ санаачилж байгаа хуулиа нэг кабинеттэй Засгийн газрын гишүүний хувьд Оюун-Эрдэнэ сайдад танилцуулсан уу, энэ хуулийг дэмжиж байгаа юу, би ч бас хууль бус хөрөнгөө хураалганаа гэж хэлсэн үү</p>	<p>Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжилтэд анхаарах асуудал тул цаашид хэрэгжилтийн явцад анхаарч ажиллах.</p>
14.	Иргэн Отгонбаатар	<p>Нийтийн албан тушаалтан гэдэгтээ Төрийн өндөр албан тушаалтанг хатуу зааж оруулах хэрэгтэй байна.</p>	<p>Хуулийн төсөлд тодорхой тусгагдсан бөгөөд энэ талаар хэлэлцүүлгийн явцад тайлбарлав.</p>
Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал ихэнхи нь дэмжсэн санал ирүүлжээ.			
15.	Иргэн Цогтбаатар	<p>Төсөлтэй танилцлаа, Монгол Улсад үгүйлэгдэж байсан, зохицуулалт шаардсан онцгой харилцааг маш сайн зохицуулж төсөл гаргасан байна. Мэдээж алдаа оноо шүүмж гарах байх, гэхдээ үүнийг зайлшгүй батлуулаарай гэж захиад, дэмжсэн саналаа илэрхийлж байна.</p>	<p>Дэмжсэн санал өгсөн.</p>

16.	Иргэн Дөрвөд	Хуулийн төсөлд санлаа өгөв. Дэмжиж байна.	Дэмжсэн санал өгсөн.	
17.	Иргэн Долгор	энэ хуулийн төслийг дэмжиж байна .өөрийн эрх мэдэл албан тушаалаа урвуулан авсан эрх мэдэлтэн дарга нарыг шалгаж улсаа хохилгүй болгох нь зөв өө	Дэмжсэн санал өгсөн.	
18.	Иргэн Гриш	Зөв санал	Дэмжсэн санал өгсөн.	
19.	Иргэн Ганбат	Дэмжиж байна.	Дэмжсэн санал өгсөн.	
20.	Иргэн Амгаланбаатар	Дэмжиж байна.	Дэмжсэн санал өгсөн.	
21.	Иргэн О.Балдангомбо	100 хувь дэмжиж байна.	Дэмжсэн санал өгсөн.	
22.	Иргэн Уртаа	Дэмжиж байна.	Дэмжсэн санал өгсөн.	

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ ЖУРМААР
НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Дд	Нэр	Албан тушаал
1	О.Алтангэрэл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
2	Н.Мягмар	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
3	Ч.Хосбаяр	Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн(зөвшилцсөнөөр)
4	Б.Батцэрэн	Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч(зөвшилцсөнөөр)
5	О.Мөнхбаатар	Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга
6	Э.Оюунболд	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, ахлах комиссар
7	Н.Жамьянхүү	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга
8	Э.Сэргэлэнбаатар	Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн Цагдаагийн албаны дарга, цагдаагийн дэд хурандаа
9	Б.Нямгомбо	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа
10	Б.Ариунзаяа	Үндэсний аудитын газрын Тамгын газрын Хуулийн хэлтсийн Хууль, эрх зүйн менежер
11	С.Гантулга	Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа
12	Б.Эрдэнэбат	Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
13	О.Амарсанаа	Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
14	Ж.Амгалан	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 18, Утас: 26 15 44,
И-мэйл: info@supremecourt.mn

2024.12.27 № 01/6198
танай _____-ны № _____-т

Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу
Нийтийн албан тушаалтны хууль бус
хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх
тухай анхдагч хуулийн төслийн талаар

Таны 2024 оны 1/1868 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн
“Авлигын эсрэг багц хуулийн төсөл Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг
хураан авах, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төслийг Монгол Улсын дээд шүүхийн
нийт шүүгчийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж,
гаргасан саналыг нэгтгэн Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3 дахь
заалтад заасны дагуу хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Д.ГАНЗОРИГ

**Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны
хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай
анхдагч хуулийн төсөлд санал**

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж буй “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төсөл (2024.11.18-ны өдрийн байдлаар)-ийг үзэл баримтлалын хувьд дахин нухацтай авч үзэх шаардлага байгааг дурдан материаллаг болон процессын эрх зүйн үүднээс дараах саналыг өгөх нь зүйтэй гэж Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

1. Монгол Улс нь Авлигын эсрэг НҮБ-ийн конвенцоор хүлээсэн үүргийн дагуу нийтийн албан тушаалтан хууль бусаар хөрөнгөжих үйлдлийг анх 2012 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болгон хуульчилж, улмаар шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлд уг гэмт хэргийн диспозици болон санкцд өөрчлөлт оруулж, “үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хураах” заалтыг нэмж тусгасан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 7.5 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагын нэг төрөлд хамаарах тул эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмын дагуу түүнийг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлох учиртай.

Гэтэл “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төсөл /цаашид Анхдагч хуулийн төсөл гэх/-ийн үзэл баримтлалд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг тусад нь бие даасан хуулиар зохицуулахаар томъёолсон нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль тогтоомжтой давхардал үүсгэж байна.

Тухайлбал, Анхдагч хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг илрүүлж, хураан авахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт үйлчлэхээр тусгасан атлаа хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх үүрэг, мөрдөн шалгах ажиллагаа явуулах тусгай журмыг хуульчилснаас гадна Иргэний хэргийн анхан шатны шүүх нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх асуудлыг прокурорын гаргасан нэхэмжлэлийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээр тусгажээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.” гэж заасантай энэхүү анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалт зөрчилдөж байна. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль

нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01 дугаартай тогтоолд "... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хязгаарлагдана" гэж дүгнэснийг дурдах нь зүйтэй.

Иймд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг энэ гэмт хэргийн онцлогт тулгуурлан шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс процессын зарим тусгай зохицуулалтыг шинээр хуульчлах шаардлагатай гэж үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт "Хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явуулах тусгай журам" бүхий дэд бүлгийг шинээр нэмэх боломжтой юм.

2.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ийн конвенцын 29 дүгээр зүйлд нийцүүлэн ердийн гэмт хэргээс уртаар тогтоох асуудлыг Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хувьд эд хөрөнгө бий болсон үеийг албан тушаал хашиж байсан үед багтаан тогтоох боловч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тухайн албан тушаалыг хашиж буй эсэхээс үл хамааран эд хөрөнгө ил болсон буюу албан тушаалтан эд хөрөнгийг өөрийн эсхүл, хамаарал бүхий хүний эзэмшилд авсан үеэс эхэлж тоолдог.

Харин үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байх, эсхүл хэтэрхий урт хугацаагаар тогтоох нь хүн өөрийн шударгаар олж авсан эд хөрөнгийн эх үүсвэрийг нотолж чадахгүйд хүрэх, нотлох боломжгүй болох, ингэснээр хүний эрх зөрчигдөх эрсдэлд хүргэх аюултай болно.

Түүнээс гадна 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрөөс дагаж мөрдсөн "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулийн 6.1-д "Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно." гэж заасныг анхаарах нь зүйтэй.

3.Хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгийг хураах харилцаанд баримтлах эрх зүйн үндсэн эх сурвалжийн нэгээр Иргэний хуулийг нэрлэн заажээ. Гэвч хувийн эрх зүйн үндсэн эх сурвалж болох Иргэний хуулиар энэ төрлийн харилцааг зохицуулах нь эрх зүйн онол, зарчмын хувьд боломжгүй юм.

Эд хөрөнгийг хуулийн хүрээнд олж авах, эзэмшилдээ байлгах, үр ашгийг хүртэх замаар хувийн өмчийн эрх найдвартай хамгаалагдах баталгааг Үндсэн хуулиас гадна Иргэний хууль бэхжүүлэн зохицуулдаг бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт субъектив шаардах эрхийн хүрээнд хэрэгждэг. Нийтийн эрх зүйн хүрээнд эд хөрөнгийг хураах, дайчлан авах харилцаа нь хувийн эрх зүйн зохицуулах зүйлд хамаардаггүй онцлогтой.

Тодруулбал, иргэд, хуулийн этгээд, эсхүл төр, орон нутгийн субъектив шаардах эрх зөрчигдсөн бол тэдгээр нь өөрсдөө, эсхүл хуулийн хүрээнд эрх бүхий төлөөллөөр дамжуулан зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр иргэний хэргийн шүүхэд хандана. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, эсхүл төр байх аль ч тохиолдолд уг этгээдийн субъектив шаардах эрх хөндөгдсөн, эсхүл хөндөгдөж

болзошгүй нөхцөл байдал үүссэн байхыг хувийн эрх зүйн хэм хэмжээ шаардах бөгөөд энэ ч агуулгаар энэ харилцаанд мөн чанарын хувьд прокурорын оролцоо шаардлагагүй байдаг онцлогтой. Хувийн эрх зүйн харилцаа нь оролцогч хэн байхаас үл хамааран тэгш байдлын хүрээнд өрнөх учиртай.

Иргэд, хуулийн этгээдийн хооронд хууль бусаар хөрөнгө шилжсэн, олж авсан гэх үндэслэл байвал ийнхүү хөрөнгө шилжсэнээр хувийн эрх ашиг нь хохирсон этгээд өөрт учирсан хохирлоо арилгуулахад хувийн эрх зүй үйлчлэх бөгөөд дээрх хууль бус шилжүүлгийн явцад нийтийн эрх ашиг хохирсон гэж үзэх үндэслэл тогтоогдвол энэ нь иргэний эрх зүйн хэм хэмжээгээр бус нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах харилцаа болно.

Иргэний хуулийн дөрөвдүгээр хэсэг, гэрээний бус үүргийн төрөл болох үндэслэлгүй хөрөнгөжих, зөрчлийн улмаас үүсэх үүрэг болох гэм хор учруулснаас үүсэх үүргийн аль ч тохиолдол нь эд хөрөнгөө бусдад үндэслэлгүй шилжүүлсэн, эсхүл эд хөрөнгө, эрүүл мэнд гэх мэт хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд нь гэм хор учирсан тухайн этгээд өөрт олгогдсон субъектив шаардах эрхээ хэрэгжүүлснээр үүснэ.

Харин хэн нэгэн этгээд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах замаар эд хөрөнгө олж авсан нь нийтийн эрх ашигт хохирол учруулсан хууль бус үйлдэл мөн бөгөөд хохирол, гэм хор учирсан тухайн эрх ашиг нь нийтийн эрх ашиг тул энэхүү харилцаанд талуудын тэгш эрх, хуваарилалтын ба солилцооны зүй ёс, гэрээний чөлөөт байдлын зарчмыг санал болгодог хувийн эрх зүйн хэм хэмжээ тохирдоггүй.

Түүнчлэн талуудын тэгш байдлын үндсэн дээр үүсэх хувийн эрх зүйн материаллаг хэм хэмжээнээс бий болсон маргааныг хянан шийдвэрлэх механизм ч энэхүү материаллаг харилцаан дахь тэгш байдлын зарчимтай салшгүй холбоотой. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах үндсэн хоёр зарчимд суурилан хэрэгжинэ. Үүнд:

-Нэхэмжлэлийн шаардлага, татгалзлын үндэслэлээ өөрсдөө нотлох, тэгш мэтгэлцэх талуудын зарчим,

-Хэргийн оролцогч нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлох, татгалзах, эвлэрэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгавар болгох диспозитив зарчмыг эн тэргүүнд нэрлэж болно.

Тодруулбал, хувийн буюу субъектив эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзсэн хэн ч болов иргэний шүүхэд хандаж эрхээ сэргээлгэх боломжтой боловч шаардах эрхээ хэрэгжүүлэн мэтгэлцэхдээ тэгш боломж олгогдох ёстой. Энэ ч агуулгаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ талуудын хүсэлтэд суурилан оролцогч нэг талын давуу байдлыг илтгэх аливаа мөрдөн шалгалтаас ангид байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эн тэнцүү боломжтой байх зарчимд тулгуурлана.

Иргэний шүүх нь талуудад тэгш хандаж, мэтгэлцэх боломжоор адил ханган өөрөө хөндлөнгийн байх зарчимтай тул цагдаагийн болон прокурорын байгууллагын оролцоотой хэрэгждэггүй. Эдгээр байгууллага нь хэргийн оролцогчийн хувиар өөрсдийн субъектив шаардах эрх нь зөрчигдсөн гэх агуулгаар иргэний хэрэг (хөдөлмөрийн, гэрээний маргаан г.м) хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бол бусад оролцогчтой тэгш мэтгэлцэх учиртай. Нэг талын давуу эрхээр,

мөрдөн шалгах зарчмаар цуглуулсан нотлох баримт иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талуудын зарчмын дор хуульд нийцээгүйд тооцогдож, шүүх үнэлэхгүй байх хууль зүйн үр дагавартай. Иргэний эрх зүйн зөрчлөөс үүсэх маргааны хувьд ч хэргийг хянан шийдвэрлэх дээрх зарчим хөндөгдөхгүй бөгөөд гагцхүү гэм буруугүйгээ хариуцагч өөрөө нотлох үүрэг хүлээдгээрээ гэрээнээс үүсэх маргаанаас ялгагдана.

Иймд нийтийн эрх зүйн шинжтэй хэрэг маргааныг мөрдөн шалгах зарчимд суурилан шийдвэрлэх үзэл баримтлал бүхий тус хуулийн төслийн зохицуулах зүйлийг хувийн эрх зүй ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэм хэмжээний үйлчлэлд хамааруулсан нь тулгуур зарчмын зөрчил болохын зэрэгцээ Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, иргэний хэргийн шүүхийн мөн чанарт нийцэхгүй тул ердийн харьяаллын шүүх ийм үзэл баримтлал бүхий хуулийг хэрэгжүүлэхэд онол, практикийн хүндрэл, хүний эрхийн зөрчил үүсэхээр байгааг анхаарвал зохино.

4. Анхдагч хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын зарим гэмт хэрэг болон 18 дугаар бүлэгт заасан мөнгө угаах гэмт хэргийн шинж, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг ялгамжтай тогтоох агуулгаар Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийн саналууд нь Авлигын эсрэг НҮБ-ийн конвенц болон ФАТФ-ын зөвлөмжид бүрэн нийцээгүй байгааг тэмдэглэж байна.

5. Эрүүгийн хуулийн 22.16 дугаар зүйл “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг шинээр томъёолсон нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50.1.29-д заасан шүүгчийн сахилгын зөрчилтэй давхардсанаас гадна нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмаар дамжуулан шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгод нийцэхгүй, сахилгын зөрчилд хамаарах хуулиар нэгэнт тогтоосон зан үйлийн хэмж хэмжээг эрүүгийн гэмт хэрэг болгож буй үндэслэл, үзэл баримтлал нь тодорхойгүй байна. Ингэснээр шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулах үр дагавартай гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС**

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

2025. 01. 03 № 01/29

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөлтэй танилцлаа.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14.2-т “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.”, 14.7-д “Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.”, 15.1-д “Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан нь дээрх хуулийн төсөлтэй зарчмын хувьд агуулга ижил байсныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан өдрөөс хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх” гэж заажээ.

Иймд Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг дэмжихгүй байгаа бөгөөд энэ хуулийн төсөлд зохицуулахаар тусгагдсан “хөрөнгө шалгах ажиллагаа”-ны талаарх болон бусад зохицуулалтыг Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

1506.0055

урьдчилан сэргийлэх тухай хуулиуд, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

ДАРГА



Д.СҮНЖИД



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.12.17 № 2423
танай _____ -ны № 1/1868 -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
1/1868 дугаар албан бичигтэй танилцлаа.

Тус албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг багц
хуулийн төсөл буюу “Нийтийн албан тушаалтны хууль
бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх”, “Түр болон
бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах
тухай” анхдагч хуулийн төсөлтэй танилцаж, зарчмын
хувьд дэмжиж байгаа болно.


Д.ЗАГДЖАВ

201040556



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0027
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gpo@prosecutor.mn,
Цахим хуудас: prosecutor.mn

2024.12.26 № 1/60
танай _____-ны № _____-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**


Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
1/1868 дугаар албан бичгээр санал авахаар
ирүүлсэн Авлигын эсрэг багц хуулийн төсөлтэй
танилцаад саналаа хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 9 хуудастай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ

О.МАШБАТ



АВЛИГЫН ЭСРЭГ БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

№	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал				Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Нэмэх	Хасах		
0	1	2	3	4		5
1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл						
1.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 2/17.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт		“Гэмт хэрэг” гэсний өмнө “Бусдын” гэж нэмэх			Суурь гэмт хэргийг үйлдсэн этгээдийг тус зүйл хэсгээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага оногдуулах нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулана” гэсэн шударга ёсны зарчимтай нийцэхгүй байх тул гэмт хэргийн субъектийг тодорхой болгох шаардлагатай байна.
		“Нийтийн албан тушаалтан өөрт итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс таван жил хүртэл				Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад нийтийн албан тушаалтнаас бусад албан тушаалтан итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийг завшсан тохиолдолд оногдуулах

2.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 3/22.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт	хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчлөн найруулах		хорих ялын хэмжээг 2 жилээс 8 жил хүртэл байхаар хуульчилсан. Иймд нийтийн албан тушаалтанд хөрөнгө завших гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-д нийцүүлэн зорчих эрх хязгаарлах болон хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.
3.	Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 1/7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт	“3.Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлөх, эсхүл түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирол, хор уршгаас илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ” гэж өөрчлөх		Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь гэмт хэргийн улмаас бусдад учирсан хохирол болон хор уршгийг арилгах үүрэгтэй тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлд заасан хуулийн зохицуулалттай нийцүүлж, <u>хор уршгийн талаар нэмэх нь зүйтэй.</u>
4.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг		“...гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл” гэсний дараа “эд хөрөнгө” гэж нэмэх	Гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдах эд зүйлсийг зөвхөн техник, хэрэгсэлээр хязгаарлах нь учир дутагдалтай байна. Тухайлбал, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны хөрөнгө, орлоготой нийлүүлэх, холих замаар мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн тохиолдол цөөнгүй гарах болсон. Энэ тохиолдолд тухайн хууль ёсны хөрөнгийг ашиглахгүйгээр мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх боломжгүй тул гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан эд зүйл гэж

				үзэх үндэслэлтэй юм. Иймд зарим төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж буй нөхцөл байдал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтод нийцүүлэн эд хөрөнгө гэсэн ойлголтыг нэмэлтээр хуульчлах шаардлагатай.
5.	Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 2/18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт		"...энэ хуулийн 18,20,22..." гэсний дараа "24" гэж нэмэх	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага FATF)-ийн 3 дугаар зөвлөмжид "улс орнууд мөнгө угаах гэмт хэрэг бүх хүнд гэмт хэргийг хамруулж, өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохино." гэж заасан.
6.	Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 2/18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт		"...эхүл энэ хуулийн 18,20,22..." гэсний дараа "24" гэж нэмэх	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, төр, нийтийн ашиг сонирхолд учруулж буй хохирол, хор уршиг зэргийг харгалзан бүхэлд нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болохоор хуульчлах нь зүйтэй.
7.	Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 2/18.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	"...29 дүгээр зүйлд..." гэсний зүйл гэснийг хасаж, "бүлэг" гэж өөрчлөх		Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүтцэд нийцүүлэн зүйл гэснийг бүлэг болгон өөрчлөх шаардлагатай.
8	Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 4/22.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэг	"Энэ зүйлд заасан "их хэмжээ" гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгох" гэж өөрчлөх		Тус бүлэгт заасан гэж өргөн хүрээтэй хуульчлах нь зарим авлигын гэмт хэргийн нийгмийн аюулын шинжид нийцэхгүй тул зүйл гэж өөрчлөх нь зүйтэй байна.

2.Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төсөл

9	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн 4.2.2 дахь заалт	“хөрөнгийн үнэлгээг тогтоох” гэснийг “хөрөнгийн үнэлгээг тогтоолгох” гэж өөрчлөх		Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд зааснаар тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий үнэлгээчин хөрөнгийн үнэлгээ хийх тухай зохицуулалттай тул түүнд нийцүүлэх шаардлагатай.
10	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.8, 5.9, 5.10 дахь хэсэг	Хөрөнгө эрхлэн удирдах нэгж хариуцах		Тухайн хэсэгт заасан ажиллагааг хэн хариуцахыг тодорхой болгох.
11	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.17 дахь хэсэг	“... хариуцагч...” гэснийг тодорхой болгож, хуулийн нэр томъёонд нэмж оруулж тодорхойлох		Хуульд заасан нэр томъёогоор тодорхойлж ойлгомжтой болгох.
12	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг	“...Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 214.4-д ..”		Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 214 гэсэн зүйл хэсэг байхгүй тул зөвтгөх.
13	Хуулийн төслийн 6.4 дэх хэсэг	“...мэргэжлийн хяналтын байгууллагын...” гэснийг өөрчлөх		Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж чиг үүрэг нь бусад байгууллагуудад шилжсэн. Иймд ямар байгууллагын хяналт дор устгахыг тодорхой тусгах.
3.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл				
14	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.10-4.1.14 дэх заалт	Холбогдох бусад хуулийн нэр томъёотой нийцүүлэн өөрчлөх		Салбар хуулиар тодорхойлсон нэр томъёог харилцан адилгүйгээр дахин томъёолох нь хуулийн давхардал, зөрчлийг үүсгэхээр байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн

				29.1.7-д заасан шаардлагад нийцүүлэх.
15	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг	“Тухайн нийтийн албан тушаалтан байгаа эсэхээс үл хамааран хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг явуулна” гэснийг “Тухайн нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, нас барсан эсэхээс үл хамааран хөрөнгө хураан авах ажиллагааг явуулна” гэж өөрчлөх		Тухайн нийтийн албан тушаалтан байгаа эсэх гэдэг нь ойлгомжгүй, ямар утгыг илэрхийлж байгаа нь тодорхойгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д заасан шаардлагад нийцүүлэх.
16	Хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйл	Хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйлд заасныг өөрчлөн найруулах		Төслийн хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйлд заасан зохицуулалтууд нь “Зарчим” бус харин хуулийн үйлчлэх хүрээ хязгаар, үндэслэлийг журамласан зохицуулалтууд байх тул өөрчлөн найруулах.
17	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.10 дахь заалт	Тухайн заалт нь ойлгомжгүй байх тул өөрчлөн найруулах		Төслийн тус заалт нь ямар утга санааг илэрхийлж байгаа нь ойлгомжгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д заасан шаардлагад нийцүүлэх.
18	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг	“...нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болох...” гэснийг “хууль бус хөрөнгө, орлого олсон болохыг” гэж өөрчлөх		Хууль бус хөрөнгө нь зөвхөн нийтийн албан тушаалтны эзэмшил, өмчлөл, ашиглалтад байгаа тохиолдолд түүнийг тогтоож, хураан авах гэж ойлгогдож байх тул өөрчлөн найруулах.
19	Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дүгээр зүйл		Ямар процесс ажиллагаа явуулсны улмаас холбогдогч болохыг тодорхой болгож, холбогдох	Хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны аль үе шатнаас нийтийн албан тушаалтан холбогдогч болж, холбогдогчийн эрх, үүргийг хүлээх нь ойлгомжгүй байх тул холбогдох

		зохицуулалтыг нэмэх		зохицуулалтыг шаардлагатай.	нэмэх
20	Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг		"...бусад оролцогч" гэсэн тодорхойлолт нэмэх	Бусад оролцогч тодорхойлолт хуулийн төсөлд байхгүй байх тул нэмэх.	гэсэн төсөлд
21	Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг			Тус хэсгийг бүхэлд нь хасах	Хөрөнгө шалгах ажиллагааны явцад дээд шатны прокурорыг; шийдвэртэй холбогдуулан дээд шатны прокурорын газарт гомдол гаргах эрхийг хуульчилснаар мөрдөн шалгах ажиллагаа удаашрах нөхцөл байдал үүснэ. Төсөлд зааснаар хууль бус хөрөнгийг шалгах нийт хугацаа 3 жилээс хэтрэхгүй байхаар буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хугацаанаас харьцангуй бага байхаар заасан нөхцөл байдалтай холбогдуулан төслөөс тус хэсгийг бүхэлд нь хасах.
22	Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг				Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар хаалттай, хязгаарлалттай мэдээллийн томъёоллыг тусган, өөрчлөн найруулах.
23	Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг			Энэ хэсэгт заасныг хасах	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баримт мэдээллийг нотлох баримтаар тооцох тул хасах нь зүйтэй.
24	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг			Тус хэсгийг бүхэлд нь хасах	"Мөрдөгч, прокурор нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогоос давсан хөрөнгийг гэмт хэргийн замаар олсон эсэхийг

					нотлох үүрэг хүлээхгүй” гэсэн нь хуулийн төслийн 6.2 дугаар зүйлд заасантай зөрчилдөж байх тул хасах.
25	Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь заалтын Б-д			“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан” гэснийг хасах.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн “6.1.Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно.” гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.
26	Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь заалтын “Д”			Яллагдагч сураггүй алга болсон гэснийг хасах	Яллагдагч сураггүй алга болсон үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй гэсэн хуулийн зохицуулалт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд байхгүй тул хасах нь зүйтэй.
27	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг	“... шалгах ажиллагаанд 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна” гэснийг тодорхой болгох			Хууль буцаан хэрэглэх нь эрүүгийн эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрсөн тогтсон ойлголт юм. Төсөлд зааснаар хуулийг буцаан хэрэглэх тохиолдолд дэлгэрэнгүй, нарийвчилсан, хугацааны талаарх үндэслэлийг тусгасан зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай.
	Хуулийн төслийн 29 дүгээр	“Хөрөнгийн үнэлгээг тухайн үеийн инфляцтай уялдуулан тооцно” гэснийг “Хөрөнгийн үнэлгээг			Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөрөнгийн үнэлгээний тухай

28	зүйлийн 29.2 дахь хэсэг	Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тооцно” гэж өөрчлөх		хуулийн зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай. Мөн тус заалт нь “Шалгах ажиллагааны хамрах хугацаа” хэсэгт хамааралгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1.2-д заасан шаардлагад нийцүүлж тусгах шаардлагатай.
29	Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.4 дүгээр хэсэг		“...прокурор” ...гэсний дараа “шүүхийн” гэснийг хасах	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “шүүх нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийн хураан авах нөхөн төлүүлэх ажиллагааг хянан шийдвэрлэхдээ энэ хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан явуулна” гэж заасантай нийцүүлэх.
30	Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг		“...цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй...” гэснийг хасах	Хэрхэн ойлгож хэрэглэх нь тодорхой бус байх тул хасах.
31	Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт	“... маягтыг” гэснийг “эрх зүйн хэлбэрийн загварыг” гэж өөрчлөх		Шалгах ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхээс үйлдэгдэх эрх зүйн хэлбэр гэж тодорхойлох нь хуульд нийцнэ.
32	Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт	“... Хөрөнгө шалгах алба..” эсхүл “...нэгж” гэж өөрчлөн нэг мөр болгох.		Хуулийн төсөлд шалгах нэгж, алба гэж нэг ойлголтыг хэд хэдэн байдлаар томьёолсон байх тул өөрчлөлт оруулах
33	Хуулийн төслийн 51 дүгээр зүйл	Өөрчлөн найруулах		Хөрөнгө шалгах ажиллагааны шийдвэр хэсэгт хөрөнгө тусгаарлах, нэгтгэх зэрэг

				зохицуулалтыг оруулсан боловч үндэслэл тодорхойгүй байх тул тодорхой болгох шаардлагатай.
34	Хуулийн төслийн 52 дугаар зүйл	Өөрчлөн найруулах		Хууль бус хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, холбогдогч нь хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ уялбаршуулсан журмаар шалгах ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болно гэж заасан байх боловч прокурорт хүсэлт гаргах талаар тодорхой тусгаагүй байна.
35	Хуулийн төслийн 53 дугаар зүйлийн 53.4 дүгээр зүйл		"...дээд шатны прокурор танилцана." гэснийг хасах	Прокурорын тухай хуульд заасан прокурорын үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим буюу хараат бус байх зарчимд нийцэхгүй тул төслөөс бүхэлд нь хасах нь зүйтэй байна.



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.12.25 № 01/21180
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ
ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хууль”, “Түр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль”-ийн төсөл, Авлигын эсрэг хууль болон хологдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн танилцуулга, үзэл баримтлалыг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр ирүүлснийг хүлээн авч, танилцлаа.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал нь үндэслэл муутай, бодитой, шинжлэх ухаанч байх зарчимд нийцээгүй, бие даасан хараат бус байгууллагын бүрэн эрхэд халдсан, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөхүйц, хуулийн үр дагаврын судалгаа нь шаардлага хангаагүй, хуулийн төслүүд нь Төсвийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох бусад хуультай зөрчилдсөн, агуулгын хувьд давхацсан зэрэг учир дутагдалтай гэж үзэхээр байна.

Иймд ирүүлсэн хуулийн төслүүдийг дэмжих боломжгүй, дахин боловсруулах шаардлагатай гэж үзэж байх тул холбогдох саналыг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142403021831

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Нэг. “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал”-ын тухайд:

1.1 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 1-д:

“Монгол Улсад авлигын эсрэг чиглэсэн дараах гол хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.Үүнд:

- Авлигын эсрэг хууль (2006 он);
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он);
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013 он);
- Эрүүгийн хууль (2015 он);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он).

Эдгээр хуулиуд нь авлигатай тэмцэх гол арга хэрэгсэл болох боловч бодит үр дүн гаргах тал дээр хүндрэлтэй байгааг олон улсын судалгаанууд илэрхийлдэг. Тухайлбал, Монгол Улс “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын 2023 оны Авлигын төсөөллийн индексээр манай улс 180 улсаас 2018 онд 93, 2019 онд 106, 2020 онд 111, 2021 онд 110-т эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 6 байраар ухарч 116-д, 2023 онд өмнөх оны эрэмбээс 5 байраар ухарч 121-д эрэмбэлэгдсэн муу үзүүлэлттэй байна.

Манай улс 2006 онд шинэчлэн батлагдсан Авлигын эсрэг хуулиараа анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газрыг байгуулж, 2007 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг нь явуулж эхэлсэн. Түүнээс хойш 17 жил өнгөрсөн хэдий ч манай улсын авлигын индекс жил ирэх тусам буурсаар байна...” гэжээ.

Тайлбар: Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас гаргадаг авлигын индексийн үнэлгээнд ялангуяа Монгол Улсын авлигын индексийн үнэлгээ “муу үзүүлэлттэй” гаргахад дээр дурьдсан хуулиудын хэрэгжилт нөлөөлж байгаа мэтээр дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI)¹ нь шинжилгээгээр мэргэшсэн 12 байгууллагын гаргасан 13 мэдээллийн эх сурвалжийг нэгтгэсэн нийлмэл индекс юм. Улс орнуудын үндсэн мэдээллийн хүртээмж өөр өөр байдаг учраас ашигласан эх сурвалжуудын тоо улс орон бүрд өөр өөр байдаг.

Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI) нь

- авлигын бодит тохиолдлыг хэмждэггүй.
- институцийн бүтцийг үнэлж дүгнэдэггүй.

¹ <https://knowledgehub.transparency.org/helpdesk/how-to-guide-for-corruption-assessment-tools-3rd-edition>

- авлигын янз бүрийн төрлийг ялгаж салгадаггүй бөгөөд зөвхөн олон нийтийн секторын авлигад анхаарлаа хандуулдаг.
- Хууль бус санхүүгийн эргэлт, мөнгө угаах болон хувийн секторын авлигын тухай мэдээллийг агуулдаггүй.
- Авлигын талаарх хүмүүсийн ойлголтын үнэлгээ нь улс орон дахь авлигын бодит түвшинг заавал тусгадаггүй болно.
- Тухайн улсын Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаа, үр нөлөөг хэмжихгүй.

Авлигын төсөөллийн индекс (Corruption perceptions CPI) нь авлигыг зөвхөн макро түвшинд хэмждэг бөгөөд хэмжүүр нь нарийн төвөгтэй, өөрчлөгдөхөд удаан байдаг учраас авлигын эсрэг тодорхой шинэчлэлийн богино хугацааны үр дүнг үнэлэхийн тулд CPI-г ашиглах нь зохимжгүй байдаг.

Дээр дурьдсанаас үзэхэд Авлигын төсөөллийн индексээр үзэлд баримтлалд нэрлэн заасан хуулийн "...хэрэгжилт авлигатай тэмцэхэд бодит үр дүн гаргахад хүндрэлтэй байгаа тухай...", мөн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр авлигын индекс буурч байгаа тухайн дүгнэлт хийх нь үндэслэлгүй юм.

Иймд "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн үзэл баримтлал"-ын "Практик үндэслэл, шаардлага"-ыг үнэн зөв, үндэслэлтэйгээр тодорхойлох шаардлагатай байна.

1.2 Үзэл баримтлалын "1.2. Практик үндэслэл, шаардлага" хэсгийн 2-т:

"Хуулийн хэрэгжилт, хариуцлагын бодлого сул, тодорхой бус, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх процесс удаашралтай, үр дүнгүй, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сул байна." гээд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг "2017-2023" оноор, хохирол нөхөн төлүүлэлтийг "2013-2017" оноор, Аудитын байгууллагын мэдээллийг "2020-2024" оноор гэх мэтээр харилцан адилгүй хугацааг хамааруулан судалгаа мэдээллийг гаргажээ.

Тайлбар: Ийнхүү адил бус цаг хугацааны мэдээллийг харьцуулан шинжлэх ухааны үндэслэлгүй, бодитой бус мэдээллийг хуулийн үзэл баримтлалд дурдан үндэслэж байгаа нь ойлгомжгүй төдийгүй хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход учир дутагдалтай байна.

Авлигатай тэмцэх газраас 2007-2023 онд гэмт хэргийн улмаас учирсан 2 их наяд 804 тэрбум 194 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг царцаах, буцаах зорилгоор гадаад улс орнуудтай идэвхтэй хамтран ажилласнаар 2021-2023 онд гадаад улс орнуудаас 13.9 сая ам. долларын хөрөнгийг буцаан авч, улсын орлого болгосон.

2022 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II (Урьдчилан сэргийлэх), V (Хөрөнгө буцаах) бүлгийн хэрэгжилтийг үнэлсэн олон улсын шинжээчдийн багийн зүгээс манай улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, ялангуяа хөрөнгө буцаах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа бусад улс оронд туршлага болохуйц жишиг болж байна хэмээн дүгнэсэн.

Иймд "Дээрх тоон мэдээллээс үзвэл гэмт хэрэг үйлдэж олсон буюу шударга бус аргаар олж авсан хөрөнгийг хураан авах бодлого өнгөрсөн жилүүдэд хэрэгжээгүй, өөрөөр хэлбэл гэмт этгээдүүд болон хууль бусаар хөрөнгөжсөн этгээдүүд өдийг хүртэл хууль бусаар олсон хөрөнгөө эзэмшиж, түүнийхээ үр шим ашгийг хүртэж байгаа гэж дүгнэхээр байна." гэсэн нь үндэслэлгүй дүгнэлт байх тул шинжлэн ухааны үндэслэлтэй, бодитой байх зарчимд тулгуурлах шаардлагатай байна.

1.3 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 9-д:

“Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь авлигатай үр дүнтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүй Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэлтэй байна. Иймд авлигын гэмт хэрэгт, тодруулбал цагдаагийн байгууллага өөрсдөө илрүүлсэн, эсхүл орон нутагт гарсан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүчин чадлыг ашиглан явуулахаар хуульчлах нь зүйтэй байна.”

“Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах харьяаллыг нэмэгдүүлж, мөрдөн шалгах байгууллагад Цагдаагийн байгууллагыг нэмж тусгана. Ингэснээр Цагдаагийн байгууллага Авлигатай тэмцэх газрын ачааллаас хуваалцаж, авлигын эсрэг хүч нэмэгдэх юм.” гэжээ.

Тайлбар: Авлигын эсрэг хуулиар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар Авлигатай тэмцэх газар нь ...авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах... чиг үүрэг бүхий хараат бусаар бие даан хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогоо “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгээр тодорхойлж, “Авлигагүй засаглал” буюу “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх Нэгдүгээр үе шат /2020-2030/-нд “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг буурсан байна” гэх үр дүнд хүрэхээр,

Монгол Улсын Их хурлаас 2023-2030 онд хэрэгжих “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрт Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна, Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ зэргээр авлигатай тэмцэх бодлогоо тодорхойлсон.

Авлигатай тэмцэх газрын МШХ-ийн мөрдөгч орон нутагт байнга суурьшин Авлигын эсрэг хуульд заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Гэтэл Ялангуяа орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүйгээс Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэлтэй байгаа тухай үзэл баримтлалд дурьдсан байх ба “орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэл...”-ийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй, таамагласан байдлаар тусгажээ.

Нөгөө талаар УИХ-аас 2025 оны төсвийг хэлэлцэх явцад Цагдаагийн ерөнхий газрын дарга "...Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор бол цагдаагийн байгууллага 6096 орон тоо дутуу байгаа. Ирэх онд 863 орон тоогоо нэмүүлье гэсэн юм. Дутуу орон тоог задалбал хэсгийн төлөөлөгч 344, эрүүгийн төлөөлөгч 183, хэсгийн байцаагч 226, хүүхдийн байцаагч 234, хэв журмын эргүүл 1422, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч 2588 дутуу байгаа. Энэ тоо бол Засгийн газрын тогтоолд заасан 4000 хүн дутам нэг хэсгийн байцаагч, 50 мянган тутамд нэг хэлтэс байна гэдэг тогтоолоор..." гэжээ.

Гэтэл Авлигын эсрэг хуулиар тогтоосон Авлигатай тэмцэх газрын чиг үүргийг цагдаагийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төсөлд тусгасан нь төрөөс баримтлах төрийн бодлоготой зөрчилдөхийн зэрэгцээ, нэгэнт маш олон орон тооны дутагдалтай байгаа цагдаагийн байгууллагаар гүйцэтгүүлэх нь оновчгүй зохицуулалт төдийгүй, авлигын гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах зарчим тодорхой хэмжээгээр алдагдаж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувь буурах, үр дүнгүй болох сөрөг үр дагавартай гэж үзэж байна.

Авлигатай үр дүнтэй тэмцэх нь зөвхөн Авлигатай тэмцэх газрын үүрэг бус улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, төрөөс авлигын эсрэг үр дүнтэйгээр тэмцэж, шударга байдлыг төрийн салбарт хэвшүүлж байгаа байдал, хүнд суртал, ил тод байдал, төрийн албан хаагчдын шударга томилгоо, авлигыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль зүйн орчин, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, бизнес, улс төрийн бүлэглэлүүдийн далд ашиг сонирхол, улс төрийн санхүүжилт, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд оногдох хэмжээний өсөлт зэрэг нийгэм, эдийн засаг, эрх зүйн олон хүчин зүйлээс хамааралтай.

Үзэл баримтлалд “Авлигатай тэмцэх газар нь улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь сөргөөр нөлөөлж байна.” гэж дүгнэж байгаа нь үндэслэлгүй юм.

Иймд таамаглах төдийгөөр “Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь авлигатай үр дүнтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлж байна.” гэж ноцтой дүгнэлт хийж, Авлигын эсрэг хуульд заасан чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхээр үзэл баримтлалаа тодорхойлж, зохицуулалтыг холбогдох хуульд тусгахаар төсөл боловсруулсан нь үндэслэлгүй, зохимжгүй байна.

1.4 Үзэл баримтлалын “1.2. Практик үндэслэл, шаардлага” хэсгийн 9-д:

“Дээр дурдсан байдлаас дүгнэвэл авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй байдал... нь цаашид авлигын гэмт хэргийг улам даамжруулах, хяналтаас гаргах өндөр эрсдэлтэй байна.” гэжээ.

“13. Авлигын гэмт хэргийн улмаас үүсэн бий болдог дагавар гэмт хэрэг буюу мөнгө угаах, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн шинж хийдэлгүй, тодорхой болно.

Авлигын гэмт хэрэг нь нотлогдоогүй хэдий ч нийтийн албан тушаалтан болон түүний “төлөөний хүн” хууль ёсны өөрийн орлогоосоо их хэмжээгээр давсан хөрөнгө, орлогыг хууль ёсоор олсон гэдгээ тайлбарлаж, нотолж чадаагүй тохиолдолд үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзэж Эрүүгийн хариуцлага ногдуулах нь авлигын гэмт хэргийн эсрэг бас нэг томоохон бодлого болох юм.

Тайлбар: Үзэл баримтлалд хууль батлах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байгаа, мөн эдгээр гэмт хэргийн шинжийг хуулийн төслүүдэд тусгаагүй хирнээ “авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлно., 13. Авлигын гэмт хэргийн улмаас үүсэн бий болдог дагавар гэмт хэрэг буюу мөнгө угаах, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн шинж хийдэлгүй, тодорхой болно.” гэх мэтээр ямар нэг судалгаа, үндэслэлгүйгээр дээрх байдлаар дүгнэсэн нь ойлгомжгүй, агуулгын зөрөөтэй, учир дутагдалтай байна.

1.5 Үзэл баримтлалд хамаарах бусад асуудлын тухайд: хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, битүүмжлэх, хадгалах, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх асуудал нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, түүнийг дагаж гарсан эрх зүйн актаар бүрэн зохицуулагдсаныг үгүйсгэсэн, огт зохицуулалтгүй байгаа асуудлыг шийдвэрлэж байгаа мэтээр тодорхойлжээ.

Эрүүгийн эрх зүйн харилцаанд “хамжигч”, “зуучлагч”-аас гадна “төлөөний хүн” гэх нэр томъёог оруулж ирж байгааг тайлбарлаагүй, энэ нь энэ төрлийн гэмт хэргийн субъект болгож авлига, албан тушаалын гэмт хэргээр шийтгэх нь мөн ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Хоёр: Хуулийн төслийн танилцуулгын тухайд:

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн талаар танилцуулгад “Хуулийн төслийг боловсруулах явцад Авлигын эсрэг хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр, зарим шаардлагатай судалгааг судлаач болон судалгааны зарим байгууллагаар хийлгэлээ.” гэжээ.

Тайлбар: Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс маш богино хугацаанд хийсэн “Авлигын эсрэг хуулийн зарим зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,...-ийн зарим зүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-ний судалгааны тайлангуудтай танилцан х саналыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Өөрөөр хэлбэл, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нь зохих шаардлага хангахгүй, учир дутагдалтай байх тул судалгааны чанар, тайлангийн боловсруулалтыг сайжруулан, АТҮХ, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зохион байгуулалттай уялдуулан, бүхэлд нь буюу иж бүрэн байдлаар, үнэлгээний аргачлал, судалгааны арга зүйн зохих шаардлагыг ханган гүйцэтгэх саналаа хүргүүлснийг энд дурдах нь зүйтэй.

Гурав: Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

3.1 Төслийн: 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

“9.1 Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.3 Авлигын талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллагад гаргах бөгөөд авлигын талаарх нотлох баримтыг хамт хүргүүлж болно.” гэжээ.

Санал:

➤ Энэ нь Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий дагнасан байгууллагын эрх зүйн байдлыг дордуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд харьяаллын бус гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэж зохиомол ачаалал үүсгэх, хүн хүч, төсөв зардал нэмэгдэхээс гадна байгууллага хооронд үл ойлголцол үүсэх, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг шилжиж цаг хугацаа ихээр алдах, үзэмжээрээ хандах, хариуцлагын үр нөлөө буурч гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдэд ял завших, хариуцлагаас мултрах үр дагаврыг бий болгох зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

➤ Дээр дурьдсан 2 хэсгийн агуулга нь хоорондоо зөрчилтэй буюу 9.1-д АТГ, 9.3-т цахимаар Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллагад гэж заажээ.

➤ Өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар гэж заасан байна. Амаар гэдэгт “утсаар ярих”, “биечлэн ирэх” үйлдэл, “цахимаар” гэдэгт цахим шуудан ашиглах эсхүл албан ёсны цахим сүлжээнд бичих үйлдэл хамаарна.

Иймд “9.1 Иргэн, хуулийн этгээд авлигын талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг амаар, бичгээр Авлигатай тэмцэх газарт өгч болно.” гэж өөрчлөх;

3.2 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

“9.4 Авлигын талаар мэдээлэл өгсөн этгээд (цаашид “авлигын мэдээлэгч” гэх)-ийг нууцлах бөгөөд авлигын мэдээлэгчийн хувийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр задруулах, бусдад дамжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.” гэжээ.

Санал: Авлигын мэдээлэгч гэж хэнийг хэлэх вэ, Авлигатай тэмцэх газарт хандан өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж байгаа бүх хүнийг хамруулахаар заасан байна.

➤ “...этгээдийг нууцлах” гэснийг дэлгэрүүлэх. Тухайлбал, нэр, утасны дугаар, ажлын газар, гэрийн хаяг зэрэг түүний ямар мэдээллийг нууцлах талаар дэлгэрэнгүй тусгах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, тухайн этгээдийн мэдээлэл төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийн алинд нь хамаарах, хэрхэн нууцлах, нууцлал ямар байх ёстойг тодорхой болгох, Авлигын талаар мэдээлэл өгсөн этгээдийг өөрөө хүссэн тохиолдолд нууцлах байдлаар тусгах. Өөрөөр хэлбэл, “нэрээ нууцалж шүгэл үлээж болох” эрхийг баталгаажуулах нь зүйтэй.

➤ Мэдээлэл өгч байгаа бүх хүнийг бус “Нийтийн ашиг сонирхлын хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн хууль бус үйлдлийг илчилж, энэ тухай өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх, тайлан гаргах, тайлбар өгөх зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөө авлигын талаарх мэдээлэгч” гэх агуулгыг тусгах, “зайлшгүй шаардлагатай мэдээллийг тодруулах” зорилгоор гэрчээр мэдүүлэг авч болох талаар зохицуулах нь зүйтэй.

➤ Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулж шүгэл үлээж болох зохицуулалтыг тусгах.

3.3 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.5 Авлигын мэдээлэгчийг шаардлагатай тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад авна.

Санал: “Авлигын мэдээлэгчийг шаардлагатай тохиолдол” гэсний дор дэлгэрэнгүй тайлбар оруулах шаардлагатай. Тухайлбал, “шаардлагатай тохиолдол” гэдэгт зөвхөн мэдээлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, хамаатан садны амь бие, эрүүл мэндэд эрсдэл учрахыг ойлгох уу? Эсхүл үүнд мэдээлэгч, түүний гэр бүлийн гишүүн, хамаатан садны эрхэлж байгаа ажлын байранд үүссэн гадуурхалт, хөдөлмөрийн таагүй нөхцөл хамаарах уу өөрөөр хэлбэл, хамгаалалтад авах тохиолдлуудыг тодорхой зааж өгөх нь зүйтэй.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд ажлын байрны дарамт, хөдөлмөрийн нөхцөл дордох зэрэг сөрөг нөлөөллөөс гэрч хохирогчийг хамгаалах зохицуулалт байхгүй тул мэдээлэгчийн хамгаалах тухай асуудал тунхгийн шинжтэй болох эрсдэл үүснэ гэж үзэж байна.

3.3 Төслийн 2 дугаар зүйлийн 1/ “9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.6.” ... авсан хууль бус хөрөнгийн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн авлигын мэдээлэгчид олгоно.” гэжээ.

Санал: Үүнд зөвхөн урамшууллын асуудал яригдаж байгаа нь хангалтгүй гэж үзэж байна. Тухайлбал, мэдээлэгчид мэдээлэл өгснөөс болж, төрөл бүрийн дарамт шахалтад орж, эдийн засаг санхүүгээр хохирсон бол түүний хохирлыг барагдуулах асуудал давхар зохицуулагдах ёстой.

Мөн "...үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх" гэж тодорхой тоо заан оруулжээ. Энэ нь албан тушаалтнуудын зүгээс албан үүрэгтэйгээ холбоотойгоор мэдээлэлд ойр байдлаа ашиглаж, холбогдох мэдээллийг гуравдагч этгээдэд өгөх, ашиг хүртэх хэлбэр рүү хууль бус ашиг сонирхлыг нэмэгдүүлэх үр дагавартай зэрэгт анхаарах шаардлагатай.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад энэхүү хэмжээний талаар ямар нэг тооцоо, судалгаа хийгдсэн талаар дурдагдаагүй байгааг анхаарах.

"9.6 ...үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг, хэрэв түүнд мэдээлэл өгсөнтэй холбоотой хохирол учирсан бол тухайн хохирлын хэмжээг тухайн авлигын мэдээлэгчид олгоно." гэж өөрчлөн найруулах;

"9.7 Шүүхийн ерөнхий зөвлөл нь хууль бус хөрөнгө хураан авсан, нөхөн төлүүлсэн, эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ авсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Хөрөнгө эрхлэн удирдах албанд тухай бүр хүргүүлнэ.

9.8 Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 9.7-д заасан шүүхийн шийдвэрийг хүлээн авч, шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс авлигын мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг тооцож, хагас жил тутам Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Ажлын албанд холбогдох шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хүргүүлнэ.

9.9 Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Удирдах зөвлөл нь Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын мэдээлэгчид олгох урамшууллын тооцоог холбогдох шүүхийн шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хянаж, авлигын мэдээлэгчид урамшууллыг олгоно." гэжээ.

Санал: Авлигатай тэмцэх газар шүүхийн шийдвэрийг хүлээн авч, шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс авлигын мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг тооцож олгохоор заасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд тус байгууллагын хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарахааргүй байна.

Мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг мөрдөн шалгах ажиллагааны явцад тооцож, олгох шийдвэрийг гагцхүү шүүх гаргадаг байх нь хууль ёсны бөгөөд аливаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл болно.

Иймд 9.7, 9.8, 9.9 дэх хэсгийг "...шүүх шийдвэрлэж, ШШГ байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангадаг байх..." зохицуулалтыг тусган өөрчлөн найруулах;

Дөрөв. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай, анхдагч хуулийн төслийн тухайд:

➤ Хуулийн төсөл бүхэлдээ хууль бус хөрөнгийг шалгах үндэслэлийг тогтоож, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх, хянан шийдвэрлэх журам, эрх бүхий байгууллагын тогтолцоо,

олон улсын хамтын ажиллагаа болон эдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулна гэжээ.

Энэ бүх үйл ажиллагаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журмаар зохицуулагддаг.

Төсөл нь тухайлсан байгууллагуудын чиг үүргийг давхардуулсан, гажуудуулсан зохицуулалт гэж ойлгогдож байна. Шүүх шүүн таслах, Прокурор хуулийг хэрэгжилтийг хангуулж, шүүхэд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэгтэй байгууллагууд, мөн төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагууд тусгайлсан чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг.

Дээрх байгууллагууд дотор тусгайлсан чиг үүрэг бүхий нэгжийг шинээр төлөвлөж бий болгох нь төрийн байгууллага хооронд чиг үүргийн давхардал, хэрэг зөрчлийн харьяаллын маргаан үүсгэсэн, төрийн байгууллагын тоог нэмэгдүүлсэн, оновчгүй, данхар бүтцийг бий болгож төсөв мөнгийг үргүй зарцуулах үр дагаврыг үүсгэхээр байна.

Мөн гэм буруутай эсэхийг нь шалгаж шийдвэрлэхэд учруулсан хохирол, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг нэгэн адил гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж гэж тодорхойлж, нотлон тогтоох ажиллагааг хийж гүйцэтгэж байхад чиг үүргийг давхардуулан хөндлөнгөөс дахин өөр мөрдөгч тухайлсан асуудлыг мөрдөн шалгах аар байгаа нь нэг төрлийн хэрэгт 2 өөр мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааг явуулах нь ойлгомжгүйн дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт хангагдахгүй нөхцөл үүснэ.

Төслийн зохицуулалтаас харахад хөрөнгө хураах 7-27 дугаар зүйл, хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа 28-51 дүгээр зүйлд зааснаас үзэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “эрүүгийн процесс”-ын журмаар явагдахаар, төслийн 55-57 дугаар зүйлд Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа” иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар явагдахаар заажээ.

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, хууль бус хөрөнгийг шалгах, “үндэслэлгүй хөрөнгө”-ийг буцаан авах ажиллагаа нь 2 өөр процессоор явагдахаар хуульчилсан нь ойлгомжгүй байна.

Иймд холбогдох хуулиуд Эрүүгийн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой байна.

➤ Төслийн зохицуулалтууд нь хоорондоо зөрчилтэй, ойлгомжгүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн холбогдох зүйл, хэсгийг хуулж тавьсан, огт ойлгомжгүй, хэмжигдэхгүй нэр томьёо хэрэглэсэн (эрх бүхий албан тушаалтан, эвлэрлийн гэрээ, төлөөний хүн, мэдэх ёстой байсан, цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгө гэх мэт) зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангахгүй байна. Тухайлбал,

Төслийн 6.2 Нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болохыг энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн шатанд прокурор нотолно.” гэх боловч шүүхээс бусад ямар шатанд хэн нотлох үүрэг хүлээгээд байгаа нь ойлгомжгүй.

Төслийн “7.1 Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь

тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж заасан хирнээ “10.3-т Мөрдөн шалгах ажиллагааны явцад Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.” гэжээ. Гэтэл АТГ, Тагнуулын байгууллагын албан хаагч Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан албадлага хэрэглэх үндэслэлгүй юм.

➤ Хуулийн төслийн 4 дүгээр зүйл: гэмт хэрэг, хөрөнгө, гуравдагч этгээд, хураан авах, нөхөн төлүүлэх, нийтийн албан тушаалтан, хамаарал бүхий этгээд, гэр бүлийн гишүүн гэх мэт бусад хууль тогтоомжоор тодорхойлсон нэр томьёоноос өөрөөр тодорхойлсон нь хууль хэрэглэгчдэд төөрөгдөл, ойлголтын зөрүү үүсгэсэн тодорхойлолт болсон байгааг анхаарч бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай.

➤ Хуулийн үйлчлэх хүрээ, хууль бус хөрөнгө шалгах хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийг тогтоохдоо:

Хуулийн төслийн 3.1 дэх хэсэгт “Энэ хууль нь нийтийн албан тушаалтан холбогдсон, гэмт хэргийн улмаас бий болсон, энэ хуульд заасан хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах үндэслэл байгаа тохиолдолд үйлчилнэ” гээд 7.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ”;

Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт “Энэ хууль нь Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураахад нэгэн адил үйлчилнэ” гээд, 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.2-т заасан ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт /“үндэслэлгүйгээр хөрөнгөжих”. Тайлбар: Албан тушаалтан 6 сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ/-ын дараа “Тайлбар: “Илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй” гэж тухайн хөрөнгө, орлогоо хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж нотлох баримт гаргаж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгсөн хэдий ч тухайн үйл баримт нотлох баримтаар тогтоогдохгүй байхыг ойлгоно” гэж нэмэхээр хуулийн төслийг боловсруулжээ.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд “Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8-т заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураах үйл ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж заасан нь Авлигын эсрэг хуульд заасан авлигын зөрчлийн 2 төрлийг нь /уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан 8 төрлийн зөрчил нь авлигын зөрчилд хамаарна/-ийг мөрдөгч шалгахгаар зохицуулсан байх ба энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “мөрдөгч”-ийн эрх, үүрэг, үйл ажиллагаанд нийцэх эсэхийг тодруулах шаардлагатай.

Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасан авлигын зөрчлийг ХШДШХ, харин Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд заасан Авлигын гэмт хэргүүдийг Мөрдөн шалгах хэлтэс шалгаж байгаа ба Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн 7.2 дахь хэсэгт нь авлигын зөрчил, авлигын гэмт хэргийн аль алиныг мөрдөгч шалгахгаар заасан нь үндэслэлгүй байна.

➤ Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогоогүй нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан шударга ёсны зарчим нь Эрүүгийн хуулийн 1.4.1 дүгээр зүйл “Энэ хуульд заасан гэмт

хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн гэм буруугийн зарчимд нийцэхгүй байх тул өөрчлөх;

➤ Хуулийн төслийн 6.1.9. хууль бус хөрөнгө бий болсон цаг хугацааг нийтийн албан тушаалтны албан тушаалын бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн болон албан тушаалын бүрэн эрх, чиг үүрэг дууссанаас хойшхи 10 жилийн хугацаатай заавал хамтатган авч үзэх гэснийг “6 жил хугацаатай заавал хамтатган авч үзэх” гэж өөрчлөх;

➤ Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт хөрөнгө шалгах ажиллагааны оролцогчдын эрх хэмжээг заахдаа:

Хуулийн төслийн 10.1 дэх хэсэгт “Хөрөнгө шалгах ажиллагааг эрх бүхий мөрдөгч явуулна. Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах мөрдөгч нь дараах эрхтэй” гээд “шалгах ажиллагаа явуулах эрх нээх, прокурорт санал гаргах, зөвшөөрөл авахаар зааснаас бусад тохиолдолд нотлох ажиллагааг бие даан явуулах, шинжээч томилох, прокурорын зөвшөөрлөөр эрх бүхий байгууллагад даалгавар бичиж гүйцэтгүүлэх” гэх зэргээр эрх хэмжээг заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөгчийн эрх хэмжээнээс зарчмын ялгаа бий эсэх, мөн “Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах мөрдөгч”, “Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах хэрэг” гэх зэргээр заасан ойлголтуудад “Хөрөнгө орлогын мэдүүлэг шалгах” ажил ямар хүрээнд хамаарах нь тодорхойгүй байна.

➤ Хуулийн төслийн 9 дүгээр зүйл /Прокурорын бүрэн эрх/-ийн 9.1.2-т “энэ хуульд заасан журмаар ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраар хяналт, дүн шинжилгээ хийлгэх” гэж заасан нь “Хөрөнгө шалгах ажиллагаа”-ны ерөнхий цар хүрээний дотор “Хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” прокурорын зөвшөөрлөөр явагдах гэх мэт эргэлзээтэй ойлголт үүсгэхээр байна.

Тодруулбал, Хуулийн төслийн 6.2-д “нийтийн албан тушаалтан хууль бус хөрөнгөтэй болохыг энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн шатанд прокурор нотолно” гэж заасан нь Авлигын эсрэг хуулийн 13.1, 13.2, 13.3. 13.4. 13.5. 13.6 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.

➤ Хуулийн төслийн 3.2-т “энэ хууль нь Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон орлогыг хураахад нэгэн адил хамаарна” гэж заасан Авлигын эсрэг хуулийн 33.2-д Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох гэж заасныг зөрчсөн буюу Авлигын эсрэг хуульд заасан шүүгчийн бүрэн эрхэд халдсан заалт гэж үзэхээр байна.

➤ Хуулийн төслийн 2.3-т эрүү, иргэний эрх зүйн харилцааг хольж хутгасан, эрүүгийн эрх зүйн харилцаагаар шийдвэрлэгдэх асуудлыг иргэний эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжоор шийдвэрлэх гэж байгаа нь ойлгомжгүй байна

➤ Төслийн “5.4 Нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг эрүүгийн журмаар хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураалгүйгээр шийдвэрлэсэн нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг явуулах үндэслэл болно. “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д “.....гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцож үл болно” гэсэн заасан. Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдоогүй нөхцөлд хөрөнгийг хууль бусаар олсон гэж тооцож хураан авах, хадгалах, захиран зарцуулах асуудлыг төсөлд тусгасан нь хүний хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулаад зогсохгүй, нигилизм үүсэх үр дагаврыг үүсгэж болзошгүй юм.

➤ Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэсэн тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн 22.10 зүйл 1 дэх хэсэгт “хөрөнгө, орлого нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол гэх агуулгад нийцүүлэх.

➤ Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид дараах байдлаар тодорхойлсныг анхаарах.

20 дугаар зүйл. Хууль бусаар хөрөнгөжих

Оролцогч улс бүр хууль бусаар хөрөнгөжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авах асуудлыг үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Тав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

5.1 Төслийн “1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй.”

21⁴.1 Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

21⁴.1.1 авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд 30 хувийг;

21⁴.1.2 мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 50 хувийг;

21⁴.1.3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24-т заасан “Хүүхдийн төлөө сан”-гийн зарим үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 20 хувийг.”

21⁴.3 Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараах 3 үзүүлэлтийн дундаж хувь хэмжээг харгалзан энэ хуулийн 21⁴.1.2-т заасан хувь хэмжээнээс хуваарилан олгоно:

21⁴.3.1 улсын хэмжээнд гарсан нийт гэмт хэрэгт эзэлж байгаа тухайн байгууллагын илрүүлсэн болон таслан зогсоосон гэмт хэргийн хувь хэмжээ;

21⁴.3.2 тухайн байгууллагын илрүүлсэн нийт гэмт хэрэгт шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ;

21⁴.3 гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон шүүхийн шийдвэртэй хэргийн эзлэх хувь хэмжээ.

Энэ санд зөвхөн авлигын гэмт хэргийн улмаас нөхөн төлүүлсэн, хураан авсан хөрөнгийг төвлөрүүлэх үү? Үгүй бол бусад төрлийн гэмт хэргийн мэдээлэгчийг ч нэгэн адил урамшуулах эсэх нь тодорхойгүй байна.

Гэтэл Авлигын эсрэг хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1/-ийн “9.6 Авлигын мэдээлэгчээс өгсөн тухайн мэдээлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар нотлогдож, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд хураан авсан хууль бус хөрөнгийн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн авлигын мэдээлэгчид олгоно.” гэжээ.

5.2 Төслийн 21⁴.3.2 дахь хэсгийг “Тухайн байгууллагын илрүүлсэн нийт гэмт хэрэгт хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолтой гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ” гэж өөрчлөх;

5.3 Төслийн 21⁴.3.3 дахь хэсгийг “гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг

хураан авч улсын орлого болгосон хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолтой хэргийн эзлэх хувь хэмжээ гэж өөрчлөх;

5.4 Төслийн 21⁴.4.1 дэх хэсэгт “хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ, тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шийтгэх тогтоол /Магадлал, тогтоол/-ын тоо мэдээ” гэж өөрчлөх;

5.5 Төслийн 21⁴.4.6-д мөрдөн шалгахад үр бүтээлтэй ажилласан ажилтанд байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр олгоно гэх заалт шаардлагатай эсэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий төрийн тусгай байгууллагын алба хаагч, төрийн тусгай байгууллагад ажилласны нэмэгдлийг цалин дээрээ авч тангараг өргөж ажилладаг. Хэт мөнгөний араас хөөцөлдөх асуудал гарч нөгөө талдаа сөрөг үр дагавар үүсгэх боломжтойг нөгөө талаар өмнөх сангуудын алдаа, оноонд тулгуурлан үйл ажиллагааг нь олон нийтэд нээлттэй байдлаар байлгаж, хяналтын тогтолцоог хөндлөнгийн төлөөллөөр хэрэгжүүлэх, удирдах зөвлөлийг хараат бус байдлаар сонгон шалгаруулж үр дүнг тооцдог байхад анхаарах нь зүйтэй.

5.6 Төсөлд “гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлоготой нийт гэмт хэрэгт эзлэх гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон хөрөнгийн 1-ээс доошгүй хувийг авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд зарцуулна” гэсэн агуулга бүхий заалтыг нэмэх;

5.7 Төслийн 21⁴ дүгээр зүйлийн 21⁴.1, 21⁴.2, 21⁴.3, 21⁴.3, 21⁴.4, 21⁴.12, 21⁴.14, 21⁴.18-д заасан зохицуулалт нь Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан зохицуулалттай давхар буюу ямар ч өөрчлөлтгүйгээр хуулж тавьсан. Өөрөөр хэлбэл, Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн гуравдугаар бүлэгт заасан агуулга бүхэлдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй давхардсан байгааг сайтар нягтлах шаардлагатай.

5.8 Төслийн 21⁴ дүгээр зүйлийн 21⁴.14-т “... хуулийн 25.5-д заасан хяналтын хороо хяналт тавих бөгөөд ...” гэсэн нь Засгийн газрын тусгай сангийн уг зохицуулалттай нийцээгүй. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.2.18-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.”/хуулийн зүйл, хэсэг, заалт ишилсэн хэсэгт “Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сан”-д холбогдох зүйл, хэсэг заалт байхгүй/;

5.9 Төсөлд сангийн эх үүсвэрийн талаарх зохицуулалт тусгагдаагүй зэрэг болно.

Зургаа. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

6.1 Төслийн 21.5-д: Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаа гэмт хэргийн шинжтэй тохиолдолд төлбөрийн акт тогтоох, албан шаардлага үйлдэхгүйгээр аудитыг нэн даруй зогсоож энэ тухай Ерөнхий аудиторт мэдэгдэж, холбогдох материалыг шилжүүлнэ гэж заажээ. Холбогдох материалыг хааш нь шилжүүлэх вэ? Ерөнхий аудитор ямар арга хэмжээг авах, хугацаа зааж өгөх нь зүйтэй. Эсхүл нэн даруй холбогдох хууль хяналтын байгууллагад өгч шалгуулах. Эргээд хүргүүлсэн материалыг хүрээнд ямар арга

хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн талаар эргэх холбоог үүрэг болгосон хэлбэрээр тусгаж өгөх, хэрэгжилтийг тооцож ажиллах шаардлагатай. Ингээгүйгээс албан тушаалтнууд гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгахгүйгээр дарагдуулах, бусдад давуу байдал бий болгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ял завшуулах нөхцөл үүсгэдэг.

6.2 Төслийн 28.1-д: Ерөнхий аудиторыг 9 жилээр томилох гэснийг 6 жилийн хугацаагаар гэж өөрчлөх;

Долоо. Түр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн тухайд:

7.1 Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд уг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулна” гэснийг Удирдах зөвлөлийн нийт бүрэлдэхүүний тоог тодорхой заах.

7.2 Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай, анхдагч хуулийн төслийн 21⁴ дүгээр зүйлийн 21⁴.1, 21⁴.2, 21⁴.3, 21⁴.3, 21⁴.4, 21⁴.12, 21⁴.14, 21⁴.18-д заасан зохицуулалт нь Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан зохицуулалттай давхар буюу ямар ч өөрчлөлтгүйгээр хуулж тавьсан. Өөрөөр хэлбэл, Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн гуравдугаар бүлэгт заасан агуулга бүхэлдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй давхардсан байгааг сайтар нягтлах шаардлагатай.

Найм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлагатай. Үндэслэлийг хуулийн үзэл баримтлалд тодорхой дурьдсан болно.

Ес. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

9.1 Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт хэргээс олсон орлогыг хөрвүүлэх, шилжүүлэх, эзэмших, нуун дарагдуулах үйлдлийг Мөнгө угаах гэмт хэрэг гэж тодорхойлдог. Мөнгө угаах гэмт хэргийг Улс төрд нөлөө бүхий этгээд, нийтийн албан тушаалтан, гэмт бүлэглэл, хуулийн этгээдийг ашиглан (цэвэр хөрөнгө буюу хууль ёсны хөрөнгө, мөнгө орлоготой хольсон mingling), Халхавч компаниуд /корпорацуудыг/ ашиглах, ашиглан үйлдсэн, санхүү, хуулийн нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор үйлдсэн, гадаад улсад хөрөнгө, мөнгө орлогыг шилжүүлэн угаасан бол хүндрүүлэх шаардлагатай.

Өнөөдрийн байдлаар өөрөө мөнгө угаах Self laundering, хүндрүүлэх шинжүүдийг ялган гэмт хэрэгт тооцоогүй, энэхүү шинжүүдийг тодорхойлоогүй байдлаас үүдэн мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хүмүүс ял завших үр дагавар үүсгэж байна. Иймд:

- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол
- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нь өөрчилсөн, шилжүүлсэн нуун далдалсан бол. /Өөрөө угаах/
- албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол

- галт зэвсэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бус эргэлт, Хүн хулгайлах, барьцаалах, бэлгийн мөлжлөг, хүний цус эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэрэг болон эрүүгийн хуулийн 18, 22, 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг угаасан бол
- энэ гэмт хэргийг үндэстэн дамнаж үйлдсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн, гэмт бүлэглэл, улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол гэсэн үйлдлүүдийг тусгах;

9.2 Төслийн 1 дүгээр зүйлийн “3/ 22.14 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хөрөнгө завших” гэмт хэргийг “Авлигын гэмт хэрэг”-ийн бүлэгт оруулахаар тусгасан нь оновчгүй бөгөөд энэхүү гэмт хэрэг нь авлигын гэмт хэргийн шинжилгэ агуулахгүй байна. Иймд тус зүйлийг хасах;

9.3 Төслийн 1 дүгээр зүйлийн “3/ 22.15 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах-Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн “Хорин гуравдугаар бүлэг”, “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-ийн бүлэгт дараахь байдлаар хуульчлагдсаныг хэвээр үлдээх. Саналыг дэмжихгүй.

Арав. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

10.1 Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн анхдагч төсөлд тусгагдсан нэр томъёог энэхүү төсөлд тусгаснаар батлах бол Иргэний хуулийн 497² дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан үндэслэлийг өөрчлөн найруулах шаардлагатай байна.

---000---



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

15150-0007 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Тасганы овоо, Хувьсгалын зам 22,
Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн байр,
Утас: 7000 8045, Факс: (976) 7000 7021,
И-мэйл: contact@judcouncil.mn, Вэбсайт: www.judcouncil.mn

2024.12.19 № 01/2203
танай 2024.11.18 -ны № 1/1868 -т

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Таны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
1/1868 дугаар албан бичгийг хүлээн авч танилцлаа.

Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу Нийтийн
албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах,
нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөлд шүүх,
шүүхийн Тамгын газраас ирүүлсэн саналыг нэгтгэн
хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 3. хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Л.ЭНХБИЛЭГ

2024.12.19

Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төсөлд шүүх, шүүхийн Тамгын газраас ирүүлсэн саналын нэгтгэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын
2024 оны 2 дугаар сарын 19 ны өдрийн
ол. дугаар албан бичгийн хавсралт
/2285

Д/д	Санал өгсөн	Хуулийн төслийн зүйл, заалт, хэсэг	Өгсөн санал	Саналын үндэслэл тайлбар
1.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-5 дахь хэсэг	1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, хөрөнгө, орлого, зэвсэг хэрэгсэл, машин механизм, / уг эд хөрөнгийг захиран зарцуулсан бол үнийг/ заавал хурааж улсын орлогод оруулахаар нэг бүрчлэн заах. 2.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 7.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан заалтууд хэрэглэхэд маш эргэлзээ дагуулан өмгөөлөгч болон гэм буруутай этгээдүүд нь энэ ойлгомжгүй заалт дээр / хуулийн хийдэл дээр/ тоглолт хийж дараа дараагийн шатанд Шүүхийн шийтгэх тогтоол гэм буруутай этгээдэд ашигтай байдлаар тайлбарлаж шүүхүүд өөр өөрөөр хэрэглэж байгаа завхралыг засах. 3.2002 оны Эрүүгийн хуулийн 49 дугаар заалтыг эргүүлэн дахин хийх маш ойлгомжтой хэрэглэхэд ямар ч эргэлзээ төрдөггүй байсан. Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийн хамгаалалтыг	Эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжид хүртэсэн хуульд заасан үндэслэн бий болсон эсэхийг үл харгалзан гэм буруутай эсэхийг тогтоох, ял шийтгэл оногдуулах асуудлыг хөндөхгүйгээр гэмт хэргийн улмаас олсон орлого, хууль бус орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх механизм буюу эрх зүйн тодорхой зохицуулалтыг холбогдох хуульд нэн даруу хийх шаардлагатай байна.

			<p>дариуд нэн хамгаалалтын арга хэмжээ авахыг хатуу заалтаар оруулж, баримтжуулах, хэрэгжих, хариуцлага чангатгах, боловсронгуй болгох.</p> <p>4.Авлига авсан тушаалтан нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих Иргэний хуульд эд хөрөнгийг хураах, улсад хөрөнгө болгохыг нэмэгдэл ялаар заавал оруулах, зүйл хэсэг тус бүрд нь заах.</p> <p>5.Эрүүгийн эрх зүйд авлига, албан тушаал, үндэслэлгүй хөрөнгөжих залилах гэмт хэрэгт гэм буруутай этгээдэд оногдох хөрөнгө гэдэгт ойлголтыг хасах замаар, хөрөнгөө нуун дарагдуулах байдлыг зогсоох.</p> <p>6.Хөрөнгө хураах ялтай гэмт хэргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлыг тусгайлсан зохицуулалттай, хяналт хариуцлагын тогтоолыг боловсронгуй болгох.</p> <p>7. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын шилжсэн бол эд хөрөнгийг үнэлж, хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх, мэдсээр байж авсан бол хэлцлийг хүчингүйд тооцож хураан авах хохирлыг нөхөн төлүүлэх.</p>	
--	--	--	---	--

2.	Булган аймаг дахь шүүхийн Тамгын газар	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх" тухай /Анхдагч хууль/ 12 дугаар зүйл. Холбогдогч	12 дугаар зүйлийн 12.1.5 тайлбар өгөхөөс татгалзах гэснийг хасах.	Учир нь: Тайлбар өгөхөөс татгалзах нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулна. Тайлбар өгөх үүрэгтэй зөрчилдөж байна.
3.	Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн Тамгын газар	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх" тухай /Анхдагч хууль/	"Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх" тухай хуулийн нэрийг "Төрийн албан хаагчийн хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх" тухай хууль гэж өөрчлөх.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4."нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг; Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: эдгээр хуулийн заалтуудад хамаарах субъектүүдээс гадна төрийн бусад албан хаагчид хууль бусаар хөрөнгөжих асуудал гарч байгаа тул бүх төрийн албан хаагчдыг хамруулах шаардлагатай гэж үзэж байна.

--00--



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН
ХОЛБОО

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 46, Гранд Плаза 15 давхар,
РД: 1626124, Утас/Факс: (+976) 7012-6861,
И-мэйл: holboo@ama.org.mn, Вэбсайт: www.ama.org.mn

2024.12.26 № 01/1357
танай 2024.11.18 -ны № 1/1868 -т

Хуулийн төсөлд санал
хүргүүлэх тухай

Нийтийн албан тушаалтнууд хууль бусаар хөрөнгөжихтэй тэмцэх хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулах талаар төрөөс явуулж байгаа бодлого, зорилго, үйл ажиллагааг дэмжиж байна. Эл зорилгод хүрэхийн тулд эрх зүйн оновчтой шийдэл, зөв зохицуулалт шаардлагатай.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн хүрээнд нэмэлт өөрчлөлт орох бусад хуулийн төсөлд холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө болох “өмчлөх эрх”-ийг хязгаарлалт буюу хөрөнгө хураан авах үндэслэл нь зөвхөн гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдсон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байна. Тиймээс хөрөнгө олж авсан үйлдлийг гэмт хэрэг гэж тогтоогоогүй, тухайн үйлдэлдээ гэм буруутайд тооцогдоогүй нөхцөлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хүний хөрөнгийг хураан авах нь Үндсэн хуулийн зөрчил болно.

2. Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийг шалган шийдвэрлэх хүрээнд тухайн албан тушаалтны хөрөнгө хууль бус эсэх нь шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд уг бүлэгт заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-г хэрэглэх үндэслэл, журмыг дэлгэрүүлэн зохицуулах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд тусгасан материаллаг зохицуулалтыг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд дэлгэрүүлэн томъёолох, процессын

зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давхардалгүйгээр тусгах байдлаар шийдвэрлэх саналтай байна.

3. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслөөр эрүүгийн эрх зүйд “төлөөний хүн” гэх шинэ нэр томъёо нэвтрүүлэхээр тусгасан байна. Нийтийн албан тушаалтныг авлигын гэмт хэрэг үйлдэхэд тусалсан, хууль бус хөрөнгө орлогыг өөрийн эзэмшилд байлгасан, нуусан зэргээр оролцсон этгээдийг Эрүүгийн хуулийн Гуравдугаар бүлэгт заасан зохицуулалт буюу гэмт хэрэгт хамтран оролцсон байдлыг шалган тогтоож, хамтран оролцогчийн хувиар хариуцлага хүлээлгэх боломжтой. Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрээс тусад нь “төлөөний хүн” гэх субъектийг шинээр тусгах шаардлагагүй.

4. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, битүүмжлэх, хураан авах, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх зохицуулалт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бий. Гэтэл Түр болон хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төсөл нь давхардсан зохицуулалт бий болгохоор байна. Хөрөнгө түр хураан авах, царцаах асуудал нь тухайн процесс ажиллагааны эцсийн шийдвэр гарахаас өмнө авагддаг арга хэмжээ учраас хөрөнгийн удирдлага буюу эзэмшил, ашиглалтын асуудлыг хөндлөнгийн буюу Хөрөнгө эрхлэн удирдах байгууллагад шилжүүлэн өгөх нь мөн л Үндсэн хуулийн зөрчил болно.

5. Эрүүгийн хуульд Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамааруулж тогтоосон нь нийтлэг жишиг бөгөөд хамгийн оновчтой зохицуулалт юм. Тиймээс гэмт хэргийн төрлөөр хөөн хэлэлцэх хугацааг тоолох үндэслэлгүй байна. Учир нь хөөн хэлэлцэх хугацаа хариуцлагаас чөлөөлөгдөх үр дагаврыг үүсгэдэг учраас хариуцлага/ял/-тайгаа уялдаатай зохицуулагддаг.

6. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо Мөнгө угаах гэмт хэргийн шинжээс ялгах шаардлагатай байна. Жнь: мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээс бусад гэмт хэрэг үйлдэж олсон гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг гэдгийг мэдсээр байж авсан, хадгалсан, борлуулсан гэх мэт.

7. Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс “Нийтийн албан тушаалтан хөрөнгө завших” үйлдлийг тусад нь салган Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт хамааруулахаар төсөлд тусгасан байна. Хөрөнгө завших гэмт хэрэг Авлигын гэмт хэргийн ялгаа нь халдлагад өртөж байгаа объектоороо ялгагддаг. Тухайлбал хөрөнгө завших гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд албан тушаалтан байна уу эсхүл тухайн эд хөрөнгийг итгэмжлэн хариуцаж байгаа нийтийн албан тушаалтан биш этгээд байна уу ялгаагүй тухайн хөрөнгийн эсрэг үйлдэл хийдэг. Харин Авлигын гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь албаны чиг үүргийн эсрэг

үйлдэл хийдэг. Тиймээс хөрөнгө завшиж байгаа албан тушаалтны үйлдлийг Авлигын гэмт хэргийн бүлэгт хамаатуулах шаардлагагүй.

8. Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлд Шүүгчид хууль бусаар нөлөөлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Гэтэл уг гэмт хэргийн хохирогч болох шүүгчийг нөлөөнд автсан талаараа мэдүүлээгүй гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж ял шийтгэхээр зохицуулсан нь логикгүй бөгөөд шүүн таслах ажиллагаанд шүүгч “нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг болсон” дэвшлийг үгүй хийх зохицуулалт болсон байна.

9. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг/ 18, 20, 22, 25, 26, 29 /-ийг тодорхойлж өгсөн нь оновчтой зохицуулалт байна. Үүн дээр нэмээд уг суурь гэмт хэргийг үйлдсэн этгээд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгддэггүй байх зохицуулалтыг оруулж өгөх шаардлагатай байна. Учир нь тухайн суурь гэмт хэргийг үйлдэн хөрөнгө олж авч байгаа этгээдийн санаа зорилго нь тухайн хөрөнгийг ашиглах, хувиргахад чиглэдэг бөгөөд уг зорилгын төлөө хийсэн нэг үйлдэлд нь хоёр өөрт зүйл ангиар давхар шийтгэж болохгүй. Тиймээс мөнгө угаах гэмт хэргийн субъект нь суурь гэмт хэрэг үйлдсэн этгээд биш байхаар зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

10. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн шинжээс “давуу байдал бий болгосон” гэсэн шинжийг нэн яаралтай хасах шаардлагатай байгаа юм. Учир нь “давуу байдал” гэдэгт юу ч хамааруулж эсхүл юу ч хамааруулахгүй байж болохоор байгаа учраас энэ тодорхойгүй байдлаас хамааран олон хүн хэлмэгдэж, олон хүн ял завшиж байна. Гэмт хэргийн шинжийг хэргийг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлно. Гэтэл “давуу байдал” гэсэн ерөнхий шинжийг цааш нь дэлгэрүүлэн тайлбарлахдаа Үндсэн хууль, бусад хууль, дүрэм, журамд заалтыг иш татан тайлбарлаж эдгээр бүх хууль тогтоомжууд бүгдээрээ “эрүүгийн хууль” болчихоод байна.

11. Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд гэсэн шинэ гэмт хэргийг эрүүгийн хуульд тусгах асуудал байж болохгүй. Захиргааны шийдвэр үйл ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шалгаж “эрүүлжүүлдэг” байдал газар авчхаад байгааг багасгахын оронд хувийн эрх зүйн харилцааны асуудлыг нэмж оруулж ирж байгаа нь байж боломгүй үйлдэл юм. Хэрэв энэ үйлдлийг гэмт хэрэг гэж хуульчлах юм бол асар том хэлмэгдүүлэлтийн хаалга нээгдэж хувийн хэвшлийн үйл ажиллагааг хааж боох арга хэрэгсэл болж хувирна.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Л.ДАНЗАННОРОВ



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2025.01.07 № 1 / 59
танай _____ -ны № _____ -т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Танай Авлигын эсрэг багц хуулийн төсөл буюу
Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан
авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл,
түүний үзэл баримтлалд санал авахаар ирүүлсэн баримт
бичигтэй танилцаад холбогдох саналыг хавсралтаар
хүргүүлж байна.

Хавсралт: 1 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000022

Санхүүгийн зохицуулах хорооны 2025
оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
1/ 5.9..... тоот албан бичгийн хавсралт

1.Төслийн 4.1.2-4.1.5-т заасан тодорхойлолтуудын найруулга зарим тохиолдолд ойлгомжгүй, мөн “хууль бус хөрөнгө гэж хууль ... тухайн нөхцөл байдлаас үл хамааран энэ хуульд заасан журмаар хууль ёсны орлогоор олж авах үндэслэлгүй хөрөнгө, түүний иж бүрдэлд хамаарах хөрөнгө, энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу дараа нь олж авсан, түүнчлэн тухайн хөрөнгийг ашигласнаас олсон, бий болсон хөрөнгө, орлогыг” гэж заасан нь хууль буцаан хэрэглэх асуудлыг нэр томъёонд тусгасан байгааг анхаарч өөрчлөн найруулах;

2.Төслийн 4.1.12-т заасан “Нэгдмэл сонирхолтой этгээд”, 4.1.13-т заасан “төрөл садангийн хүн”, 4.1.14-т заасан “гэр бүлийн гишүүн” гэсэн тодорхойлолт зэрэг нь холбогдох бусад хуулиар тодорхойлсон нэр томъёотой давхардсан, зөрчилдсөн байж болзошгүй тул хууль тогтоомжийн нийцлийг хангах;

3.Төслийн 6.1.9-д заасан “бүрэн эрх, чиг үүрэг дууссанаас хойших 10 жилийн хугацаатай хамтатган авч үзнэ” гэж заасантай холбогдуулан хууль зүйн үндэслэл, үр дагаврын талаар үзэл баримтлалд тусгах;

4.Төслийн 6.1.10 дахь заалтын “нөхөн төлбөргүй” гэснийг хасах;

5.Төслийн 15.2-т заасан “шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт” гэдэг нь ямар шаардлага, шалгуурыг хангасан дүгнэлт байх талаар хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тусгах;

6.Төслийн 18 дугаар зүйлд тодорхойлсон “хөрөнгө хураан авах ажиллагаанд оролцогч, бусад оролцогч”-ийн хүрээг нэр томъёоны тодорхойлолтод тусгах;

7.Төслийн 26.2 дахь хэсэгт хадгаламж, зээлийн хоршооны гүйлгээ, хадгаламж, зээлийн, мөн үнэт цаасны болон виртуал хөрөнгийн арилжаатай холбогдох мэдээллүүдийг нэмж тусгах;

8.Төслийн 30.11-д “Баримт нотолгоо болох эд зүйлийг түр хугацаагаар хурааж авч болно.” гэж заасныг хэрэгжүүлэх этгээд тодорхойгүй байгаа тул нэмж тусгах;

9.Хуулийн төсөлд заасан “мэдэж болох байсан”, “мэдээгүй байсан”, мэдэх боломжгүй байсан” зэрэг ойлголтуудын ялгааг нарийвчилж, төсөлд тусгах, бусад хуульд заасан ижил, эсхүл ойролцоо агуулгатай зохицуулалттай нийцүүлэх.

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ХУРААН АВАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР АНХААРАХ АСУУДЛУУД

1.Хөрөнгө шалгах ажиллагааны хамрах хугацаа

Төслийн 29.1-д “Прокурор нь хөрөнгө шалгах ажиллагааны явцад мэдэгдэж буй нөхцөл байдлыг үндэслэн хөрөнгө шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахдаа хөрөнгө шалгах ажиллагаанд 2002 оны 9 сарын 01-ний өдрөөс хойш, тухайн холбогдогч нийтийн албан тушаал эрхэлж байх хугацаанд түүний болон түүний хамаарал бүхий этгээдийн өмчлөлд, эзэмшил, ашиглалтад бий болсон, хууль ёсны орлогоос давсан хөрөнгийг хамруулна.” гэж заасан.

Гэтэл төслөөс харахад хөрөнгө шалгах ажиллагаа нь эрүүгийн процессын шинжтэй харилцаа /хэрэг нээх, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, мэдүүлэг өгөх, хөрөнгө шалгах тодорхой төрлийн ажиллагаа/-нд хамаарахаар боловч шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний процессын журмаар шийдвэрлэгдэхээр байгаа нь салбар эрх зүйн өөрсдийн онцлог, эрх зүйн системчлэлийг алдагдуулах, тухайн салбар эрх зүйд баримтлах зарчмыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар ойлгомжгүй асуудал үүсгэхээр байна.

Тухайлбал хуулийг буцаан хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэж байна.

Эрүүгийн эрх зүйд

- Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.

- Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.

- Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна.

Иргэний эрх зүйд

- Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.

- Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.

- Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.

2. Хөрөнгө шалгах ажиллагааг эхлүүлэх үндэслэл

28.1.2.энэ хуульд заасан хууль бус хөрөнгө байгаа гэж үзэх хангалттай үндэслэл байгаа боловч дараах үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд:

28.1.2.а.Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдсан;

28.1.2.б.Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан;

28.1.2.в.хөөн хэлэлцэх хугацаа дууссан;

28.1.2.г.яллагдагч нас барсан;

28.1.2.д.яллагдагч сураггүй алга болсон, эсхүл оргон зайлсан.

Эрүүгийн хуулийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим буюу гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Хууль ёсны орлогоос давсан хэмжээний хөрөнгийнхөө эх үүсвэрийг нас барсан, оргон зайлсан тохиолдолд тухайн асуудлыг зохицуулж байгаа нь зөрчил үүсгэхээр байна.